



Г МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Лувсангийн ЭНХБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-13-31, Факс: 32-70-16  
E-mail: enkhboldl@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2019.01.18 № 687

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх

тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Л.ЭНХБОЛД

А.СҮХБАТ

О.БАТНАСАН

Х.БОЛОРЧУЛУУН

М.ОЮУНЧИМЭГ

Ш.РАДНААСЭД

Б.ЭНХ-АМГАЛАН

Л.МӨНХБААТАР

000039



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Лувсангийн ЭНХБОЛД**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
 Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
 Утас: 26-13-31, Факс: 32-70-16  
 E-mail: enkhboldi@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2019. 01. 18 № 679

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
 Ц.ЦОЛМОН ТАНАА

Г Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсныг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү. (129-р).

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
 ГИШҮҮН

Л.ЭНХБОЛД

А.СҮХБАТ

О.БАГНСАН

Х.БОЛОРЧУЛУУН

М.ОЮУНЧИМЭГ

Ш.РАДНААСЭД

Б.ЭНХ-АМГАЛАН

700042



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20<sup>18</sup> он 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 197/2751

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Л.ЭНХБОЛД ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал дүгнэлт авахаар ирүүлсэн  
Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын  
2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан  
тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 1.. хуудас.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

013130

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлд:

"ҮII.ХЭЛЭЛЦСЭН нь:

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболдын санаачлан боловсруулсан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболдын санаачлан боловсруулсан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй гэсэн саналыг төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн гуравдугаар зүйлийн 3.5.1.4-т "Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална" гэж заасан;

2. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.3<sup>1</sup>.4 дэх заалтад ус ашиглах эрэмбэлэлд уул уурхай, баяжуулах үйлдвэрийг тусгасан нь төслийн 22 дугаар зүйлийн 22.7<sup>1</sup> дэх хэсэгт "Газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно..." гэж заасантай зөрчилдөж байна;

3. Уул уурхайн салбарын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэж одоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний 22 орчим хувь, экспортын 90 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 74 хувийг тус тус бүрдүүлж байна;

4. Мөн Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор "Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого" батлагдсан ба уг бодлогын 3.6.4-т "Эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усиг аль болох ашиглахгүй байх, гадаргын усиг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усиг дахин ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих" гэж заасны дагуу уул уурхайн үйлдвэрлэлд гадаргын болон саарал усиг ашиглах, ашигласан усиг алдагдал багатай дахин ашиглах технологийг нэвтрүүлж байна;

5. Хууль тогтоомжийн тухай 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх, хуулийн төслийн үр нөлөө болон хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэрэг судалгааны тайланг хавсаргаагүй байна" гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН



Л.ЭНХБОЛД

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУДИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

**1.1. Практик шаардлага**

2012 онд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан боловч газрын доорх усны зохицуулалт гээгдэж, газрын доорх устай холбоотой харилцааг зөв зохистой шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэ нь газрын доорх усны зохисгүй хэрэглээ нэмэгдэхэд хүргэж, Монгол Улсын усны хэрэглээний 80 орчим хувийг, нийт нөөцийн 1.9 хувь болох газрын доорх усаар хангаж байгаа нь экосистемийн тэнцвэргүй байдлыг үүсгэж, ирээдүйд газрын доорх усны хомсдол, эх үүсвэрийн доройтлыг бий болгоно.

Гэвч Монгол Улсад газрын доорх усыг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журам, эрх зүйн баримт бичиг хангалтгүй байна.

Үүний хүрээнд "Усны тухай хууль"-д газрын доорх ус ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулах, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах нь өнөөгийн тулгамдаж буй асуудал болж байна. Түүнчлэн уул уурхай, аж үйлдвэрийн салбар хөгжиж буйтай холбогдуулан энэхүү салбаруудад газрын доорх цэнгэг усны орд ашиглахыг хориглох, орхигдсон цооногийг битүүмжлэх, усны ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтоож иргэдийн үндны усны хэрэглээний давуу эрх бий болгох, гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэх, усны нөөцийн хомсдлын түвшинг тогтоох, хянах эрх зүйн орчинг бүрдүүлэх нийгэм-эдийн засгийн шаардлага бий болж байна.

**1.2.Хууль зүйн үндэслэл**

Усны талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалт, "Ус" үндэсний хөтөлбөр (УИХ-ын 2010 онд 24 дүгээр тогтоол), "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" (УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол), "Төрөөс экологийн талаар баримтлах бодлого" (УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоол), "Ногоон хөгжлийн бодлого" (УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол), "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол), "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр", "Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө" (Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоол) зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан усыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх болон усны хэрэглээг иргэдэд хүртээмжтэй, тогтвортой байдлаар хүргэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд Усны тухай хуульд газрын доорх усны эрх зүйн

нарийвчилсан зохицуулалтын нэмэлт оруулах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлд дараах зохицуулалтуудыг оруулсан. Үүнд:

"28.14. Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглалтын нөөцийн баталгаажуулсан хэмжээ нь зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн хэрэгжүүлэх төслийн үргэлжлэх хугацаа болон ашигтай ажиллах нөхцлийг хангахаар байгаа тохиолдолд ус ашиглах эрхийг бусад аж ахуйн нэгжид давхардуулан олгохгүй.

28.15. Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглах боломжит нөөц нь тухайн хэрэгжүүлэх төслийн усны хэрэгцээг бүрэн хангаж, илүү гарах нөхцөлд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бусад аж ахуйн нэгжийн хэрэгцээнд ашиглуулах бөгөөд усны эрэл, хайгуулын нийт зардлаас зөвхөн тухайн аж ахуйн нэгжид нийлүүлэх усны эрэл, хайгуулын ажилд зарцуулсан зардлыг нөхөн төлүүлж болно.

28.16. Энэ хуулийн 28.14, 28.15 дахь хэсэг нь унд, ахуйн болон байгаль хамгааллын зориулалтаар ашиглах усны харилцаанд хамаarahгүй.

28 дугаар зүйлийн 28.14-т усны нөөцийг өөрийн хөрөнгөөр илрүүлсэн аж ахуйн нэгжид ус ашиглах онцгой эрхийг олгох буюу 28.15-д заасан нөхцөл бүрдээгүй тохиолдолд тухайн нөөцөөс ус ашиглах зөвшөөрлийг бусдад давхардуулан олгохгүй. Харин 28.16-д заасны дагуу ус ашиглах эрхийг давхардуулан олгохгүй заалт нь УНД, АХУЙН болон байгаль хамгааллын зориулалтаар ашиглах тохиолдолд хамаarahгүй байна.

Мөн Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн усны эх үүсвэрээс ашиглаж байгаа бусад ус ашиглагчийн эрхийг төр өөрийн санаачилгаар цуцалж болно" гэж заасан нь Монгол Улс нь хүн амын унд, ахуйн усны хүртээмжийг баталгаажуулах бодлоготой нь хамааралтай юм.

Гэсэн хэдий ч эдгээр заалтууд нь хангалттай хэрэгжиж чадахгүй байна. Ялангуяа уул уурхай, баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа явуулдаг бүсүүдэд удаан хугацаанд нөхөн сэргээгддэг газрын доорх усыг үйлдвэрлэлд шууд ашиглах зөвшөөрөл олгосон байдаг нь тухайн орон нутгийн иргэдийн унд, ахуйн усны хэрэглээний хомсдол үүсэх улмаар ирээдүйд усны нөөцийн түвшин буурах эрсдэлд орох аюул тулгарна.

Энэ нь Усны тухай хуульд хүн амын ундны усыг тэргүүн ээлжинд тавьж байгаа утга агуулга нь хангалттай тодорхой биш, механизм нь дутмаг байгаад оршино. Үүний улмаас орон нутгийн оршин суугчид аж ахуйн нэгжүүдээс хүн амын ундны усан хангамжийн хуваарилалт хийхийг шаардаж чадахгүй, эрүүл мэндээрээ хохирч байна.

Иймд Усны тухай хуульд улсын хөрөнгөөр хайгуул хийж илрүүлсэн бүх усны нөөцөд хамаарах ашиглалт, хэрэглээний дараах эрэмбийг тогтоож өгөх шаардлагатай. Үүнд:

1. Унд, ахуйн хэрэглээ
2. Хөдөө аж ахуй
3. Үйлдвэрлэл
4. Уул уурхай, баяжуулах үйлдвэр
5. Бусад

Энэхүү эрэмбийн дагуу аливаа усны нөөц илэрсэн тохиолдолд тэргүүн ээлжинд ундны ус хангамжинд ашиглах бөгөөд хүн амын ундны ус хангамж бүрэн хангагдсан тохиолдолд дараагийн эрэмбийн усны хэрэглээнд ус ашиглах зөвшөөрөл олгох юм.

Харин аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглах боломжит нөөц нь 28 дугаар зүйлийн дагуу зохицуулагдах боломжийг нь хэвээр үлдээх нь аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой.

Усны нөөцийн хайгуул хийх, газрын хэвлэй ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулахад цооног гаргадаг. Уг цооногууд нь газар доорх усыг бохирдуулдаг томоохон хүчин зүйлүүдийн нэг учраас Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.17-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө” гэж заасан байдаг. Хэрэв аж ахуйн нэгж нь цооногоо битүүмжлэлгүйгээр хаяж явсан бол Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15-ийн 1.6-д “ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасны дагуу хариуцлага хүлээдэг.

Гэтэл орхигдсон цооногийг хаяж явсан аж ахуйн нэгжийг олж тогтоох хүртэл хугацаанд тухайн цооног нь нээлттэй хэвээр байж газар доорх усыг бохирдуулсаар байдаг. Иймд буруутай этгээдийг илрүүлэх хүртэл сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөрөнгөөр битүүмжлэх арга хэмжээг нэн даруй авч газар доорх усыг хамгаалах шаардлагатай. Үүний дараагаар буруутай этгээдээр Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж орон нутгийн төсвийг тэнцвэржүүлэх эрх хэмжээг олгохоор тусгах нь зүйтэй юм.

Түүнчлэн Монголд Улсын хэмжээнд цооног битүүмжлэх нэгдсэн аргачлал байхгүйн улмаас одоог хүртэл аж ахуйн нэгжүүд цооногийг зохих ёсоор битүүмжлэхгүйгээр зөвхөн таглаж орхидог практик тогтсон. Иймд Засгийн газар цооног битүүмжлэх нэгдсэн аргачлалыг батлах нэн тэргүүний шаардлага үүссэн.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7. “Гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна” гэж заасны дагуу энэхүү харилцаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулагдаж байна. Гэсэн хэдий ч Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд цэнгэг усыг ашиглахыг хориглосон заалт, утга санаа байхгүй.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 21 дүгээр зүйл:

“21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм

1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхэлж болно.

2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан.

Энэхүү 21 дүгээр зүйлийн 21.2-т Байгалийн нөөц газарт үйл ажиллагаа явуулахыг хориглосон боловч байгалийн нөөцөөс тэр дундаа газар доорх усыг татаж, өөр газар байршуулах замаар ашиглах боломжтой мэт харагдаж, голын усыг бохирдуулахгүй л бол газар доорх усыг ашиглаж болохоор ойлгогдож байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1:

“Байгалийн нөөц газрыг дараах төрөлд хуваана:

1/ байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар;

2/ ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар;

3/ эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар;

4/ газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар;

5/ мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар” гэж байгалийн нөөц газрын төрлийг заасан.

Гэсэн хэдий ч энэхүү 20 дугаар зүйлд заасан байгалийн нөөц газрын төрлүүдэд 21 дүгээр зүйлд заасан дэглэм нэгэн адил үйлчилж байна. Өөрөөр хэлбэл байгалийн нөөц газрын тухайн төрөлд тохирсон дэглэмийг хуульчлаагүй. Ингэснээр УСНЫ НӨӨЦ-ийг хамгаалалтад авсан хэдий ч (1) үүнд тохирох дэглэм хэрэгжихгүй, (2) тухайн хамгаалалтад авсан газар зүйн байршилд 21.1-т заасан үйл ажиллагааг хориглож болох боловч ус татаж авах боломж нь нээлттэй хэвээр үлдсэн.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасны дагуу Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам (цаашид “Дэглэм мөрдөх журам”)-аар усны сан бүхий газар, усны эх үүсвэрт тогтоох онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг тогтоодог. Энэхүү журамд (1) Онцгой хамгаалалтын бүс, (2) Энгийн хамгаалалтын бүс, (3) Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, (4) Эрүүл ахуйн хориглолтын бүс, болон (5) Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс-үүдийг тус тус тогтоодог байна. Гэсэн хэдий ч энэхүү журмын сул талыг ашиглан цэнгэг усны ордыг уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломж байна.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Усны нөөцийг хомсдох, бохирдооос хамгаалах, үер, усны гамшигаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бус тогтооно” гэж заасан байх бөгөөд Дэглэм мөрдөх журмын 2 дугаар зүйлийн 2.3.-т “Онцгой хамгаалалтын бүсийг дараах байдлаар тогтооно:

2.3.1.гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт түүний эргээс усны хагалбарын хил хүртэлх зайд;

2.3.2.гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж;

2.3.3.нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд;

2.3.4.хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 100 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 50 метрээс доошгүй зайд;

2.3.5.ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд;

2.3.6.үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас 30 метр хүртэлх зайд” гэж заасны дагуу газар доорх усны нөөц болон ундны эх үүсвэрийг онцгой хамгаалалтын бүсэд авч үзэж байна.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-т “онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно” гэж заасан боловч Дэглэм мөрдөх журмын 2 дугаар зүйлийн 2.4.-т “Улс ардын аж ахуйд онц ач холбогдолтой мега төслийн байгууламж барих, үерийн хамгаалалт, тохируулгын далан боомт, үерийн ус хуримтлуулах нөөцлүүр зэрэг усны барилга байгууламж болон зам, гүүр, усан зогсоол, ус, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл Засгийн газар мега төсөл гэж үзэх бүх төслүүдэд энэхүү журам үйлчлэхгүй.

Тэгвэл мега төсөлд уул уурхай хамаарах эсэхийг авч үзье. 2017 онд Монгол банкнаас гаргасан “Мега төсөл: олон улсын туршлага, монгол улсын одоогийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө”-нд “Мега төсөл гэдэг нь том хэмжээний, ажиллагаа ихтэй, нэг тэрбум ам.доллар болон түүнээс дээш санхүүжилттэй, хэрэгжүүлэхэд урт хугацаа ордог, төрийн болон хувийн хэвшлийн аль алины оролцоо шаарддаг, тухайн бүс нутагт хүчтэй нөлөөлдөг төслүүдийг хэлнэ (Flyvbjerg, 2014)” гэж тодорхойлсон. Мөн баримт бичигт “Мега төсөл нь бараа, үйлчилгээний салбар бүрт тархаж байна. Дэд бүтэц, усан хангамж, эрчим хүч, мэдээллийн технологи, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, нийлүүлэлтийн сүлжээ, мэдээллийн систем, стратегийн зорилт бүхий хөтөлбөрийг өөрчлөх, нэгтгэх, нээж илрүүлэх, шинээр бий болгох үйл ажиллагаа, засгийн

газрын үйл ажиллагааны систем, банк, батлан хамгаалах, оюун ухаан, агаар, сансрын судалгаа, шинжлэх ухаан, хотын дахин төлөвлөлт болон томоохон арга хэмжээг хамарч байна" гэж заасан.

Үүнээс үзвэл Засгийн газрын дэмжлэгтэй уул уурхай, боловсруулах үйлдвэрийн төслүүдэд онцгой хамгаалалтын болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бус тогтоох боломжгүй гэсэн үр дүнд хүрч байна. Үүнийг энэ журам хүлээн зөвшөөрсөн байх бөгөөд З дугаар зүйлийн 3.3-т "Эрүүл ахуйн бус тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бусийн дэглэм зөрчигдэж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглоно" гэж заасан байх бөгөөд энэ нь Мега төсөл явагдаж буй усны эх үүсвэрийн хүн амын ундны ус болгож ашиглахгүй гэсэн үг. Өөрөөр хэлбэл цэнгэг усны орд байсан хэдий ч уг орд, түүний эргэн тойрны Эрүүл ахуйн бус гэж үзээгүй тохиолдолд хүн амын усан хангамжид ашиглах боломжгүй болж байгаа юм.

Үүнээс гадна энэхүү Дэглэм мөрдөх журамын 2 дугаар зүйлийн 2.11- "Энгийн хамгаалалтын бусэд стратегийн орд ашиглах асуудлыг тухайн усны сан бүхий газрын усны нөөц, горим, гидрогоеологийн онцлог нөхцөл, ашиглах технологи зэргийг харгалзан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, усны сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн тусгайлан шийдвэрлэнэ" гэж заасны дагуу мөн л энгийн хамгаалалтын бусэд уул уурхайн үйл ажиллагаа явуулах боломжтой болж байгаа юм.

Одоо гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай (цаашид "Хориглох тухай хууль") хуулийг авч үзвэл энэхүү хууль нь З дугаар зүйлийн 3.1.3-т "усны сан бүхий газрын хамгаалалтын бус" гэж Усны тухай хуулийн 31.3-т заасныг" гэж тодорхойлсон. Харин Усны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т "Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөлийг хуулиар тогтооно" гэсэн заалт байх бөгөөд Хориглох тухай хууль болон Усны тухай хуулийн нэр томьёо болон агуулга нь хоорондоо зөрж байна. Ингэснээр Хориглох тухай хууль нь Усны сан бүхий газрын хамгаалалтын бусэд хэрэгжих боломжгүй гэсэн үг юм.

Хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д "Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно" гэж заасан. Дээрх нэр томьёо болон агуулгын зөрүүтэй байдлыг засах бүрэн боломжтой бөгөөд зассан гэж үзвэл: Хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй" гэж заасны дагуу энэ хууль нь Засгийн газрын Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үзсэн бүх ашигт малтмалын үйл ажиллагаанд Хориглох тухай хууль үйлчлэхгүй болж байна. Түүнчлэн Усны сан бүхий газрын хамгаалалтын бусийг Дэглэм мөрдөх журам -ын дагуу тогтоох бөгөөд энэхүү журам нь мега төсөл болон стратегийн ач холбогдолтой уул уурхайд ногоон гэрэл асааж өгч байгааг энэхүү журмын зохицуулалтаас харж болно.

Дээр дурдсанаар "Усны тухай хууль", "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль", "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль" мөн "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын зохицуулалтуудаас үзвэл хүн амын ундны эх үүсвэрээс Мега төслүүд болон Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд тэргүүн ээлжинд тавигдаж байгаа бөгөөд цэнгэг усны ордыг тусгай хамгаалалтанд авсан хэдий ч Засгийн газар тухайн ордыг өөрийн үзэмжээр ашиглаж болох эрх зүйн орчин бүрдсэн байна.

Иймд хүн амын одоогийн болон ирээдүйн усан хангамж, ундны усны нөөцийг хамгаалахын тулд Усны тухай хуульд "цэнгэг усны орд" илэрсэн тохиолдолд, аливаа нэмэлт ажиллагаа явуулахгүйгээр шууд хуулийн дагуу тухайн газарт уул уурхай болон үйлдвэрлэл явуулах, "цэнгэг усны орд"-ыг уул уурхай болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох заалт оруулах мөн хүн амын ундны усан хангамжийг тэргүүн ээлжинд шийдэх талаар зохицуулалт оруулах шаардлагатай.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-ийн дагуу Ус ашиглах хэмжээнээс шалтгаалан ус ашиглах зөвшөөрлийг Сав газрын захиргаа (хоногт 100 шоо метрээс их ус ашиглах), Аймаг, нийслэлийн байгаль орчны алба (хоногт 50-100 шоо метр ус ашиглах) болон сум, дүүргийн Засаг дарга (хоногт 50 шоо метрээс бага ус ашиглах) тус тус олгодог.

Ус ашиглах зөвшөөрөл болон гэрээнд иргэн, аж ахуйн нэгжийн ус ашиглах боломжит нөөц, хэмжээг тогтоодог. Энэхүү хэмжээг Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлд зохицуулсны дагуу усны ордын хайгуул, судалгаанд тулгуурлан Усны нөөцийн зөвлөл тухайн орд бүрээр баталдаг. Энэхүү ус ашиглах боломжит нөөц, хэмжээг тогтоосноор тухайн орд газрыг усны нөөц хомсдохос сэргийлж байгаа юм. Өөрөөр хэлбэл аливаа илэрсэн ордыг ашиглаж дуусгах бус, нөөцийг нь хадгалж үлдэх бодлогыг Монгол Улс баримталдаг.

Ус ашиглагч нь ус ашиглах боломжит нөөц, хэмжээг хэтрүүлэн ашигласнаас усны ордын нөөц хомсддог бөгөөд нөөцийг хомстуулсан тохиолдолд дараах зохицуулалтууд үйлчилдэг:

Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т "усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх" эрхийг сум, дүүргийн Засаг даргад олгосон байна. Гэвч мөн хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу ус ашиглах гэрээг зөвшөөрөл олгогч цуцлах эрхтэй тул Сав газрын захиргаа болон Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нарын байгуулсан ус ашиглах гэрээнд сум, дүүргийн Засаг дарга цуцлах эрхгүй болж байгаа юм. Өөрөөр хэлбэл 13 дугаар зүйл нь сум, дүүргийн Засаг даргын ус ашиглах зөвшөөрөл олгох эрх хэмжээ болох хоногт 50 шоо метрээс бага ус ашиглах зөвшөөрөлд хамааралтай болно.

Сав газрын захиргааны хувьд Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 "ус ашиглах, хаягдал ус зайлцуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлцуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах" эрхтэй юм.

Энэхүү заалтын "шаардлага" гэдэгт ямар шаардлага гэдэг нь ойлгомжгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл усыг ашиглах шаардлагыг ус ашиглагчид тавьж байна уу? Эсхүл ус ашиглахтай холбоотой шаардлагыг тавьж байна уу? Эхний тохиолдолд ус ашиглагч усаа ашиглахгүй байгаа тул Сав газрын захиргаа ашиглахыг шаардаж байна, дараагийн тохиолдлын хувьд ус ашиглалттай холбоотой гэрээ, журам, хуульд заасан үүргээ биелүүлэх шаардлага гэж ойлгох юм. Иймд энэхүү заалтыг тодорхой болгох шаардлагатай.

Нэгэнт нөөц хомсдоод ус ашиглах боломжгүй болсон бол зөвшөөрөл олгогчийг цуцлахаас өмнө тухай ус ашиглагч гэрээг цуцлах хүсэлт гаргаж болох юм. Иймд ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээг ус ашиглагч хэтрүүлэн ашигласан тохиолдолд (Усны тухай хууль, 30 дугаар зүйлийн 30.1.1) Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 "ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй" гэх үндэслэлээр ус ашиглах гэрээг зөвшөөрөл олгогчийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцална гэж заасан.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15-д "2.Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан боловч эдгээр заалтууд нь хангалттай хэрэгжихгүй байна. Үүний улмаас Монгол Улсад ус ашиглагч нь зөвшөөрөл олгогдсон усны ордын нөөцийг дуусган дахин шинэ усны нөөц хайж илрүүлэн шинэ ус ашиглах зөвшөөрөл авдаг практик тогтсон.

Иймд нэгэнтээ ус ашиглах зөвшөөрөл, гэрээ авсан иргэн, аж ахуйн нэгжид шинээр буюу нэмэлтээр усны нөөцийн хайгуул хийх, ус ашиглах зөвшөөрөл авахыг хязгаарлаж нэг иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж буй нэг газарт олон тооны ус ашиглах зөвшөөрөл эзэмших явдлыг хянах шаардлагатай. Иргэн, аж ахуйн нэгжийн ус ашиглах эрхийг хориглох нь шударга ёс, тэгш эрхийн зарчимд нийцэхгүй боловч нөгөө талаас Монгол Улсын иргэдийн одоогийн болон ирээдүйн үндны усны нөөц хомсдох эрсдэлтэй тул хязгаарлалт тавьж тодорхой нөхцөл, болзол, шаардлагыг хуульчлах боломжтой юм.

Жишээ нь, дараах гурван нөхцөлийг тавьж болох юм. Үүнд: 1. Ус ашиглах, зөвшөөрөл, гэрээгүйгээр ус ашигласан эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан зөрчилгүй байх. 2. Ус ашиглагч нь тухайн орд газрын нөөцийг дуусгаагүй байх. 3. Үйл ажиллагаагаа өргөжүүлсэнтэй холбоотойгоор усны ашиглалт нэмэгдэх зайлшгүй шаардлагатай болсон гэх мэт зохицуулалтуудыг оруулах шаардлагатай байна.

Тайлбарлаваас, 1 болон 2 дугаар нөхцөлүүдэд ус ашиглагч өөрийн гэм буруугаас болж усны нөөцөд хохирол учруулж өөрийн үйл ажиллагааг явуулах боломжгүй болсон тул тухайн зөвшөөрөлтэй усны ордыг нөхөн сэргээх үүрэгтэй болгох нь шударга ёсыг тогтоож олон нийтийн эрх ашгийг мөн хамгаалж чадна. З дугаар нөхцөлийн хувьд иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн үйл ажиллагааг өргөтгөсөн тохиолдолд усны хэрэглээ мөн адил нэмэгдэх нь зайлшгүй тул ус ашиглах эрх шинээр авахыг нь хязгаарлах нь Монгол Улсын эдийн засгийн үр өгөөжийг хумъж буй явдал болно. Тийм учраас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлээгүй тохиолдолд бизнесийг дэмжих нь зүй ёсны хэрэг. Иймд эдгээр нөхцөлүүд нь бизнесийн болон олон нийтийн эрх ашгийг тэнцвэржүүлж чадах юм.

Дээрх нөхцөлүүдийг иргэн, аж ахуйн нэгж хангаж чадахгүй бол нэмэлт ус ашиглах зөвшөөрлийг шинээр олгохоос татгалзах хэрэгтэй бөгөөд тухайн нөхцөлийг засварласан тохиолдолд ус ашиглах зөвшөөрлийг шинээр олгох боломжийг нь мөн адил олгох нь зүйтэй.

Үүнээс гадна, хариуцлагатай ус ашиглалтыг хянах гол хүчин зүйл нь хомсдол болон түүний түвшинг зөв тогтоох явдал юм. Монгол Улсад одоог хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөн хомсдлын түвшинг тогтоох аргачлал байхгүй.

Тэгсэн атал усны нөөцийг хомсдуулсан тохиолдолд Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т "усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх" эрхийг сум, дүүргийн Засаг даргад олгосон байх жишээтэй. Хомсдлын түвшинг шинжлэх ухааны аргад үндэслэн, Засгийн газраас баталсан албан ёсны зааварчилгааны үндсэн дээр тогтоосон тохиолдолд ус ашиглагч болон олон нийтийн ашиг сонирхол хамгаалагдаж, ус ашиглагчийн эрх үүрэг тодорхой болж мөн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй, нэгж болон үйлдвэрлэлд хохиролгүйгээр ус ашиглалтын хяналтыг шударгаар хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Иймд Монгол Улсад ус ашиглалт болон усны нөөцийн хомсдлын түвшинг хянах нээлттэй шударга механизмыг бий болгох, усны нөөцийн хавтгайрсан хэрэглээг зогсоохын тулд нэг ус ашиглагчид олон тооны ус ашиглах зөвшөөрөл эзэмшихийг нь хязгаарлах, хомсдлын түвшинг тогтоох аргачлалыг Засгийн газраас батлах эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай байна.

**Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь нэмэлт хэлбэрээр боловсруулагдах ба усны нөөц хамгаалах, хомсдлоос сэргийлэх, хариуцлагатай ашиглалт, хяналтыг сайжруулах, хүн амын унд, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах газрын доорх усны эрх зүйн зохицуулалтыг тусгана:

- 1/ Гадаргын ба газрын доорх усны нөөцөөс хамаарч түүнийг ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтооно.

- 2/ Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан эсхүл хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө учруулсан тохиолдолд ус ашиглах эрхийг хязгаарлах, цуцлах тухай заалт оруулна.
- 3/ Аж ахуй нэгж хаяж, орхисон цооногийг нөхөн битүүмжлэх арга хэмжээ авна.
- 4/ Цэнгэг усны ордыг аж үйлдвэрлэл болон уул уурхайн зориулалтаар ашиглахыг хориглоно. /Үүнд хүнсний үйлдвэрлэл хамаарахгүй болно./
- 5/ Усны хомсдлын түвшинг тогтоох аргачлалыг тогтооно.
- 6/ Ашигт малтмалын тухай хуульд гүний ус гэж орсон ойлголтын зөрүүг засч Усны тухай хуульд заасан газрын доорх ус гэсэн нэр томъёог оруулна.
- 7/ Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бий болгоно.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч дараах зерэг үр дүн гарна гэж тооцоолж байна. Үүнд:

- 1/ Ус ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтоосноор иргэдийн үндны болон ахуйн усны хэрэглээг баталгаажуулна.
- 2/ Цэнгэг усны нөөц ордуудыг хүн амын усан хангамжийн хэтийн хэрэглээнд ашиглах боломж бүрдэнэ.
- 3/ Гадаргын усны сүлжээ байгуулан усыг алсын зайд шилжүүлэх, газрын доорх усны нөөц ордтой хосолмогоор ашиглах эрх зүйн үндэслэл бий болно.
- 4/ Монгол Улсын газрын доорх усны ордын нөөцийн хомсдол болон чанарын доройтлоос сэргийлнэ.
- 5/ Газрын доорх усыг аж үйлдвэр болон уул уурхайн бохирдоос хамгаална.
- 6/ Хариуцлагын тогтолцоог тодорхой болгосноор иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд үүргээ биелүүлэхэд хялбар болж хариуцлагатай ашиглалтын механизм бий болно.
- 7/ Хаягдаж орхигдсон цооногийг аргачлалын дагуу зөв зохистой битүүмжлэх нь газрын доорх усыг бохирдооос сэргийлнэ.
- 8/ Газрын доорх цэнгэг усны ордыг аж үйлдвэрлэл болон уул уурхайн зориулалтаар ашиглах болон зохисгүй хэрэглээг хориглож хязгаарласнаар цөлжилт нэмэгдэх, бэлчээр доройтооос сэргийлж чадна.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төслийг дагалдуулан "Усны тухай хууль"-д нэмэлт оруулах тухай, "Ашигт малтмалын тухай хууль"-д өөрчлөлт оруулах тухай, "Эрүүгийн хууль"-д нэмэлт оруулах тухай, "Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуулийн төслийг зэрэгцүүлэн боловсруулна.

## ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,  
АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ, УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын хэмжээнд газрын доорх усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь байгалийн бус, бүслүүр, ус агуулах чулуулгийн тогтоц, найрлагаас хамаарч өөр өөр байна. Гадаргын усны нөөцийн 70% нь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт нийт нутаг дэвсгэрийн 30% орчим эзлэх талбайд бүрдэнэ.

Манай орны нийт ус ашиглалт, хэрэглээ жилдээ 500 сая.м<sup>3</sup> орчим байгаа ба хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдан жилээс жилд нэмэгдэж байна. Сүүлийн 40 жилийн судалгаагаар Монгол орны усны нийт нөөц олон жилийн дунджаар жилд 608,300.0 сая.м<sup>3</sup> (мөнх цас, мөсөн голын усны нөөц буурснаас 564,800.0 сая.м<sup>3</sup> болсон), үүний 34,600.0 сая.м<sup>3</sup> гол, мөрний, 500,000.0 сая.м<sup>3</sup> нуурын, 62,900.0 сая.м<sup>3</sup> (19,400.0 сая.м<sup>3</sup> болж буурсан) мөнх цас, мөсөн голын, 10.800 сая.м<sup>3</sup> газрын доорх ус байна.

Монгол Улсын усны хэрэглээний 80 орчим хувийг нийт нөөцийн 1.9 хувь болох газрын доорх усаар хангаж байгаа бөгөөд газрын доорх усыг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичиг хангалтгүй байна.

Түүнчлэн “Усны тухай хууль”-д газрын доорх ус ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулах, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах нь өнөөгийн тулгамдаж буй асуудал болсон. Мөн уул уурхай, аж үйлдвэрийн салбар хөгжиж буйтай холбогдуулан энэхүү салбаруудад газрын доорх цэнгэг усны орд ашиглахыг хориглох, орхигдсон цооног битүүмжлэх, усны ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтоож иргэдийн үндны усны хэрэглээний давуу эрх бий болгох, гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэх, усны нөөцийн хомсдлын түвшинг тогтоох, хянах эрх зүйн орчинг бүрдүүлэх нийгэм-эдийн засгийн шаардлага үүссэн.

Иймд Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах болон Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдэд нэмэлт болон өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулж усны нөөц хамгаалах, хомсдлоос сэргийлэх, хариуцлагатай ашиглалт, хяналтыг сайжруулах, хүн амын унд, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор газрын доорх усны эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь хоёр зүйлтэй.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 22.19, 22.20 заалтуудад орхигдсон цооногийг сум дүүргийн Засаг дарга нь улсын төсвийн хөрөнгөөр битүүмжлэх үүрэг хүлээж байгаа нь газар доорх усны бохирдлоос

хамгаалах яарагтай арга хэмжээний нэг хэлбэр юм. Гэхдээ энэ нь буруутай этгээд үүргээс чөлөөлөгдөж буй хэлбэр биш бөгөөд буруутай этгээд тогтоогдсон даруйд улсын төсөвт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг заавал барагдуулж, холбогдох хариуцлагыг хүлээлгэнэ.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 4<sup>1</sup> дүгээр зүйлд ус ашиглах эрхийн эрэмбийг тогтоон өгч үүний тэргүүн ээлжинд Хүн амын унд, ахуйн хэрэглээг оруулж өгсөн нь Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.1-д "Усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.", мөн Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030"-ын Зорилт 2 "Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ." гэх зорилтуудыг хангахад оршино.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.4-д "Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална", УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс экологийн талаар баримтлах бодлогын 3.7.1-д "Монгол орны гадаргын ба газрын доорх усны нөөц нь байгаль болон амьдралын эрүүл орчны шүтэлцээг хангагч үндсэн эх үүсвэр хэмээн үзэж усны нөөц, чанарыг хадгалан гамтай ашиглаж, нөхөн сэргэх, арвижих боломжийг хангах нь төрийн бодлогын зангилаа асуудал мөн" гэж тус заасан нь Монгол Улсын усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, хүн амын ундны ус хангамжийг нэмэгдүүлэх, ус ашиглагчийн хариуцлага, хяналтыг сайжруулах бодлогыг баримталж байна. Үүнтэй холбоотойгоор Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 4<sup>1</sup>.2 дахь заалтыг оруулсан болно.

Өнөөг хүртэл Монгол Улсад усны нөөцийн хомсдол болон түүний түвшинг тогтоох нэгдсэн аргачлал байхгүйн улмаас аж ахуйн нэгжүүдийн усны нөөцийн хавтгайрсан хэрэглээ бий болж үүнд улсаас тохирсон хариуцлага хүлээлгэж чадахгүй байна. Иймд усны хомсдлоос сэргийлэх, оновчтой хариуцлагын механизм бий болгохын тулд Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 10.1.31, 25.7 заалтуудыг тус тус нэмэлтээр оруулсан болно.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь тус тус 1 зүйлтэй.

Ашигт малтмалын тухай хуульд гүний ус гэж орсон ойлголтын зөрүүг засч Усны тухай хуульд заасан газрын доорх ус гэсэн нэр томьёог оруулна. Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бий болгоно.

Эдгээр төслүүдэд ус ашиглагч нь усны нөөцийг хомсдуулсан тохиолдолд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээдэг байхаар тус тус тусгасан болно.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Усны тухай хуульд оруулсан нэмэлтүүдийн үйлчлэх хугацаа болон журмыг тодорхойлсон болно.

## **ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/4<sup>1</sup> дүгээр зүйл:**

##### **“4<sup>1</sup> дүгээр зүйл.Ус ашиглах эрхийн эрэмбэ**

4<sup>1</sup>.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрхийн эрэмбийг дараах байдлаар тогтооно. Эхний эрэмбийн усны хэрэгцээ бүрэн хангагдаагүй тохиолдолд дараагийн эрэмбэд ус хуваарилахгүй болно.

- 4<sup>1</sup>.1.1.Хүн амын унд, ахуй;
- 4<sup>1</sup>.1.2.Хөдөө аж ахуй;
- 4<sup>1</sup>.1.3.Үйлдвэрлэл;
- 4<sup>1</sup>.1.4.Уул уурхай, баяжуулах үйлдвэр;
- 4<sup>1</sup>.1.5.Бусад.

4<sup>1</sup>.2.Газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай болон үйлдвэрийн зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэхүү заалт хүнсний үйлдвэрлэлд хамаарахгүй болно.”

#### **2/10 дугаар зүйлийн 10.1.31 дэх заалт:**

“10.1.31.Усны нөөцийн хомсдол, түүний түвшин, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох аргачлалыг батлах.”

#### **3/22 дугаар зүйлийн 22.19, 22.20 дахь хэсэг:**

“22.19.Орхигдсон цооногийг сум, дүүргийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр битүүмжлэн буруутай этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна.

22.20.Цооног битүүмжлэх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

#### **4/25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг:**

“25.7.Ус ашиглагч нь ус ашиглах боломжит нөөц болон гэрээнд заасан хэмжээг хэтрүүлснээс усны нөөц хомсдсон тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус хомсдуулсны нөхөн төлбөрийг

ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн гурав дахин нэмэгдүүлж тогтооно."

**2 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийн "дээд хязгаарыг" гэсний дараа "ус ашиглах эрхийн эрэмбийг баримтлан" гэж, 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийн "25.2" гэсний дараа ", 25.7" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4.2 дахь заалтын "гүний" гэснийг "газрын доорх" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай  
24.10 дахь зүйл нэмсүгэй:

**“24.10 дугаар зүйл:**

**24.10 дугаар зүйл. Усны нөөцөд хохирол учруулах**

1. Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зөрчсөн, бусад санаатай эсхүл болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас усны нөөцийг хомсдуулсан эсхүл хомсдож болзошгүй нөхцөл байдал бий болгосон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай болон үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах гэрээг шинээр байгуулахгүй, сунгахгүй болно.

**2 дугаар зүйл.**20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн усны сав газар бүрээр гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг ус ашиглах эрхийн эрэмбийг баримтлан тогтооно.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН СУДАЛГАА**

**Улаанбаатар хот 2019 он**

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

**НЭГ. Ерөнхий мэдээлэл**

**ХОЁР. Асуудлын дүн шинжилгээ**

**ГУРАВ. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал**

**ДӨРӨВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, эерэг болон сөрөг тал дээр хийсэн харьцуулалт**

**ТАВ. Сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал**

**ЗУРГАА. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт**

**ДОЛОО. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал**

**НАЙМ. Зөвлөмж**

## **НЭГ. Ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын хэмжээнд газрын доорх усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь байгалийн бус, бүслүүр, ус агуулах чулуулгийн тогтоц, найрлагаас хамаарч өөр өөр байна. Гадаргын усны нөөцийн 70% нь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт нийт нутаг дэвсгэрийн 30% орчим эзлэх талбайд бүрдэнэ. Манай орны нийт ус ашиглалт, хэрэглээ жилдээ 500 сая.м<sup>3</sup> орчим байгаа ба хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдан жилээс жилд нэмэгдэж байна.

Сүүлийн 40 жилийн судалгаагаар Монгол орны усны нийт нөөц олон жилийн дунджаар жилд 608,300.0 сая.м<sup>3</sup> (мөнх цас, мөсөн голын усны нөөц буурснаас 564,800.0 сая.м<sup>3</sup> болсон), үүний 34,600.0 сая.м<sup>3</sup> гол, мөрний, 500,000.0 сая.м<sup>3</sup> нуурын, 62,900.0 сая.м<sup>3</sup> (19,400.0 сая.м<sup>3</sup> болж буурсан) мөнх цас, мөсөн голын, 10.800 сая.м<sup>3</sup> газрын доорх ус байна.

Судлаач доктор Р.Баттөмөрийн 2010 онд нэгтгэсэн мэдээгээр Өмнөговь, Дорнговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын нутаг дэвсгэрт нарийвчилсан хайгуулаар 140.4 мянган м<sup>3</sup>/хоног, урьдчилсан хайгуулаар 343.1 мянган м<sup>3</sup>/хоног, нийтдээ 483.5 мянган м<sup>3</sup>/хоног усны нөөцтэй 53 орд, үүнээс 38 орд буюу 43.2 хувь нь цэнгэг устай..."гэжээ.

Монгол Улсын усны хэрэглээний 80 орчим хувийг нийт нөөцийн 1.9 хувь болох газрын доорх усаар хангаж байгаа бөгөөд газрын доорх усыг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичиг хангалтгүй байна.

### **ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

#### **Мөн чанар, цар хүрээг тогтоох**

Хуулийн төсөл нь нэмэлт оруулах хэлбэрээр боловсруулагдах ба усны нөөц хамгаалах, хомсдлоос сэргийлэх, хариуцлагатай ашиглалт, хяналтыг сайжруулах, хүн амын унд, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах газрын доорх усны эрх зүйн зохицуулалтыг тусгана:

- 1/ Гадаргын ба газрын доорх усны нөөцөөс хамаарч түүнийг ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтооно.
- 2/ Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан эсхүл хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө учруулсан тохиолдолд ус ашиглах эрхийг хязгаарлах, цуцлах тухай заалт оруулна.
- 3/ Аж ахуй нэгж хаяж, орхисон цооногийг нөхөн битүүмжлэх арга хэмжээ авна.
- 4/ Цэнгэг усны ордыг аж үйлдвэрлэл болон уул уурхайн зориулалтаар ашиглахыг хориглоно. /Үүнд хүнсний үйлдвэрлэл хамаarahгүй болно. /
- 5/ Усны хомсдлын түвшинг тогтоох аргачлалыг тогтооно.
- 6/ Ашигт малтмалын тухай хуульд гүний ус гэж орсон ойлголтын зөрүүг засч Усны тухай хуульд заасан газрын доорх ус гэсэн нэр томъёог оруулна.

7/ Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бий болгоно.

### **Хууль зүйн дүн шинжилгээ**

2012 онд батлагдсан Усны тухай хууль нь Монгол Улсын усны харилцааг зохицуулах ерөнхий хууль юм.

"Усны тухай" хуулийн зорилт нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Хуулинд "усны нөөц" гэж Монгол улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг хэлнэ гэж тодорхойлсон.

Гэвч "Усны тухай" хуулинд Газрын доорх цэнгэг усны ордуудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна гэхээс өөрөөр газрын доорх усыг хамгаалах, хомсдоос сэргийлэх талаар тусгагдаагүй байна.

#### **1. Ус ашиглалтын эрэмбэ тогтоох тухай**

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

"28.14.Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглалтын нөөцийн баталгаажуулсан хэмжээ нь зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн хэрэгжүүлэх төслийн үргэлжлэх хугацаа болон ашигтай ажиллах нөхцөлийг хангахаар байгаа тохиолдолд ус ашиглах эрхийг бусад аж ахуйн нэгжид давхардуулан олгохгүй.

28.15.Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглах боломжит нөөц нь тухайн хэрэгжүүлэх төслийн усны хэрэгцээг бүрэн хангаж, илүү гарах нөхцөлд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бусад аж ахуйн нэгжийн хэрэгцээнд ашиглуулах бөгөөд усны эрэл, хайгуулын нийт зардлаас зөвхөн тухайн аж ахуйн нэгжид нийлүүлэх усны эрэл, хайгуулын ажилд зарцуулсан зардлыг нөхөн төлүүлж болно.

28.16.Энэ хуулийн 28.14, 28.15 дахь хэсэг нь унд, ахуйн болон байгаль хамгааллын зориулалтаар ашиглах усны харилцаанд хамаарахгүй."

28 дугаар зүйлийн 28.14-т усны нөөцийг өөрийн хөрөнгөөр илрүүлсэн аж ахуйн нэгжид ус ашиглах онцгой эрхийг олгох буюу 28.15-д заасан нөхцөл бүрдээгүй тохиолдолд тухайн нөөцөөс ус ашиглах зөвшөөрлийг бусдад давхардуулан олгохгүй. Харин 28.16-д заасны дагуу ус ашиглах эрхийг давхардуулан олгохгүй заалт нь унд, ахуйн болон байгаль хамгааллын зориулалтаар ашиглах тохиолдолд хамаарахгүй байна.

Мөн Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн усны эх үүсвэрээс ашиглаж байгаа бусад ус ашиглагчийн эрхийг төр өөрийн санаачилгаар цуцалж болно" гэж заасан нь Монгол Улс нь хүн амын унд, ахуйн усны хүртээмжийг баталгаажуулах бодлоготой нь хамааралтай юм.

Гэсэн хэдий ч эдгээр заалтууд нь хангалттай хэрэгжиж чадахгүй байна. Ялангуяа уул уурхай, баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа явуулдаг бүсүүдэд удаан хугацаанд нөхөн сэргээгддэг газрын доорх усыг үйлдвэрлэлд шууд ашиглах зөвшөөрөл олгосон байдаг нь тухайн орон нутгийн иргэдийн унд, ахуйн усны хэрэглээний хомсдол үүсэх улмаар ирээдүйд усны нөөцийн түвшин буурах эрсдэлд орох аюул тулгарна. Жишээ нь:

Энэ нь Усны тухай хуульд хүн амын ундны усыг тэргүүн ээлжинд тавьж байгаа утга агуулга нь хангалттай тодорхой биш, механизм нь дутмаг байгаад оршино. Үүний улмаас орон нутгийн оршин суугчид аж ахуйн нэгжүүдээс хүн амын ундны усан хангамжийн хуваарилалт хийхийг шаардаж чадахгүй, эрүүл мэндээрээ хохирч байна.

Иймд Усны тухай хуульд улсын хөрөнгөөр хайгуул хийж илрүүлсэн бүх усны нөөцөд хамаарах ашиглалт, хэрэглээний дараах эрэмбийг тогтоож өгөх шаардлагатай. Үүнд:

1. Унд, ахуйн хэрэглээ
2. Хөдөө аж ахуй
3. Үйлдвэрлэл
4. Уул уурхай, баяжуулах үйлдвэр
5. Бусад

Энэхүү эрэмбийн дагуу аливаа усны нөөц илэрсэн тохиолдолд тэргүүн ээлжинд ундны ус хангамжинд ашиглах бөгөөд хүн амын ундны ус хангамж бүрэн хангагдсан тохиолдолд дараагийн эрэмбийн усны хэрэглээнд ус ашиглах зөвшөөрөл олгох юм.

Харин аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглах боломжит нөөц нь 28 дугаар зүйлийн дагуу зохицуулагдах боломжийг нь хэвээр үлдээх нь аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой.

## 2. Орхигдсон болон хаягдсан цооног битүүмжлэх тухай

Усны нөөцийн хайгуул хийх, газрын хэвлэй ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулахад цооног гаргадаг. Уг цооногууд нь газар доорх усыг бохирдуулдаг томоохон хүчин зүйлүүдийн нэг учраас Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.17-д "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө" гэж заасан байдаг. Хэрэв аж ахуйн нэгж нь цооногоо битүүмжлэлгүйгээр хаяж явсан бол Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15-ийн 1.6-д "ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасны дагуу хариуцлага хүлээдэг байна.

Гэтэл орхигдсон цооногийг хаяж явсан аж ахуйн нэгжийг олж тогтоох хүртэл хугацаанд тухайн цооног нь нээлттэй хэвээр байж газар доорх усыг бохирдуулсаар байдаг. Иймд буруутай этгээдийг илрүүлэх хүртэл сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөрөнгөөр битүүмжлэх арга хэмжээг нэн даруй авч

газар доорх усыг хамгаалах шаардлагатай байна. Үүний дараагаар буруутай этгээдээр Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж орон нутгийн төсвийг тэнцвэржүүлэх эрх хэмжээг олгохоор тусгах нь зүйтэй юм.

Түүнчлэн Монгол улсын хэмжээнд цооног битүүмжлэх нэгдсэн аргачлал байхгүйн улмаас одоог хүртэл аж ахуйн нэгжүүд цооногийг зохих ёсоор битүүмжлэхгүйгээр зөвхөн таглаж орхидог практик тогтсон. Иймд Засгийн газар цооног битүүмжлэх нэгдсэн аргачлалыг батлах нь нэн тэргүүний шаардлага үүсээд байна.

### 3. Цэнгэг усны ордыг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалтын дүгнэлт

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7. “Гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна” гэж заасны дагуу энэхүү харилцаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулагддаг. Гэсэн хэдий ч Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль-д цэнгэг усиг ашиглахыг хориглосон заалт, утга санаа байхгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 21 дүгээр зүйл:

“21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм

1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үргилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхэлж болно.
2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усиг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан.

Энэхүү 21 дүгээр зүйлийн 21.2-т Байгалийн нөөц газарт үйл ажиллагаа явуулахыг хориглосон боловч байгалийн нөөцөөс тэр дундаа газар доорх усиг татаж, өөр газар байршуулах замаар ашиглах боломжтой мэт харагдаж байна. Өөрөөр хэлбэл голын усиг бохирдуулахгүй л бол газар доорх усиг ашиглаж болохоор байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1:

“Байгалийн нөөц газрыг дараах төрөлд хуваана:

- 1/ байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар;
- 2/ ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар;
- 3/ эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар;
- 4/ газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар;

5/ мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар” гэж байгалийн нөөц газрын төрлийг заасан байна.

Гэсэн хэдий ч энэхүү 20 дугаар зүйлд заасан байгалийн нөөц газрын төрлүүдэд 21 дүгээр зүйлд заасан дэглэм нэгэн адил үйлчилж байна. Өөрөөр хэлбэл байгалийн нөөц газрын тухайн төрөлд тохирсон дэглэмийг хуульчлаагүй байна. Ингэснээр усны нөөц-ийг хамгаалалтад авсан хэдий ч (1) үүнд тохирох дэглэм хэрэгжихгүй, (2) тухайн хамгаалалтад авсан газар зүйн байршилд 21.1-т заасан үйл ажиллагааг хориглож болох боловч ус татаж авах боломж нь нээлттэй үлдجээ.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасны дагуу Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам (цаашид “Дэглэм мөрдөх журам”)-аар усны сан бүхий газар, усны эх үүсвэрт тогтоох онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг тогтоодог. Энэхүү журманд (1) Онцгой хамгаалалтын бүс, (2) Энгийн хамгаалалтын бүс, (3) Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, (4) Эрүүл ахуйн хориглолтын бүс, болон (5) Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс-үүдийг тус тус тогтоодог. Гэсэн хэдий ч энэхүү журмын сул талыг ашиглан газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломж нээлттэй хэвээр байна.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно” гэж заасан байх бөгөөд Дэглэм мөрдөх журмын 2 дугаар зүйлийн 2.3.-т “Онцгой хамгаалалтын бүсийг дараах байдлаар тогтооно:

2.3.1.гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт түүний эргээс усны хагалбарын хил хүртэлх зайд;

2.3.2.гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргесгэж;

2.3.3.нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнциүү хэмжээний зайд;

2.3.4.хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 100 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 50 метрээс доошгүй зайд;

2.3.5.ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд;

2.3.6.үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас 30 метр хүртэлх зайд” гэж заасны дагуу газар доорх усны нөөц болон ундны эх үүсвэрийг онцгой хамгаалалтын бүсэд авч үзэж байна.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-т “онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно” гэж заасан боловч Дэглэм мөрдөх журмын 2 дугаар

зүйлийн 2.4.-т “Улс ардын аж ахуйд онц ач холбогдолтой мега төслийн байгууламж барих, үерийн хамгаалалт, тохируулгын далан боомт, үерийн ус хуримтлуулах нөөцлүүр зэрэг усны барилга байгууламж болон зам, гүүр, усан зогсоол, ус, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй” гэж заасан. Өөрөөр хэлбэл Засгийн газар мега төсөл гэж үзэх бүх төслүүдэд энэхүү журам үйлчлэхгүй байх нөхцөл бүрдجээ.

Тэгвэл мега төсөлд уул уурхай хамаарах эсэхийг авч үзье. 2017 онд Монгол банкнаас гаргасан “мега төсөл: олон улсын туршлага, монгол улсын одоогийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө”-нд “Мега төсөл гэдэг нь том хэмжээний, ажиллагаа ихтэй, нэг тэрбум ам.доллар болон түүнээс дээш санхүүжилттэй, хэрэгжүүлэхэд урт хугацаа ордог, төрийн болон хувийн хэвшлийн аль алины оролцоо шаарддаг, тухайн бүс нутагт хүчтэй нөлөөлдөг төслүүдийг хэлнэ (Flyvbjerg, 2014)” гэж тодорхойлсон байна. Мөн баримт бичигт “Мега төсөл нь бараа, үйлчилгээний салбар бүрт тархаж байна. Дэд бүтэц, усан хангамж, эрчим хүч, мэдээллийн технологи, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, нийлүүлэлтийн сүлжээ, мэдээллийн систем, стратегийн зорилт бүхий хөтөлбөрийг өөрчлөх, нэгтгэх, нээж илрүүлэх, шинээр бий болгох үйл ажиллагаа, засгийн газрын үйл ажиллагааны систем, банк, батлан хамгаалах, оюун ухаан, агаар, сансрын судалгаа, шинжлэх ухаан, хотын дахин төлөвлөлт болон томоохон арга хэмжээг хамарч байна” гэж заасан.

Үүнээс үзвэл Засгийн газрын дэмжлэгтэй уул уурхай, боловсруулах үйлдвэрийн төслүүдэд онцгой хамгаалалтын болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүс тогтоох боломжгүй гэсэн үр дүнд хүрч байна. Үүнийг энэ журам хүлээн зөвшөөрсөн байх бөгөөд З дугаар зүйлийн 3.3-т “Эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бүсийн дэглэм зөрчигдэж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглоно” гэж заасан байх бөгөөд энэ нь Мега төсөл явагдаж буй усны эх үүсвэрийн хүн амын ундны ус болгож ашиглахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл цэнгэг усны орд байсан хэдий ч уг орд, түүний эргэн тойрны Эрүүл ахуйн бүс гэж үзээгүй тохиолдолд хүн амын усан хангамжид ашиглах боломжгүй болж байгаа юм.

Үүнээс гадна энэхүү Дэглэм мөрдөх журамын 2 дугаар зүйлийн 2.11-“Энгийн хамгаалалтын бүсэд стратегийн орд ашиглах асуудлыг тухайн усны сан бүхий газрын усны нөөц, горим, гидрогеологийн онцлог нөхцөл, ашиглах технологи зэргийг харгалзан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, усны сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн тусгайлан шийдвэрлэнэ” гэж заасны дагуу мөн л энгийн хамгаалалтын бүсэд уул уурхайн үйл ажиллагаа явуулах боломжтой болж байгаа юм.

Одоо Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай (цаашид “Хориглох тухай хууль”) хуулийг авч үзвэл энэхүү хууль нь З дугаар зүйлийн 3.1.3-т “усны сан бүхий газрын хамгаалалтын бүс” гэж Усны тухай хуулийн 31.3-т заасныг” гэж тодорхойлсон байна. Харин Усны тухай

хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т "Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөлийг хуулиар тогтооно" гэсэн заалт байх бөгөөд Хориглох тухай хууль болон Усны тухай хуулийн нэр томьёо болон агуулга нь хоорондоо зөрж байна. Ингэснээр Хориглох тухай хууль нь Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд хэрэгжих боломжгүй гэсэн үг юм.

Хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д "Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно" гэж заасан байна. Дээрх нэр томьёо болон агуулгын зөрүүтэй байдлыг засах бүрэн боломжтой бөгөөд зассан гэж үзвэл: Хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаarahгүй" гэж заасны дагуу энэ хууль нь Засгийн газрын Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үзсэн бүх ашигт малтмалын үйл ажиллагаанд Хориглох тухай хууль үйлчлэхгүй болж байна. Түүнчлэн Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг Дэглэм мөрдөх журам -ын дагуу тогтоох бөгөөд энэхүү журам нь мега төсөл болон стратегийн ач холбогдолтой уул уурхайд ногоон гэрэл асааж өгч байгааг энэхүү журмын зохицуулалтаас харж болно.

Дээрх дурдсанаар "Усны тухай хууль", "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль", "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль" мөн "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын зохицуулалтуудаас үзвэл хүн амын ундны эх үүсвэрээс Мега төслүүд болон Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд тэргүүн ээлжинд тавигдаж байгаа бөгөөд цэнгэг усны ордыг тусгай хамгаалалтад авсан хэдий ч Засгийн газар тухайн ордыг өөрийн үзэмжээр ашиглаж болох эрх зүйн орчин бүрдсэн байна.

Иймд хүн амын одоогийн болон ирээдүйн усан хангамж, ундны усны нөөцийг хамгаалахын тулд Усны тухай хуульд "газрын доорх цэнгэг усны орд" илэрсэн тохиолдолд, аливаа нэмэлт ажиллагаа явуулахгүйгээр шууд хуулийн дагуу тухайн газарт уул уурхай болон үйлдвэрлэл явуулах, "газрын доорх цэнгэг усны орд"-ыг уул уурхай болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох заалт оруулах мөн хүн амын ундны усан хангамжийг тэргүүн ээлжинд шийдэх талаар зохицуулалт оруулах шаардлагатай байна.

#### **4. Ус ашиглах гэрээний хэмжээг хэтрүүлэн ашигласны улмаас үүсэх хомсдол**

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-ийн дагуу Ус ашиглах хэмжээнээс шалтгаалан ус ашиглах зөвшөөрлийг Сав газрын захиргаа (хоногт 100 шоо метрээс их ус ашиглах), Аймаг, нийслэлийн байгаль орчны алба (хоногт 50-100 шоо метр ус ашиглах) болон сум, дүүргийн Засаг дарга (хоногт 50 шоо метрээс бага ус ашиглах) тус тус олгодог байна.

Ус ашиглах зөвшөөрөл болон гэрээнд иргэн, аж ахуйн нэгжийн ус ашиглах боломжит нөөц, хэмжээг тогтоодог. Энэхүү хэмжээг Усны тухай хуулийн 4 дүгээр

зүйлд зохицуулсны дагуу усны ордын хайгуул, судалгаанд тулгуурлан Усны нөөцийн зөвлөл тухайн орд бүрээр баталдаг. Энэхүү ус ашиглах боломжит нөөц, хэмжээг тогтоосноор тухайн орд газрыг усны нөөц хомсдооос сэргийлж байгаа юм. Өөрөөр хэлбэл аливаа илэрсэн ордыг ашиглаж дуусгах бус, нөөцийг нь хадгалж үлдэх бодлогыг Монгол Улс баримталдаг юм.

Ус ашиглагч нь ус ашиглах боломжит нөөц, хэмжээг хэтрүүлэн ашигласнаас усны ордын нөөц хомсддог бөгөөд нөөцийг хомсдуулсан тохиолдолд дараах зохицуулалтууд үйлчилдэг байна:

Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “Усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх” эрхийг сум, дүүргийн Засаг даргад олгосон. Гэвч мөн хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу ус ашиглах гэрээг зөвшөөрөл олгогч цуцлах эрхтэй тул Сав газрын захиргаа болон Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нарын байгуулсан ус ашиглах гэрээнд сум, дүүргийн Засаг дарга цуцлах эрхгүй болж байгаа юм. Өөрөөр хэлбэл 13 дугаар зүйл нь сум, дүүргийн Засаг даргын ус ашиглах зөвшөөрөл олгох эрх хэмжээ болох хоногт 50 шоо метрээс бага ус ашиглах зөвшөөрөлд хамааралтай болно.

Сав газрын захиргааны хувьд Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 “ус ашиглах, хаягдал ус зайлцуулах шаардлагыг зэрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлцуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах” эрхтэй юм.

Энэхүү заалтын “шаардлага” гэдэгт ямар шаардлага гэдэг нь ойлгомжгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл усыг ашиглах шаардлагыг ус ашиглагчид тавьж байна уу? Эсхүл ус ашиглахтай холбоотой шаардлагыг тавьж байна уу? Эхний тохиолдолд ус ашиглагч усаа ашиглахгүй байгаа тул Сав газрын захиргаа ашиглахыг шаардаж байна, дараагийн тохиолдлын хувьд ус ашиглалттай холбоотой гэрээ, журам, хуульд заасан үүргээ биелүүлэх шаардлага гэж ойлгох юм. Иймд энэхүү заалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Нэгэнт нөөц хомсдоод ус ашиглах боломжгүй болсон бол зөвшөөрөл олгогчийг цуцлахаас өмнө тухайн ус ашиглагч гэрээг цуцлах хүсэлт гаргаж болох юм. Иймд ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээг ус ашиглагч хэтрүүлэн ашигласан тохиолдолд (Усны тухай хууль, 30 дугаар зүйлийн 30.1.1) Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 “ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй” гэх үндэслэлээр ус ашиглах гэрээг зөвшөөрөл олгогчийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцална гэж заасан.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15-д “Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,

хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан боловч эдгээр заалтууд нь хангалттай хэрэгжихгүй байна. Үүний улмаас Монгол Улсад ус ашиглагч нь зөвшөөрөл олгогдсон усны ордын нөөцийг дуусган дахин шинэ усны нөөц хайж илрүүлэн шинэ ус ашиглах зөвшөөрөл авдаг практик тогтсон.

Иймд нэгэнтээ ус ашиглах зөвшөөрөл, гэрээ авсан иргэн, аж ахуйн нэгжид шинээр буюу нэмэлтээр усны нөөцийн хайгуул хийх, ус ашиглах зөвшөөрөл авахыг хязгаарлаж нэг иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж буй нэг газарт олон тооны ус ашиглах зөвшөөрөл эзэмших явдлыг хянах шаардлагатай байна. Иргэн, аж ахуйн нэгжийн ус ашиглах эрхийг хориглох нь шударга ёс, тэгш эрхийн зарчимд нийцэхгүй боловч нөгөө талаас Монгол Улсын иргэдийн одоогийн болон ирээдүйн ундны усны нөөц хомсдох эрсдэлтэй тул хязгаарлалт тавьж тодорхой нөхцөл, болзол, шаардлагыг хуульчлах боломжтой юм.

Жишээ нь, дараах гурван нөхцөлийг тавьж болох юм. Үүнд: 1. Ус ашиглах, зөвшөөрөл, гэрээгүйгээр ус ашигласан эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан зөрчилгүй байх. 2. Ус ашиглагч нь тухайн орд газрын нөөцийг дуусгаагүй байх. 3. Үйл ажиллагаагаа өргөжүүлсэнтэй холбоотойгоор усны ашиглалт нэмэгдэх зайлшгүй шаардлагатай болсон гэх мэт зохицуулалтуудыг оруулах шаардлагатай байна.

Тайлбарлаваас, 1 болон 2 дугаар нөхцөлүүдэд ус ашиглагч өөрийн гэм буруугаас болж усны нөөцөд хохирол учруулж өөрийн үйл ажиллагааг явуулах боломжгүй болсон тул тухайн зөвшөөрөлтэй усны ордыг нөхөн сэргээх үүрэгтэй болгох нь шударга ёсыг тогтоож олон нийтийн эрх ашгийг мөн хамгаалж чадах юм. 3 дугаар нөхцөлийн хувьд иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн үйл ажиллагааг өргөтгэсэн тохиолдолд усны хэрэглээ мөн адил нэмэгдэх нь зайлшгүй тул ус ашиглах эрх шинээр авахыг нь хязгаарлах нь Монгол Улсын эдийн засгийн үр өгөөжийг хумьж буй явдал болох юм. Тийм учраас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлээгүй тохиолдолд бизнесийг дэмжих нь зүй ёсны хэрэг. Иймд эдгээр нөхцөлүүд нь бизнесийн болон олон нийтийн эрх ашгийг тэнцвэржүүлж чадах юм.

Дээрх нөхцөлүүдийг иргэн, аж ахуйн нэгж хангаж чадахгүй бол нэмэлт ус ашиглах зөвшөөрлийг шинээр олгохоос татгалзах хэрэгтэй бөгөөд тухайн нөхцөлийг засварласан тохиолдолд ус ашиглах зөвшөөрлийг шинээр олгох боломжийг нь мөн адил олгох нь зүйтэй юм.

Үүнээс гадна, хариуцлагатай ус ашиглалтыг хянах гол хүчин зүйл нь хомсдол болон түүний түвшинг зөв тогтоох явдал юм. Монгол Улсад одоог хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөн хомсдлын түвшинг тогтоох аргачлал байхгүй. Тэгсэн атал усны нөөцийг хомсдуулсан тохиолдолд Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т "Усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх" эрхийг сум, дүүргийн Засаг даргад олгосон байна. Хомсдлын түвшинг шинжлэх ухааны аргад үндэслэн, Засгийн газраас баталсан албан ёсны зааварчилгааны үндсэн дээр тогтоосон тохиолдолд ус ашиглагч болон олон нийтийн ашиг сонирхол

хамгаалагдаж, ус ашиглагчийн эрх үүрэг тодорхой болж мөн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй, нэгж болон үйлдвэрлэлд хохиролгүйгээр ус ашиглалтын хяналтыг шударгаар хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Иймд Монгол Улсад ус ашиглалт болон усны нөөцийн хомсдлын түвшинг хянах нээлттэй шударга механизмыг бий болгох, усны нөөцийн хавтгайрсан хэрэглээг зогсоохын тулд нэг ус ашиглагчид олон тооны ус ашиглах зөвшөөрөл эзэмшихийг нь хязгаарлах, хомсдлын түвшинг тогтоох аргачлалыг Засгийн газраас батлах эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай байна.

**Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох**

Холбогдох тайлангаас үзэхэд газрын доорх усны нөөц, газрын доорх усны цэнгэг ордны нөөцийн хавтгайрсан ашиглалт жилээс жилд нэмэгдэж байгаа боловч бодит байдалд түүнийг хамгаалах, зүй зохистой ашиглах, хянах, хомсдлыг тогтоох асуудал тодорхой бус, ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн хариуцлага суларч, уул уурхай, үйлдвэрлэл төдийгүй хаягdsan цооногоос шалтгаалан газар доорх усны бохирдол, хомсдол ихсэж бүлгийн эрх ашигт сергэөр нелөөлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нелөөлж буй хэлбэр
1	Нийт иргэд	Усны нөөц, тэр дундаа цэнгэг усны ордын бохирдол, хомсдол, зүй бус ашиглалтаас үүсэх хор уршигт нийт иргэд өртөнө. Өөрөөр хэлбэл, улс орны аюулгүй байдал, иргээдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд төдийгүй эдийн засгийн хөгжилд сөрөг нелөөтэй.
2	Орон нутгийн иргэд	Усны нөөц, тэр дундаа цэнгэг усны ордын бохирдол, хомсдолд тухайн орон нутгийн иргэд хамгийн ихээр өртөнө. Энэхүү эрсдэлт байдал нь иргээдийн эрүүл мэнд төдийгүй, амьд явах баталгаа, амьдрах цэвэр орчин, аюулгүй байдал, өрхийн амьжиргаа зэрэгт олон сөрөг үр дагаврыг бий болгоно.
3	Төр	Газар доорх усны нөөц, тэр дундаа цэнгэг усны ордын нөөц хомсдох нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нелөөлж ирээдүйд гадны нелөөлөлд эмзэг болох эрсдэлтэй. Үүнээс гадна газар доорх ус, тэр дундаа цэнгэг усны ордыг хамгаалах, нөхөн сэргээхэд улсын төсвөөс ихээхэн зардал шаардагдахад хургэж байна.

## **Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл**

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1-д “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна.”, 4.2.3-т “Усны нөөцийг хамгаалж, хомсдоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.”, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.1-д “Усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.”, 3.5.1.4-д “Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална”, УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс экологийн талаар баримтлах бодлогын 3.7.1-д “Монгол орны гадаргын ба газрын доорх усны нөөц нь байгаль болон амьдралын эрүүл орчны шүтэлцээг хангагч үндсэн эх үүсвэр хэмээн үзэж усны нөөц, чанарыг хадгалан гамтай ашиглаж, нөхөн сэргэх, арвижих боломжийг хангах нь төрийн бодлогын зангилаа асуудал мөн” гэж тус тус заасан нь Монгол Улсын усны нөөцийг хамгаалах, хомсдоос сэргийлэх, хүн амын ундны ус хангамжийг нэмэгдүүлэх, ус ашиглагчийн хариуцлага, хяналтыг сайжруулах бодлогын баримталж буй заалтууд юм.

Усны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль мөн Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын зохицуулалтуудын дээрх шинжилгээнээс үзвэл мега төсөл болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд нь хүн амын ундны эх үүсвэрээс давуу эрх эдэлж байх бөгөөд газрын доорх цэнгэг усны ордыг тусгай хамгаалалтад авсан ч Засгийн газар тухайн ордыг өөрийн үзэмжээр ашиглаж болох эрх зүйн орчин бүрдсэн.

Үүнээс гадна 2002 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр Говийн бүсийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд “Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээ байгуулах” ажлыг хийж байна. Уг ажлын хүрээнд 2015 онд газрын доорх усны эvdэгдсэн горим, байгалийн горим, бохирдолд өртөж болзошгүй газрын доорх усны ордуудад нийт 99 цэгт хагас автомат, 20 цэгт бүрэн автомат багаж суурилуулаад байгаа боловч газрын доорх усны түвшин багасаж, хомсдож, бохирдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй байна.

Хариуцлагатай ус ашиглалтыг хянах маш том хүчин зүйл нь усны ашиглах боломжит нөөцийг зөв тогтоож, хяналт-шинжилгээний үр дүн, мэдээлэлд боловсруулалт хийж, бохирдол, хомсдлыг бодитой тогтоох явдал юм.

Ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээд усны нөөц нь тогтоогдсон газрын доорх усны орд газарт нэмж усны нөөцийн хайгуул хийхийг хязгаарлаж, газрын доорх усны орд газарт олон тооны ус ашиглах зөвшөөрөл эзэмшиж байгаа тохиолдолд хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүн амын одоогийн болон ирээдүйн усан хангамж, ундны усны нөөцийг хамгаалахын тулд Усны тухай хуульд “цэнгэг усны орд” илэрсэн тохиолдолд, аливаа нэмэлт үйл ажиллагаа явуулахгүйгээр, шууд хуулийн дагуу тухайн газарт уул уурхай болон үйлдвэрлэл явуулах, “цэнгэг усны орд”-ыг уул уурхай болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хязгаарлах, хориглох заалт оруулах мөн хүн амын ундны усан хангамжийг тэргүүн ээлжинд шийдэх талаар зохицуулалт оруулах шаардлагатай.

Түүнчлэн Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.17-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх үүрэгтэй. Гэвч эдгээрийг хэрхэн устгах, булах, эсвэл цаашид сэргээх талаар зохицуулсан дүрэм, журам байхгүй байна. Иймд газрын доорх усыг бохирдоос сэргийлэх зорилгоор ашиглаж дууссан, орхигдож хаягdsан болон хайгуулын цооногуудад геологийн болон гидрогоеологийн нехцелөөс хамааран устгал хийх, буулгах, булах эсвэл дахин сэргээх талаарх аргачилсан заавар, дүрэм, журмыг боловсруулах шаардлагатай.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

### **Асуудлыг шийдвэрлэхэд дараах зорилгыг тодорхойллоо:**

Усны тухай хуульд нэмэлт оруулах замаар газрын доорх ус ашиглалт, хэрэглээний эрэмбийг тогтоож, газрын доорх усыг хомсдлоос хамгаалах, хомсдол тогтоох аргачлал батлах, ус ашиглалт түүнчлэн цооног ашиглалтын хариуцлага, хяналтыг сайжруулах эрх зүйн зохицуулалтыг гүний ус гэсэн нэр томъёоны зөрүүг Усны тухай хуульд заасан газрын доорх ус гэсэн нэр томъёогоор засах, ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бий болгох.

## **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ ДЭЭР ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбаруудын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, зерэг болон сөрөг талыг нь харьцуулья.

“Тэг” хувилбар буюу зохицуулалт хийхээс татгалзах"- Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй, төрөөс тодорхой зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.

"Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх"-тохиромжгүй хувилбар.

"Төрөөс санхүүгийн интервенц хийх"-тохиромжгүй хувилбар.

"Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх" – тохиромжгүй хувилбар.

"Захиргааны шийдвэр гаргах"-Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны акт хэлбэрээр шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн тул сонгох боломжгүй.

"Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх" болон "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн 2 хувилбарыг сонголоо.

Сонгосон хувилбарын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны зерэг, сөрөг талыг харьцуулан судалбал:

Сонгосон хувилбаруудын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны зерэг, сөрөг тал

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1.Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Усны нөөцийг хамгаалах, бохирдлыг бууруулах, үнэгүйдүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааг дэмжих боловч зорилгод бүрэн хүрэхгүй.	Зардал хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай адил гарна. Асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй хувилбар
2.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Усны тухай хуулийн хэрэгжих боломжийг дээшлүүлэх, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах, усны нөөцийг хамгаалж, бохирдол, хомсдоос сэргийлэх.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг шийдвэрлэхэд оновчтой хувилбар.

Хуульд нэмэлт оруулах замаар дараах асуудлуудыг шийдвэрлэх боломжтой тул "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" хувилбарыг сонгов.

## ТАВ. СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн хууль тус бүрээр гаргалаа.

### 5.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

### 5.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
<b>1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй	Хуулийн төслөөр холбогдох этгээдэд тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчлагдсан.
1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Нийтийн ашиг сонирхлын үүднээс тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мэн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Хүний ундны усаар хангагдах эрхийг дэмжсэн болно.
<b>1.2. Оролцоог хангах</b>			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Орон нутгийн иргэд ус ашиглагчаас зохистой хэмжээнд унд, ахуйн хэрэглээний ус хуваарилахыг шаардах эрхтэй болсон.
<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			
1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах,	Тийм		Ус ашиглах, хэрэглэх эрэмбэ тогтоох бөгөөд үүний тэргүүн

	хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх			ээлжинд унд, ахуйн хэрэглээг тогтоосноор хүний усаар хангагдах эрхийг дэмжсэн болно.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Хууль зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэн зохицуулна.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Эрх агууллагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Нутгийн оршин суугч
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү здгээрээр хязгаарлахгүй/			
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Төр, хуулийн этгээд үүрэг хүлээнэ
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Хуулийн төслийн зохицуулалтууд бүхэлдээ жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн.

### 5.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/?		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах уу?		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
2. Дотоодын зах	2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах уу?		Үгүй Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?		Үгүй Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.3 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?		Үгүй	Цэнгэг усны ордын усыг уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн аж ахуйн нэгжүүд цэнгэг усны орд ашиглах эрхгүй болно.
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох уу?		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Цэнгэг усны ордоос уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигладаг аж ахуйн нэгжүүд усны шинэ эх үүсвэр олно.
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	3.4 Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй захиргааны зардлын ачаалал	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг /Жишээ нь, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт/ бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	5.1 Өмчлөх эрхийг /үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө,		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй

5.Өмчлөх эрх	эдийн бус баялаг зэргийг/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх			
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	5.3 Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг зерчсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
6.Инноваци ба судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		Цэнгэг усны ордын хэрэглээг хязгаарласнаар аж ахуйн нэгкүүд шинэ технологи ашиглан усны өөр эх үүсвэрээс бий болгоно
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
7.Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	7.4 Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй

	шинээр бий болгох эсэх			
	8.2 Тодорхой бус нутгуудад тодорхой чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	8.3 Жижиг, дунд үйлдвэрүүд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад онцгой нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Цэнгэг усны ордыг уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт ашиглахгүй болно. Хүнсний үйлдвэрлэл уг хязгаарлалтад орохгүй болно.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Орхигдсон аливаа цооногийг улс төсвийн хөрөнгөөр битүүмжлэн. Уг гаргасан зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Сум, дүүргийн Засаг дарга орхигдсон цооног битүүмжлэх үүрэг хүлээнэ. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шинэ журам боловсруулан батална.
10.Микро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй

	ЭСЭХ			
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	10.3 Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

### 5.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	2.4 Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх		Үгүй Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй

	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд Г.М		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөө нөлөө байхгүй
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Сум, дүүргийн Засаг дарга орхигдсон цооног битүүмжлэх үүрэгтэй болно. Захиргааны байгууллага усны нөөцийн хомсдлын түвшин тогтоох үүрэгтэй болно. Төрийн зүгээс тавих хяналт сайжирна.
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		Төрийн албан хаагч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зерэг нөлөө үзүүлнэ.
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм		Ус ашиглах, хэрэглэх эрэмбэ тогтоосноор иргэд унд, ахуйн хэрэглээний

				усаар хангагдахаар шаардах эрхтэй болно.
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 Хувь хүний/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй		Үнд, ахуйн хэрэглээний усны хүртээмж сайжирснаар нийт хүн амын өвчлөлт багасч эрүүл мэндэд зерэг нөлөө үзүүлнэ.
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эс эх	Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ/-т нөлөөлөх эсэх	Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Үнд, ахуйн хэрэглээний усны хүртээмж нэмэгдэнэ.
	6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3 Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.5 Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх явц сайжирч, зэрэг нөлөө гарна.
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2 Хэл соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3 Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хүснэгт 5.

#### 5.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Агаар	1.1 Зохицуулалтын үр дүнд агаар бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш эрчим хүч	2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамал хамгаалах	3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2 Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3 Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	4.2 Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	4.3 Үндны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
5.Хөрсний бохирдол	5.1 Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	5.2 Хөрсийг эвдлэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1 Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2 Газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3 Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Хамгаалалтыг

	зориулалтыг вээрчлэх эсэх			нэмэгдүүлнэ
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй баялаг	7.1 Самар, жимс зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг түүний нөхөн сэргээлтийн хугацаанаас өмнө ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Нөхөн сэргээгдэхгүй газар доорх ус болон цэнгэг усны ордыг хамгаална

### **ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Иймээс аргачлалын 7-д зааснаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.

Хувилбаруудын эерэг болон сөрөг тал, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж, хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ.

### **ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

### **ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ, АШИГЛАХ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА**

#### **МОНГОЛ УЛС**

#### **Газрын доорх усыг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн орчин**

№	Хуулийн нэр	Газрын доорх усны ашиглалт, хамгаалалттай холбоотой заалт байгаа эсэх
1	"Усны тухай" хууль 2012.05.17	"Усны нөөц" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг; <u>13 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бурэн эрх</u> <u>13.1.3. усны нөөц хомсдох, гол горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн</u>

		<p>сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;</p> <p><u>17 дугаар зүйл. Сав газрын захиргааны бүрэн эрх</u></p> <p><u>17.1.12 гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах;</u></p> <p><u>22 дугаар зүйл. Усны нөөцийг хамгаалах</u></p> <p>22.1. Усны нөөцийг хомсдох, бохирдооос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.</p> <p>22.18 Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, Байгаль орчин, уур амьсгалын сан, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлнэ”</p> <p><u>30 дугаар зүйл. Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлага</u></p> <p>30.1.1.ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;</p> <p>30.1.2.хоногт 50 шоометрээс их ус ашиглагч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу дотоод хяналтын цэг, техник хэрэгсэлтэй байх ба усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах;</p>
2	Байгаль орчныг хамгаалах тухай"хууль	<p>Хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ: (Газар, түүний хөрс, газрын хэвлэй, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар)</p> <p>“Ус” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорх ус хамаарна;</p>
3	Газрын хэвлэлийн тухай хууль	<p><u>18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ердийн ашигт малтмал олборлох, газар доорх цэнгэг усыг ашиглах</u></p> <p>Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн уурхайн эдэлбэр авахгүйгээр ердийн ашигт малтмал олборлох, газар доорх цэнгэг усыг ашиглах эрхтэй.</p>
4	Засгийн газрын	4.2.1.Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг

	2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2016.09.09 №45	усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна.  4.2.3.Усны нөөцийг хамгаалж, хомсдлоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.
5	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2016.02.05 №19	<u>2.3.1.Усны нөөцийн нэгдсэн менежмент</u> Зорилт 1.Усны нөөцийг хамгаалж, хомсдлоос сэргийлнэ. I үе шат (2016-2020): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх. Зорилт 2. <u>Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.</u> I үе шат (2016-2020): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох. II үе шат (2021-2025): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох. III үе шат (2026-2030): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.
6	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010.07.15 №48	3.5.1.Усны нөөцийн хомсдлоос сэргийлэх 3.5.1.1.Усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ. 3.5.1.2.Усны үнэлээмжийг нэмэгдүүлэх, нөөцийг хамгаалах, өсгөх ажлыг санхүүжүүлэх механизмыг тодорхой болгох, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн усны эрэл, хайгуулын зардлыг эргэн төлүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийнэ. 3.5.1.4.Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны

		нөөцийг хамгаална.
7	"Ус" үндэсний хөтөлбөр 2010.05.20 №24	<p>3.1.7 гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 80 хувьд хамаарах газрын хилийг нарийвчлан тогтоож улсын болон орон нутгийн хамгаалалтад авна. Энэ хэсэгт явагдаж байгаа болон явуулахаар төлөвлөж байгаа серөг нөлөө бүхий аливаа үйл ажиллагааг багасгаж, зогсоох арга хэмжээг авах;</p> <p>3.2.14. Монгол орны гадаргын болон газар доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг байнгын, тасралтгүй мэдээлэл, удирдлагын хамгийн сүүлийн үеийн системд сууринсан сүлжээ болгон өөрчлөх;</p> <p>3.2.15. Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд сүлжээ байгуулах ажлын хүрээнд региональ гидрогоеологийн үндсэн тогтцын онцлогт тулгуурлан 40 м хүртэл гүнтэй 150 цооног өрөмдөж тоноглон, мэдээллийг улсын усны мэдээллийн санд оруулах.</p> <p>3.5.9. Сав газрын нэгдсэн менежментийн зөвлөлүүдийг аж ахуйн үйл ажиллагааны ачаалал ихтэй том, дунд хэмжээний голуудад байгуулан ажиллуулна. Усны нөөцийг байгалийн бусад нөөцийг зохистой ашиглах, хамгаалах цогц үйл ажиллагаатай уялдуулан менежментийн цогцолбор төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;</p>
8	Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө 2013.11.30 №389	<p>4.12. "Гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдол, хомсдоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ". /2014-2021 онд Улсын төсвийн хөрөнгөөр/</p> <p>5.17. Мониторингийн орчин үеийн шинэлэг техник, технологи, арга, аргачлал нэвтрүүлэх замаар мониторингийн мэдээллийг сайжруулна. Томоохон голуудын дагууд болон шаардлагатай байрлалд газрын доорх усны мониторингийн цэгүүд шинээр байгуулж, мониторингийн сүлжээг өргөжүүлнэ. Газрын доорх усны судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний төвтэй болно /2014-2021/</p>
9	"Төрөөс экологийн талаар баримтлах бодлого" УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоол	<p>3.7.1. Монгол орны газрын дээрх ба доорх усны нөөц нь байгаль болон амьдралын эрүүл орчны шүтэлцээг хангагч үндсэн эх үүсвэр хэмээн үзэж усны нөөц, чанарыг хадгалан гамтай ашиглаж, нөхөн сэргэх, арвижих боломжийг хангах нь төрийн бодлогын зангилаа асуудал мөн;</p> <p>3.7.2 экологи-эдийн засгийн үнэлгээ, чанарын хяналт-шинжилгээ, бүртгэл тооцоог боловсронгуй болгох үндсэн дээр усны нөөцийг хэмнэх чиглэл, ашиглах зориулалт, боломжит дээд хязгаарыг бүсчлэн тогтооно;</p>
10	"Газрын доорх	Газрын доорх усны ангилал, газрын доорх усны нөөцийн

	усны нөөцийн ангилал, зэрэглэлийн аргачилсан загвар батлах тухай" Сайдын тушаал 2015.04.20. А-173	ангилал, зэрэглэл, рашааны ордын нөөцийн ангилал, зэрэглэл, Хавсралт 2-д "Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын тайлангийн агуулга", Хавсралт 3-д "Газрын доорх усны эрэл, хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын техникийн даалгавар" /жишиг/.
--	--	---

"Усны тухай" хуулийн зорилт нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Хуулинд "усны нөөц" гэж Монгол улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг хэлнэ гэж тусгаснаас өөрөөр газрын доорх усны нэр томьёо тодорхойлолт байхгүй байна. Энэ нь усны нөөц ашиглуулсны төлбөрийн асуудалд хүндрэл учруулдаг. Тухайлбал, хуулиар заагаагүй учраас хөрсний усыг гадаргын усанд эсвэл газрын доорх усанд хамааруулж ус ашиглуулсны төлбөр тооцох нь тодорхойгүйн улмаас иргэд аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хооронд үл ойлголцол үүсгэдэг.

Улс орнуудын судалгаанаас харахад газрын доорх усанд булаг шанд, рашаан, худгийн усыг оруулдаг байна. Газрын гадаргуугийн үе давхрааны хооронд орших усыг газрын доорх ус гэх бөгөөд гүний хагарлыг дамжин гарсан гадаргад ил гарсан усыг булаг шанд эрдэсжилт ихтэй түүнийг нь эмчилгээнд ашигладаг бол рашаан гэж нэрлэжээ.

Газрын доорх усыг орших байдлаар нь:

- Грунтын ус:** Газрын гадаргуугийн өнгөн хэсэгт орших гравитацийн ус сул ус чөлөөт ус гэх мэт хэлбэрээр орших ул хөрсний усыг хэлнэ.
- Давхарга хоорондын ус:** Ус үл нэвтрүүлэгч давхаргын дээр орших усыг хэлнэ. Энэ усыг өрөмдөл худаг гарган ашигладаг.
- Артезийн ус:** 1887 онд францын Артуа мужид газар өрөмдөж байсан хүмүүс асар их даралттай ус байхыг олж түүнийгээ артуа гэж нэрлэсэн нь сунжирсаар Артезийн ус болж нэршсэн газрын гүнд их даралттай орших ус.

Манай улсын "Усны тухай" хуулийн 22 дугаар зүйлд "Усны нөөцийг хамгаалах" харилцааг зохицуулсан хэдий ч энэ харилцаа нь зөвхөн усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоох, зөрчихийг хориглохоор хязгаарлагдсан.

22 дугаар зүйл /Усны нөөцийг хамгаалах/-д газрын доорх усанд хамаарах дараах 2 заалт байна.

- 22.1.-д Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.
- 22.18.-д Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, Байгаль орчин, уур амьсгалын сан, аж ахуйн нэгж,

байгууллагын хөрөнгө, гадаадын зээл, тусlamжаар санхүүжүүлнэ” гэж тусгасан.

Улс орнуудын туршлагаас харахад ашиглагч нь хамгаалагч байна гэсэн зарчмитай байна. Тухайлбал, ОХУ-ын “Усны тухай” хуульд Газрын хэвлүй ашиглагч нь газрын доорх усыг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй. Бүгд Найрамдах Казакстан улсын “Усны тухай” хуулиар Газрын доорх усны нөөц, төлөв байдалд хор нөлөөтэй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд нь газрын доорх усанд хяналт, шинжилгээ хийж, усанд үзүүлэх хор уршиг, усны нөөцийн хомсдол, бохирдоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг заавал авч хэрэгжүүлдэг. Бүгд Найрамдах Узбек Улсад “Газрын доорх усыг хамгаалах үйл ажиллагаа нь цооногийн ажиглалтын сүлжээ байгуулахаас гадна, газар доорх усанд нөлөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн тусlamжтай хийгддэг.

Дэлхийн улс орнууд усыг ашиглах талаар харилцан адилгүй эрх зүйн зохицуулалттай байдаг боловч хаана ч ижил байх зарчмууд байдаг.Үүнд:

- Усны чанарт хяналт тавих
- Усыг зөв ашиглах
- Усны ундаргыг хамгаалах зэрэг болно.

Иймд гадны орнууд хууль эрхэйн орчиндоо газрын доорх усны ашиглалт, хамгаалалтын асуудлыг хэрхэн тусгасан байдаг талаар судалгааг хийлээ.

## **АМЕРИК УЛС**

АНУ нь нийтийн эрх зүй буюу Англи – Саксоны эрх зүйн бүлд хамаардаг юм. Иймд АНУ-ын хууль нь бичмэл хуулиас гадна шүүхийн шийдвэр, эрх зүйн практик зарчмуудаас бүрддэг ба эрх зүйн харилцааг хуульчлах, кодчилох практик нь хожуу эхэлсэн бөгөөд одоог хүртэл бүх эрх зүйн харилцааг хууль тогтоомжийн хэлбэрт орж амжаагүй байдаг. Энэхүү эрх зүйн бүлд шүүхийн шийдвэр хуулийг бүтээдэг ба одоог хүртэл маш том үүрэгтэй. Хууль тогтоомж нь шүүхийн шийдвэр дээр үндэслэн гарах нь элбэг байдаг бөгөөд шүүхийн шийдвэртэй зөрчилдсөн дүрэм журам гарах нь ховор байдаг онцлогтой.

АНУ-д усны эрхийн асуудал нь мужийн эрх хэмжээнд байдаг бөгөөд холбооны засгийн газар ус ашиглах эрхийн цар хүрээ, эрхийг тодорхойлох болон хувийн усны эрхийг зохицуулах эрхийг мужуудад олгосон байдаг. Иймд 50 муж өөр өөрсдийн гэсэн усны хууль, дүрэм журамтай байна.

АНУ-д холбооны засгийн газар мөн адил усны зохицуулалтын эрхийг эдэлнэ. Үндсэн зарчим нь усны хэмжээг мужууд, усны чанарыг холбооны засгийн газар хариуцдаг. Сүүлийн үед холбооны засгийн газрын эрх хэмжээ өсч том хэмжээний усны төслүүдийг санхүүжүүлэх, усны нийтийн хэрэглээг хамгаалах, муж хоорондын усны маргааныг шийдвэрлэж байна. Уг эрхүүдийг холбооны засгийн газар хуульд заасны дагуу эсхүл мужийн хүсэлтээр хэрэгжүүлэн олон нийтийн эрх ашгийг хамгаалдаг. Үүнээс гадна Ховордсон төрөл зүйлийн тухай

хууль болон Цэвэр усны тухай хуулийг хэрэгжүүлэхээр мужийн асуудалд оролцох эрхтэй.

Газар доорх усны хувьд холбооны засгийн газрын оролцоо маш бага юм.

АНУ нь 50 муж улстай бөгөөд муж бүр нь өөрсдийн гэсэн газар доорх усны эрх зүйн зохицуулалттай. Эдгээр зохицуулалтууд нь үндсэн 5 чиг хандлагатай байна. Үүнд:

- Үнэмлэхүй өмчлөх эрх /Англи дүрэм//Англи-Саксоны эрх зүй/ (Absolute ownership)
- Зохистой хэрэглээ /Америк дүрэм/ (Reasonable use)
- Ашгийн төлөөх зарчим /Англи болон Америк дүрмийн холимог/ (Beneficial purpose doctrine/ Restatement (second) of Torts §858)
- Харилцан хамааралтай хэрэглээ (Correlative use)
- Давуу эрхийн эзэмшил (Prior appropriation)

## 1. Үнэмлэхүй өмчлөх эрх /Англи дүрэм//Англи-Саксоны эрх зүй/

Үнэмлэхүй өмчлөх эрхийн зарчмаар гадаргыг (газар) өмчилдөг этгээд газар доорх усыг мөн өмчлөх эрхтэй бөгөөд хөрш зэргэлдээх газар өмчлөгчид хохирол учирсан байсан ч газар доорх усыг татаж ашиглах эрхтэй юм.

Энэхүү зарчим нь Англи улсаас гаралтай бөгөөд АНУ-ын зүүн бүсийн мужуудад (Коннектикуд, Жиоржиа, Луизиана, Мэйн, Роде Айланд) болон Техаст одоог хүртэл мөрдөгдөг байна.

Энэхүү дүрэм нь маш энгийн бөгөөд уян хатан юм. Газар доорх усыг захирах дүрэм, тусгай зөвшөөрөл болон захиргааны байгууллага байхгүй. Газар доорх ус ашиглагч гүний худаг ухах гэх мэт зардлыг өөрөө хариуцна.

Энэхүү дүрмийн гол сул тал нь хяналт сүлттай байх явдал бөгөөд энэ нь хөрөнгө оруулалт багасах, шүүх энэ дүрмийг хэрэгжүүлэхээс татгалзах гол шалтгаан болдог.

## 2. Зохистой хэрэглээ /Америк дүрэм/ (Reasonable use)

Зохистой хэрэглээний дүрэмд газар эзэмшигч нь өөрийн өмчлөлийн газар доорх усыг ашиглах эрхтэй боловч хөрш газар өмчлөгчдийн газар доорх ус ашиглах эрхийг хөндсөн тохиолдолд зөвхөн зохистой хэмжээнд газар доорх усыг ашиглах боломжтой. Зохисгүй хэмжээнд хэрэглэснээс бусдад учирсан аливаа хохирлыг ус ашиглагч бүрэн хариуцна. Өөрөөр хэлбэл газар эзэмшигч нь ус ашиглах абсолют бус хязгаарлагдмал эрхтэй юм.

Энэхүү дүрмээр газар өмчлөгч нь газар доорх усыг мөн өмчилдөг Америк хэв маягийн дүрэм юм.

XIX-р зууны сүүлээс эхлэн АНУ-д Үнэмлэхүй өмчлөх эрхээс татгалзаж Зохистой хэрэглээний дүрэмд шилжиж эхэлсэн. Одоогоор Алабама, Аризона, Арканзас, Флорида, Иллинои, Кентаки, Мариланд, Миссисипи, Мисссури, Нью Хэмпшир, Нью Йорк, Хойд Каролина, Оклахома, Пенсильвани, Өмнөд Каролина,

Тэннесси, Виржиния болон Баруун Виржиния мужууд энэхүү дүрмийг мөрддөг байна. /18 муж/

Энэ дүрмийн давуу тал нь илүү их хяналт бий болгосон бөгөөд газар доорх ус ашиглагчдын эрхийг худаг огтлолцох болон ус хэтрүүлэн татах асуудлаас (will interference and over-draft problems) сэргийлэх юм. Огтлолцол нь хоёр ба түүнээс дээш худгийн хонхорхой (cone of depression of two or more wells) давхцаж эдгээр худгуудын ус багасахыг хэлдэг.

Энэхүү дүрмийн гол асуудал нь “Зохистой болон үр ашигтай хэрэглээ гэж ямар хэрэглээг хэлэх вэ?” гэдэг асуулт юм. Газар доорх усны оршиж буй газартай холбоотой аливаа газар доорх усны хэрэглээ нь зохистойд тооцогдох юм. Гэвч газрыг эзэмшдэггүй этгээдийн газар доорх ус ашиглалт нь газар өмчлөгчийн газар доорх усны эрхтэй зөрчилдвэл газар эзэмшдэггүй этгээд газар доорх усыг зохисгүйгээр хэрэглэсэнд тооцогдоно.

Иймд, Зохистой хэрэглээний дүрэм нь хоёр газар өмчлөгчийн газар доорх ус ашиглах эрхтэй холбоотой маргааныг шийдэж чаддаггүй бөгөөд газар доорх усны хэрэглээ нь хичнээн ашигтай эсхүл зохистойгоос үл хамааран газар эзэмшдэггүй эсхүл тухайн газрыг эзэмшдэггүй этгээдийн эрхийг хамгаалж чаддаггүй сүл талтай юм.

### **3. Ашгийн төлөөх зарчим /Англи болон Америк дүрмийн холимог/ (Beneficial purpose doctrine/ Restatement (second) of Torts §858)**

Ашгийн төлөөх зарчим нь Англи болон Америк дүрмийн холимог бөгөөд Америкийн хуулийн институтийн судлаачдын асар их судалгааны үндсэн дээр бий болсон бөгөөд уг институтээс санал болгосон Гэм хорын хоёр дугаар Ристэйтмент (дахин баталгаажуулалт дүрэм)-ийн 858 дугаар зүйлд тусгагджээ.

Энэхүү дүрэм нь Английн үл хариуцах концепци болон Америкийн зохистой хэрэглээний дүрмүүдийг агуулсан байна. Гэм хорын хоёр дугаар Ристэйтментийн 858 дугаар зүйлийн дагуу дараах тохиолдолд ашиглагч нь гэм хорын хариуцлага үүснэ. Үүнд:

- Ус таталт нь хөрсний усны түвшинг багасгах замаар ус татдаг бусад этгээдэд хохирол учруулсан
- Ус татал нь газар доорх уснаас тэжээл авдаг нуур, гол болон горхиудад хохирол учруулсан
- Ус таталт нь өмчлөгчийн хэрэглээний зохистой хувиас их хэмжээний ус шахаж авсан.

Энэхүү дүрмийн гол зорилго нь жижиг худаг ашиглагчдын эрхийг өндөр хүчин чадалтай худаг ашиглагчдаас хамгаалах явдал бөгөөд үүнээс гадна газар доорх болон гадаргуун усны хамаарлыг мөн адил авч үздэг онцлогтой юм. Мичиган, Охаио, Висконсин мужууд мөрддөг.

### **4. Харилцан хамааралтай хэрэглээ (Correlative use)**

Харилцан хамааралтай хэрэглээний дүрэмд газар доорх усыг газар өмчлөгч үнэмлэхүй абсолютаар өмчлөхгүй бусад эзэмшигчийн эрхтэй харилцан хамааралтайгаар ус ашиглах эрх эдэлнэ.

Газар өмчлөгчдийн ердийн /түгээмэл/ сав газар, ханасан давхарга, газар доорх усан сантай (common basin, saturated strata, or underground reservoir) холбоотой эрхүүд нь харилцан хамааралтай болон харилцан тэгш юм. Газрын нэг өмчлөгч нь бусдын эрхийг зерчиж байгаа тохиолдолд өөрт оногдсон хувиас илүү ус татахгүй, энэ хязгаарлалт нь өөрийнх нь өмчилж буй газар доор байгаа усанд мөн хамааралтай.

Газар доорх ус ашиглах хувь, хэмжээ нь газар өмчлөгчийн өмчлөлийн газрын хэмжээ (акр) нь усан давхаргын нийт хэмжээтэй харьцах харьцаанаас шалтгаална. Энэхүү дүрмээр газар өмчлөгч нь газар доорх усыг мөн адил өмчилнө.

Чийглэг болон хагас хуурай мужуудын шүүхүүд нийтийн эрх зүйн ус ашиглах дүрмийг халж зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлэх зорилготойгоор мөрдөж эхэлсэн байна. Арканзас, Калифорни, Делавэйр, Хавай, Айова, Минесота, Нью Жерси, Оклахома болон Вермонт мужууд энэ дүрмийг дагадаг.

Энэ дүрмийг газар доорх усны нөөц багатай мужууд бүх ус ашиглагч нарт газар доорх усны хүрэлцээг хангах зорилготой дагаж мөрддөг. Сав газраас гадуур оршдог хэрэглэгчдэд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр газар доорх усыг ашиглах ба зөвхөн тухайн сав газарт усны илүүдэл нөөц байгаа ба тухайн нөөц нь тухайн газрын ашиглагчдад шаардлагагүй тохиолдолд газар доорх ус ашиглах зөвшөөрөл олгодог байна.

Сав газрын усыг хэтрүүлэн ашигласан тохиолдолд үндсэн хэрэглэгчдийн ашиглалтыг хязгаарлан газар доорх усны түвшинд хяналт тавьдгаараа Зохистой хэрэглээний дүрмээс давуу талтай юм.

##### 5. Давуу эрхийн эзэмшил (Prior appropriation)

Давуу эрхийн эзэмшлийн дүрмийн дагуу газар доорх ус нь мужийн өмчлөлд байдаг байна. Товчоор тайлбарлавал “түрүүлж ирсэн нь түрүүлж эрх эдэлнэ” гэх дүрэм юм. Газар доорх ус ашиглах эрхийг цаг хугацааны дарааллаар олгож, тодорхой сав газрын тодорхой хэсгийг түрүүлж эзэмшин, ашиглалтад оруулсан этгээд давуу эрх эдэлдэг.

Энэхүү дүрмийг баруун мужууд болох Аляска, Колорадо, Айдахо, Канзас, Монтана, Невада, Нью Мехико, Хойд Дакота, Орегон, Өмнөд Дакота, Юта, Вашингтон болон Вайоминг нар дагаж мөрддөг байна.

Давуу эрхийн эзэмшлийн дүрмийн гол зорилго нь газрын ус ашиглалтыг хянах, зөвшөөрлийн тоог хязгаарлах замаар усны сав газрын их хэмжээгээр татан ашиглахаас сэргийлэх юм. Захиргааны байгууллага нь ус шахах хэмжээний хязгаарлалт, худгийн байршилд тавих шаардлага, худаг барихад тавигдах шаардлага тогтоон үндэслэлтэй тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзах замаар усны хэрэглээг хянан удирддаг.

Газар доорх ус ашиглах зөвшөөрөл бага олгогдсон газарт тухай үеийн нөхцөл байдлаас шалтгаал зөвшөөрөл олгодог ба ус ашиглах зөвшөөрөл их олгогдсон газарт зөвшөөрөл хүсч буй худгийн нөлөөллийг сайтар судалсны эцэст л зөвшөөрөл олгодог. Өөрөөр хэлбэл газар доорх усыг илрүүлсэн этгээд болгон

ашиглах эрхтэй бус тухай газрын нөхцөл байдал, худаг болон бусад газрын ус ашиглах төхөөрөмжийн тоо зэргээс шалтгаалан усны хэрэглээ зөвшөөрдөг хатуу тогтолцоюү.

Энэ дүрмийн сул тал нь газар доорх усыг анхлан буюу түрүүлж ашиглах эрхтэй болсон этгээдүүд шинэ хэрэглэгчдийг нэвтрүүлэхийг зөвшөөрөхгүй байх боломж өндөр бөгөөд энэ нь усны нөөцийг өөр газраас авах боломжгүй хэрэглэгчдэд эрх олгохоос татгалзаж байгаа нь шударга бус юм. Үүнээс гадна хувь этгээдийн үндсэн эрх, нийгмийн эдийн засгийн үр өгөөжийг хязгаарладаг.

### **Газар доорх ус хамгаалалтын бүс (цаашид "ГДУХБ" гэх)**

ГДУХБ-ийг засгийн газраас хууль тогтоогчдын тогтоосон бүсэд нутгийн захиргаа газар доорх усыг удирдах, хамгаалдаг тусгай газар юм. Ихэвчлэн газар доорх усны нөөцийн асуудалтай бүсүүд сонгогддог ба мужийн бусад газар доорх уснаас ондоо удирдлага хэрэгжүүлдэг байна. Зарим мужууд нэгдсэн ГДУХБ-ийн удирдлагын дүрэмтэй байдаг бол зарим мужууд бүс болгонд онцгой зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Мужууд ГДУХБ газрын мэдээлэл цуглуулах, тусгай дүрэм бий болгох, боловсрол олгох, жижиг тосгон, оршин суух газруудад нөөц хуваарилдаг.

ГДУХБ нь дараах зохицуулалтуудыг боломжтой болгодог байна. Үүнд:

- Уст давхаргын гидрологийн зүй тогтлыг харгалзан үзэж хэрэглээг тогтоох боломжтой. Хэрэв орон нутгийн усны тэжээгдэл өндөр бол зарлагын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.
- ГДУХБ нь талбайн хэмжээн дээр үндэслэн үйлдвэрлэлийн хязгаар тогтоож усны түвшин бууралтыг намдааж болно.
- Газар доорх ус, гадаргын усны нөөц болон бусад ашиглагчдад үзүүлэх нөлөөг харгалзан ГДУХБ нь газар доорх ус ашиглах зөвшөөрөл олгож болно.
- Үр ашиггүй хэрэглээ болон бохирдлыг хязгаарлах, нөөцийн хамгаалах зорилгоор ГДУХБ нь газар доорх ус ашиглах зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- Усны чанарыг хамгаалахын тулд худаг барих болон хаах тусгай стандарт тогтоож болно.
- ГДУХБ-ийн удирдлагыг сайжруулах мэдээлэл, тоо баримт цуглуулах зорилгоор худаг болон өрөмдлөгийн бүртгэл хөтлөх, газар доорх усны олборлолтын тайлан гаргах шаардлага тавьж болно.
- Бүс нь ахуй, газар тариалан, уул уурхай, амралтын газар гэх мэт ус ашиглах хэлбэрээс шалтгаалан ус олборлолтын хэмжээг хязгаарлаж болохгүй. Гэвч усны түвшин тодорхой хэмжээнд буурах тохиолдолд бага ач холбогдолтой хэрэглэгчдийн ус ашиглах хэмжээг хязгаарлах эсхүл хориглох эрхтэй.

## АРИЗОНА МУЖ

Аризона муж нь цөлийн уур амьсгалтай, жилд дунджаар 323 мм бороо ордог бөгөөд өвөл болон зуны сүүлийн саруудад ордог байна. 7 сая гаруй хүн амтай бөгөөд Ирланд, Финланд, Шинэ зеланд гэх мэт улсаас том эдийн засагтай.

Зэс олборлолт нь XIX зуунаас Аризонагийн тэргүүлэх салбар болсон бөгөөд АНУ-ын тэргүүлэх зэс олборлогч муж болж АНУ-ын зэс олборлолтын 60%-ийг эзэлдэг. 2007 онд Аризона рекорд тогтоож 5,54 тэрбум ам.долларын үнэлгээтэй нийт 750 мянган тонн зэс олборлосон байна.

Аризона муж суурьшиж эхэлсэн цагаас газар доорх усанд нөхөгдөх боломж олголгүйгээр татан ашиглаж “хэтрүүлэн ашиглалт”-ын томоохон асуудалд орсон. Буруу ашиглалтын үр дүнд өрөмдлөг болон ус олборлолтын зардал өсч улмаар усны нөөцгүй болох аюул тулгараад байв. Үүнээс гадна, чанаргүй усны хэрэглээ өсч газрын гадаргуу доош суун зам, барилга байгууламж, газар доорх бусад байгууламжийг гэмтээж болзошгүй хагарал, ан цав үүсэх аюултай байв.

Иймд, ГДУ-ны нөөц нь иргэдийн сайн сайхан болон амьдралын чанарт нөлөөлөх тул Аризона муж нь эрх зүйн шинэчлэлт хийн 1980 онд Аризонагийн Газар доорх усны менежментийн хуулийг (цаашид “ГДУМХ” гэх) баталсан байна.

ГДУМХ-ийн төслийг бэлдэхийн тулд хатуу бодит нөхцөл байдалтай нүүр тулж маш олон асуултад хариулах шаардлага тулгарсан байна. Үүнээс дурдвал:

- Аризона мужийн газрын доорх усны хэмжээний нөөц?
- ГДУ-ыг хэн ашиглах нь зүйтэй вэ?
- Ямар зорилгоор ГДУ-ыг ашиглах вэ?
- Тодорхой төрлийн хэрэглээнд хэр их ус татах хэрэгтэй вэ?
- Аризонагийн иргэд ус таталтанд хэрхэн хяналт тавих вэ?

1986 онд Форд сан нь Аризонагийн Газар доорх усны менежментийн хуулийг (цаашид ГДУМХ) АНУ-ын муж болон орон нутаг дундаас 10 хамгийн шинэлэг хөтөлбөрийн нэг хэмээн сонгожээ. Энэхүү хууль нь 1980 онд батлагдсан бөгөөд Аризонагийн иргэд хамгийн чухал байгалийн нөөцийг хамгаалах, мужийнхаа онцлог болон тодорхой хэрэгцээг үүнтэй уялдуулахыг зорьжээ. Үүний үр дүнд газар доорх усны нэгдмэл, үр дүнтэй тухайн цагт шинэлэг эрх зүйн зохицуулалт бий болж чадсан байна.

1980 оны ГДУМХ нь гурван гол зорилготой. Үүнд:

- Мужийн ихэнх хэсгүүдэд ажиглагдаж буй хэтрүүлэн ашиглалтыг хянах;
- Улсын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хамгийн үр дүнтэй хангахын тулд газрын доорх усны хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой хуваарилах арга хэрэгслээр хангах;
- Аризонагийн усан хангамжийг сайжруулах замаар газрын доорх усны нөөцийг сайжруулах

Эдгээр зорилгуудыг биелүүлэхийн тулд нэгдсэн менежментийн тогтолцоог бий болгож Аризонагийн Усны нөөцийн газрыг байгуулсан. Нэгдсэн

менежментийн хүрээнд ГДУМХ нь ГДУ-ны нөхцөл байдлаас шалтгаалан гурван шат бүхий усны менежмент бий болгосон байна. Үүнд:

- Менежментийн хамгийн доод шат нь муж даяар хэрэглэгдэх нийтлэг зохицуулалтыг агуулдаг.
- Дунд шат нь Усалгаатай өргөтгөлийн бус талбай (нийт 2 байдаг) хамаарна.
- Хамгийн дээд шат нь ГДУ-ны хэтрүүлэн ашиглалт хамгийн ноцтой газрууд болох Идэвхтэй хяналтын бүсэд (нийт 5 бүс байдаг) хамаарна.

Усалгаатай өргөтгөлийн бус талбай болон Идэвхтэй хяналтын бүсийг хот, дүүргийн бүсээр бус газар доорх усны сав газар, дэд сав газраар хуваадаг. Усны менежментийн газар нь эдгээр бүсүүдийг тогтоох бөгөөд иргэд мөн адил эдгээр бүсүүдийг бий болгохоор саналаа өгөх эрхтэй.

Идэвхтэй хяналтын бүсийн менежмент хамгийн хатуу бөгөөд хэтрүүлэн ашиглалтын 70% нь мөн Аризонагийн нийт хүн амын 80% нь энэхүү бүсэд хамаардаг. Энэхүү бүсүүдэд 2025 он хүртэл "safe-yield" буюу "аюулгүй олборлолт" бодлогыг хэрэгжүүлж бүсээс олборлодог жилийн усны хэмжээ болон байгалийн болон хиймэл аргаар нөөцийн нөхөн сэргээлтийн урт хугацааны тэнцвэрийг хангах зорилготой юм.

Идэвхтэй хяналтын бүстэй (ИХБ) холбоотой дараах **ЗУРГААН ЗОХИЦУУЛАЛТЫГ** хуулинд тусгасан байна, Үүнд:

1. ГДУ-ны эрхийн болон ашиглалтын зөвшөөрлийн тогтолцоог бий болгох
2. ИХБ-д газар тариалангийн зориулалтаар шинэ газар олгохыг хориглох
3. Таван ИХБ болгонд усны менежментийн төлөвлөгөө боловсруулан хамгаалалтын зорилт тогтоох болон бусад усны менежментийн шалгуурыг тогтоох нэгдсэн тогтолцоо бий болгох.
4. Бүтээн байгуулагч нарт усны түвшний өсөлтийг хангах 100 жилийн баталгаатай усан хангамжийн баталгаа гаргахыг шаардах
5. Бүх томоохон худгуудад усны тоолуур тавих
6. Ус таталт болон ашиглалтын жилийн тайлан боловсруулалтыг шаардах. Эдгээр тайлангууд нь аудитлагдах бөгөөд гаргасан зөрчилд хариуцлага хүлээнэ.

ИХБ-д гурван төрлийн **УС АШИГЛАХ ЭРХ** зөвшөөрөгдсөн байна. Үүнд:

1. Өвлөгдсөн эрх
  - a. Усалгаатай өвлөгдсөн эрх – 1975-аас 1980 оны хооронд усалгаанд хамрагдаж байсан тодорхой газар нутгийн хэсгийг эзэмших эрхийг хэлнэ. "Усалгаа" гэж хоёр ба түүнээс дээш акр газрыг хүнсний хэрэглээ, малын тэжээл бэлтгэх зорилгоор услахыг хэлдэг байна. Ус ашиглах зөвшөөрөлд боломжит усны хэмжээг заадаг бөгөөд тухайн үеийн тооцооллоос шалтгаалан өөрчлөгдэж болдог. Усалгааны эрх нь газрын өмчлөх эрхтэй нягт холбоотой бөгөөд тусад нь худалдах боломжгүй. Усалгааны эрхгүй газарт газар тариалан эрхлэх хориотой.
  - b. 1-р төрлийн эрх – газар тариаланд ашиглагдах боломжгүй болсон шинэ аж үйлдвэр барих боломжтой газар. Жил бүр шахах боломжтой усны

хэмжээ нь хамгийн ихдээ 1 акр газарт 3 акр-фут. Газрын өмчлөх эрхтэй нягт холбоотой.

- c. 2-р төрлийн эрх – усалгааны бус зориулалтаар ашиглаж болох ба ус ашиглах хэмжээ нь 1975 – 1980-д оны ус ашиглалтын хэмжээтэй тэнцүү байна. Усалгааны бус ашиглалтад үйлдвэр, мал аж ахуй, гольфийн талбай гэх мэт орно. Өмчлөх эрх нь илүү уян хатан бөгөөд газар эсхүл худгаасаа тусад нь худалдаж болно. Усны нөөцийн газрын зөвшөөрөлтэйгээр газар өмчлөгч тухайн ИХБ-ийн дотор өөр газраас ус ашиглаж болох ба өөрийн 2-р төрлийн эрхээ бусдад түрээсэлж болно.
2. Үйлчилгээний бүсийн эрх – хот, хотхон, тосгон, хувийн усны компаниудад хэрэглэгчдэд ус түгээх зорилгоор олгогддог ус ашиглах эрх.
3. Ус таталтын зөвшөөрөл – газар тариалангийн усалгааны бусаар ГДУ-ыг ашиглах шинэ татуургын зөвшөөрөл. Уг зөвшөөрөл нь 8 төрөлд хуваагддаг байна. Жишээ нь, аж үйлдвэрийн зориулалтаар ашиглах, муу чанарын газар доорх ус таталтын зөвшөөрөл гэх мэт.

Зөвшөөрлийн төрөл болгон нь өөрийн гэсэн ус ашиглах хэмжээ, зорилго тодорхойлсон болон бусад нөхцөлтэй байдаг. Тэр дундаа усалгааны болон усалгааны бус хоёрын ялгаа маш чухал.

ИХБ-д газар тариалангийн усалгааг идэвхтэй хязгаарлаж байгаа бөгөөд зөвхөн усалгааны эрхтэй өвлөгдсөн эрхийн дагуу газар тариаланг усалж болно. Үүнээс гадна өвлөгдсөн эрхийн дагуу усны өмчлөл, эзэмшил, усны хэрэглээний зориулалт болон хэмжээ нь ГДУМХ батлагдахаас өмнө 1975–1980 оны байдлаараа царцаагдсан байдгаараа онцлогтой юм.

ИХБ-д газрын өмчлөл, эзэмшлээ худалдах гэж буй бүх этгээдүүд Аризонагийн Усны нөөцийн газарт **УСАН ХАНГАМЖИЙН БАТАЛГААг** заавал гаргаж Усан хангамжийн гэрчилгээ авна. Уг гэрчилгээг авахын тулд дараах шаардлагыг хангана. Үүнд:

- 100 жилд санал болгосон ашиглалтын зорилгод тухайн газрын усны хэмжээ болон чанар нь хүрэлцээтэй
- санал болгож буй ашиглалт нь ИХБ-ийн менежментийн төлөвлөгөө болон ИХБ-ийн үндсэн зорилготой нийцэх ёстай
- ус нийлүүлэгч нь санал болгож буй бүтээн байгуулалтын усны хангамжийг нийлүүлэхэд хангалттай усны хангамж, ариутгах татуургын систем барих эдийн засгийн хүчин чадалтай эсэх.

Худалдан авагч нь зөвхөн Усан хангамжийн баталгааны гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулах эрхтэй.

1995 онд Аризонагийн Усны нөөцийн газар Усан хангамжийн баталгааны дүрмийг шинээр баталж шинэ бүтээн байгуулалтад гадаргын ус гэх мэт нөхөн сэргээгдэх нөөц ашиглахыг шаарддаг болсон.

## КАЛИФОРНИ МУЖ

Калифорни муж нь АНУ-ын баруун хойно зүгт далайн эрэг дээр оршдог боловч хүн ам, аж үйлдвэрлэл, газар тариалан хөгжил нэмэгдэхийн хэрээр усны хэрэглээ нэмэгдэж сүүлийн жилүүдэд ган гачиг их тохиолдож гал түймэр гэх мэт байгалийн гамшиг ихээр тохиолдсон байна.

Калифорни муж нь хэрэгцээнийхээ 30-60%-ийг ГДУ-аас хангадаг. Ихэвчлэн хуурай газруудаар ГДУ-ыг ашигладаг боловч ГДУ-ны хэт хамаарлаас болж ГДУ-ны нөөц мужийн ихэнх хэсгээр удаан хугацааны туршид багасаж эхэлсэн. 4 жилийн хугацааны туршид ган гачиг үргэлжилсний эцэст 2014 онд Калифорни муж нь Газар доорх усны тогтвортой менежментийн тухай хуулийг (цаашид ГДУТМХ) баталсан байна. Энэхүү хууль нь Калифорни мужийн сүүлийн хагас зууны хамгийн дэвшилтэт усны эрх зүйн зохицуулалтад тооцогддог.

Одоогийн байдлаар газар өмчлөгч ГДУ-ыг өмчилдөг бөгөөд бусадтай эрх нь тэгш, харилцан хамааралтай байдаг. Газар зээмшдэггүй этгээд газар өмчлөгчөөс ус авах боломжтой. Ус шахалтыг дүүрэг, хороодын нутгийн захиргаа хариуцдаг.

ГДУ-ыг гурван төрөлд хуваадаг байна. Үүнд:

- (1) газар доорх горхи, хөндийгөөр урсдаг,
- (2) гадаргын урсцын газар доорх урсгал. Хөрс, элс, хайрган дунд урсдаг ус бөгөөд гадаргын устай холбоотой байх ёстой.
- (3) нэвчих ус буюу харьцангуй сийрэг давхаргаас илүү гүнд орших сав газар луу нэвчдэг усыг хэлнэ.

**Тогтвorumуулагч агентлаг.** ГДУТМХ нь газар доорх усны эрх зүйн зохицуулалт, түүнийг хүрээг тодорхойлж нутгийн ГДУ-ны тогтвorumуулагч агентлагууд (цаашид “Тогтвorumуулагч агентлаг” гэх) хэрэгжилтийг хариуцдаг байна. Тогтвorumуулагч агентлагууд нь тогтвorumуулах төлөвлөгөөг боловсруулдаг ба энэхүү төлөвлөгөөг хэтрүүлэн ашиглалтаас үүдэх серөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон ГДУ ус хэрэглэгч болон ашиглагчид буюу нийт оролцогчдын ашиг сонирхлыг харгалзахыг шаарддаг. Оролцогчдод ГДУ оршиж буй газрын газар өмчлөгчид, нийтийн ус хангамжийн газар, нутгийн газрын агентлагууд, байгаль орчин ашиглагчид, гадаргуун ус ашиглагчид, холбооны засгийн газар, Америкийн уuguул овгууд, эмзэг бүлгийнхэн болон мониторингийн бүртгэгдсэн байгууллагууд хамаардаг байна.

**Сав газруудын ангилал.** ГДУТМХ нь сав газруудын нөхцөл байдлын хүнд хөнгөнөөс шалтгаалан “тэргүүн ач холбогдолтой”, “дунд зэргийн ач холбогдолтой”, “бага зэргийн ач холбогдолтой” “маш бага ач холбогдолтой” сав газруудад ангилж тэдгээрийн тэргүүн болон дунд зэргийн ач холбогдолтой сав газруудад тавигдах хамгаалалт болон шаардлагуудыг чангатгасан. 2003 оны байдлаар Калифорни муж нь 515 сав газрыг тодорхойлж, үүний 43 нь тэргүүн ач холбогдолтой, 83 нь дунд зэргийн ач холбогдолтой болгон ангилсан байна. Нийлээд 127 ширхэг болох эдгээр сав газрууд нь мужийн ГДУ-ны хэрэглээний 96%-ийг хангаж, хүн амын 88%-д хамаардаг.

ГДУТМХ нь тэргүүн болон дунд зэргийн ач холбогдолтой сав газруудад буруу ашиглалтын урт хугацааны “сөрөг үр дүн” үүсэхээс сэргийлэх хяналтын төлөвлөгөө боловсруулахыг шаарддаг бөгөөд ингэхдээ бүх оролцогчдын санал бодол болон ашиг сонирхлыг нь харгалзан үзэх шаардлагатай байна. Зохистой, төлөөлөгдсөн, оролцоог хангасан Тогтвортжуулагч агентлагийн захиргааны бүтэц нь ирээдүйн маргаан бий болох болон мужийн оролцоо оруулахаас хамгаалах юм.

**Сөрөг үр дүн.** “Сөрөг үр дүн” гэдгийг Тогтвортжуулах агентлагууд сав газрын онцлогоос шалтгаалан тогтоох ба дараах нөхцөлүүдийг заавал харгалзах ёстой байна. Үүнд:

- ГДУ-ны түвшин буурч нийлүүлэлтийн хэмжээнд томоохон болон үндэслэлгүй хорогдол бий болох
- Их хэмжээгээр болон үндэслэлгүйгээр ГДУ-ны нөөц багасах
- Их хэмжээгээр болон үндэслэлгүйгээр далайн ус нэвтрэх
- Их хэмжээгээр болон үндэслэлгүйгээр усны чанар муудах
- Их хэмжээгээр болон үндэслэлгүйгээр газарт суулт өгөх
- ГДУ-тай холбоотой газар дээрх усны нийлүүлэлт багасч томоохон болон үндэслэлгүй сөрөг нөлөө үзүүлэх

**Тогтвортой олборлолт.** Орон нутгийн Тогтвортжуулагч агентлаг нь сав газар бүрт Газар доорх усны тогтвортжуулалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх үүрэгтэй. Уг төлөвлөгөөгөөр сав газрын “Sustainable yield” буюу “Тогтвортой олборлолт”-ыг тодорхойлон уг түвшинд хүрэх ажлыг зохион байгуулдаг.

“Тогтвортой олборлолт” гэж аливаа сөрөг үр дүн үүсгэхгүйгээр газар доорх усны нөөцөөс жил бүр татаж болох, сав газрын урт хугацааны нөхцөлийг төлөөлж чадах тодорхой хугацаанд тооцсон усны хамгийн дээд хэмжээ, түүний илүүдэл.

Тогтвортой олборлолтод хүрэхийн тулд Тогтвортжуулагч агентлагууд нь хэн удирдах, хэн ус татах, хэн төлөх гэх мэт маш хүнд асуултуудыг тавин шийдвэр гаргах хэрэгтэй байдаг. Учир нь Тогтвортжуулагч агентлаг нь газар өмчлөгчийн ГДУ-ны өмчлөх эрхийг хөндөх ёсгүй учир уг асуудлуудыг бусдын өмчлөх эрхийг хөндөлгүйгээр мөн бүх оролцогчдын ашиг сонирхлыг ханган шийдвэрлэх шаардлагатай юм.

**Олон нийтийн оролцоо.** Калифорни муж даяар 2300 гаруй нутгийн Тогтвортжуулах агентлагууд бүртгэлтэй байдаг тул эдгээр агентлагуудыг хамтран нэг сав газрыг удирдах эрх олгосон байна. Үүний нэг амжилттай жишээ нь Сакраменто газар доорх усны захиргаа юм. Энэ захиргаа нь дөрвөн газраас бүрдэх бөгөөд 14 нутгийн усны болон газар тариалангийн агентлаг болон ус татуургын аж ахуй эрхлэгчдээс бүрдэх 16 гишүүн бүхий удирдах зөвлөлөөр дамжуулан Хойд бүсийн сав газрыг удирддаг. Ингэснээр шийдвэр гаргах үйл явцад газар тариалан, байгаль орчны бүлгүүд, эмзэг бүлгийнхэн болон бусад ГДУ-ны харилцагчид оролцох боломжтой болдог байна.

Үүнээс гадна, сав газрууд нь хоорондоо холбоотой учир тэдгээрийн хилийг тогтоон мэдээллийн системд бүртгэх нь маш чухал.

**Хил тогтоох.** Сав газар болон дэд сав газрын хилийг цэвэр геологийн аргаар тогтоон хот, орон нутгийн удирдлагын газар зүйн бүтцийг харгалзах ёсгүй. Үүний нэг жишээ нь Санта Мариагийн сав газар юм. Уг сав газрын хилийг тогтооход жил гаруй хугацаа өнгөрсөн. Үр дүнд нь уг сав газрын менежментэд оролцохыг хүсээгүй талуудыг гидрологийн нэг сав газарт байршиж байна гэх үндэслэлээр шүүх албадан оролцуулсан.

**Нэгдсэн мэдээллийн систем.** Сав газрыг хамгаалахын тулд сав газар болгоны мэдээллийг цуглуулах шаардлагатай. Энэхүү мэдээллийн системд сав газрын дагуух урсгал, ГДУ-ны түвшин, чанарын талаарх орон зайд, цаг хугацааны мэдээлэл, суулт, газар доорх болон газар дээрх усны харилцан хамаарал, далайн усны халдлага, ГДУ-наас хамаарал бүхий экосистем, усны хэрэгцээ, цэнэглэх бүс гэх мэт мэдээллийг агуулдаг.

Түүнээс гадна ГДУТМХ-д Тогтвортжуулах төлөвлөгөөний мониторинг, шинэ технологийн дэмжлэг, санхүүжилтийн асуудал болон оролцогчдын хамтын ажиллагааг хангах талаар зохицуулсан байна.

## **АЮУЛГҮЙ ҮНДНЫ УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ БА НЭВЧҮҮЛЭХ ХУДАГ**

Ус болон бусад химийн нэгдлүүдийг газарт шахах Газар доорх нэвчүүлэх худаг нь маш олон төрлийн зориулалтаар ашиглагддаг. АНУ-ын Байгаль орчин хамгаалах агентлаг нь 850 000 гаруй нэвчүүлэх худгийг Газар доорх нэвчүүлэх худгийн хяналтын хөтөлбөр болон Аюулгүй үндны усны тухай хуулийн дагуу зохицуулдаг. Эдгээр худгуудын хяналтыг мужийн түвшинд хэрэгжүүлэн удирддаг байна.

Байгаль орчин хамгаалах агентлаг нь нэвчүүлэх худгийн хэрэглэх хэлбэрээс шалтгаалан 6 ангилалд хуваадаг.

**1-р ангилал:** Аж үйлдвэрлэл болон орон нутгийн хаягдал зайлцуулах. Эдгээр худгууд нь маш гүн чулуулаг тогтоц, ихэвчлэн гадаргаас мянга гаруй метрийн гүнд хортой болон хоргүй хаягдлыг нэвчүүлдэг. Хаягдлууд нь олон төрлийн аж үйлдвэрээс гардаг хаягдлууд буюу шатахуун боловсруулалт, үйлчилгээний хог хаягдал, орон нутгийн бохир ус болон хоол хүнс, химийн бодис, төмөрлөг болон эмийн бэлдмэл үйлдвэрлэлийн хаягдлууд багтана. АНУ-д 1-р ангиллын 800 гаруй нэвчүүлэх худаг байдаг.

**2-р ангилал:** Газрын тос, байгалийн хийтэй холбоотой нэвчүүлэх худаг. Энэхүү худаг нь АНУ-д 180 000 гаруй байдаг бөгөөд эдгээр нь гурван дэд ангилалд хуваагдана. Үүнд:

1. Хаягдлын худаг. Газрын тос болон байгалийн хийн аж үйлдвэрийн хаягдал ус зайлцуулах, үүнд, газрын тос болон байгалийн хийн олборлолтой хамт гарч ирсэн ус болон гидравлик хагарал үүссэний дараа гадаргуу руу буцах урсгал ус зэрэг багтана. Нийт 2-р ангиллын худгийн 20%-ийг эзэлдэг.
2. Сайжруулсан сэргээх худаг. Газрын тос агуулах тогтцод (мөн зарим тохиолдолд байгалийн хий агуулдаг тогтцод) нөөцийг сэргээх зорилгоор шингэн бодис шахах худаг юм. 80%-ийг эзэлнэ.

3. Гидрокарбон хадгалах худаг. 100 ширхэг л байдаг бөгөөд АНУ-ын Түлшний стратегийн нөөцийн бодлогын дагуу газрын тос болон бусад төрлийн шингэн гидрокарбоныг нөөцлөх худаг юм.

**3-р ангилал: Уурхайн шингэн шахах худаг.** Эрдсийг задрааж, бий болох эдийг гадаргууд татан олборлох зорилгоор шингэн бодисыг шахах худаг. Ихэвчлэн давс болон уран олборлолтод ашиглана. Энэ төрлийн худаг 18 500 гаруй ширхэг байдаг бөгөөд ихэнх хувийг уран, 5%-ийг давс олборлоход ашигладаг бол зэс олборлох цөөн тооны худаг байдаг.

**4-р ангилал: Бага зэргийн аюултай болон цацраг идэвхт бодис нэвчүүлэх худаг.** Энэхүү төрлийн худаг нь аюултай болон цацраг идэвхт бодисыг зайлцуулах зорилгоор ундны усны давхарга руу эсхүл дээгүүр нь шахдаг худаг бөгөөд 1984 онос хойш хориглогдсон байна. Одоо зөвхөн газар доорх усыг цэвэршүүлэх зорилгоор ашигладаг 32 худаг байдаг.

**5-р ангилал: Ундны усны газар доорх эх үүсвэр лүү эсхүл түүний дээгүүр шингэн шахах худаг.** 4-р ангиллын худагтай адил боловч аюултай бодис нэвчүүлдэггүй юм. Энэхүү ангиллын худаг нь хамгийн түгээмэл бөгөөд арав гаруй төрлийн 650 000 гаруй худгууд байдаг. Ихэвчлэн борооны ус зайлцуулах худаг болон септик системд хүрдэг худгууд байдаг. Зарим нэг төрлийн худгуудаас дурдвал:

- Ундны ус цэвэршүүлснээс үлдсэн бодисыг зайлцуулах
- Орон нутгийн бохирдол зайлцуулах
- Шахсан ус нь халаад цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор ашиглах геотермийн худаг
- Барилгын цаг уурын хяналтын зорилгоор усыг халаах эсхүл хөргөх худаг
- Уст давхарга тэжээх

**6-р ангилал: Карбон диоксидыг геологийн тусгаарлалтын худаг.** Энэхүү худаг нь газар доорх гүн чулуун тогтцод удаан хугацаагаар карбон диоксидыг тусгаарлах зорилготой бөгөөд энэ төрлийн худгууд 2011 онд бий болсон байна.

Доорх хүснэгтэд АНУ-ын газар доорх усны (ГДУ) эрх зүйн зохицуулалтыг муж бүрээр гаргасан болно.

Муж	ГДУ-ны эрхийн хуваарилалтын хэлбэр	ГДУ хуваарилалтын эзэмбэлэй эсэх	ГДУ ашиглалтын зөвшөөрөлтэй эсэх	Зөвшөөрлийн хугацаа	Хууль тогтоомж	Захиргааны байгууллага	Тайлбар
Алабама	Зохистой хэрэглээ	Үгүй	Тийм	5-10 жил	1975 оны Алабамагийн Хууль Бүлэг 22 (Title 22 Code of Alabama 1975)	Алабама мужийн Эдийн засаг, олон нийттэй харилцах газар	ГДУ-ыг өөр усны орд руу шилжүүлэх нь донор ордын усны түвшин, нөлөөллийн шинжилгээ, байгаль орчин, эдийн засгийн үр дүнгийн тооцооны үндсэн дээр хийнэ. Алабама муж нь тусгай зөвшөөрөлгүйгээр газар доор аливаа бохирдуулагч шахахыг хориглодог байна (хаягдал ус). <i>Underground injection well</i> буюу ил, далд нэвчүүлэх байгууламж барих, хяналт тавихад тусгай зөвшөөрөл шаардлагатай. Ундны усны цооног тогтоох, худаг барих, ажиллуулах, усны чанар шалгах харилцааг зохицуулдаг.
Аляск	Давуу эрхий эзэмшил	Тийм	Тийм	Тийм	Аляскийн Хууль, 46-р бүлэг, 46.15 Усны хэрэглээний хууль	Байгалын нөөц газрын Газар болон усны менежментийн хэлтэс	Муж нь газар доорх усны ёмчлэгч мөн бөгөөд ГДУ нь иргэдэд зориулагдсан гэж заажээ. Дүрмийн дагуу газар зарагдсан тохиолдолд ус нь

							мөн адил газрын хамт шилжих боловч Байгальн нөөцийн газрын Газар болон усны менежментийн хэлтэс усыг газраас салгах тухай шийдвэр гарвал ГДУ газар өмчлөгчид шилжихгүй. ГДУ ашиглах зөвшөөрлийг олгох хугацаа нь ГДУ-ны хэмжээ болон чанараас шалтгаална. Мөн усыг 5-с доош жилийн хугацаатайгаар ашиглах бол түр ашиглах зөвшөөрөл өгч болно.
Аризона	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм	50 жил хүртэл	(A.R.S 45-р бүлэг "Ус") Аризонагийн ГДУ-ны менежментийн хууль	Аризонагийн усны нөөцийн газар	Муж нь ГДУ-ны өмчлөгч мөн. Аризонагийн ГДУ-ны менежментийн тухай хууль нь ус таталт, шилжүүлэлт, ашиглалт, хадгалалтын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах замаар ГДУ-ыг хадгалах, хамгаалах, хуваарилахыг зорьдог байна. Энэхүү хуулийн зорилго нь (1) хэтрүүлэн ашиглалтын хяналт, (2) мужийн нэмэгдэж буй усны хэрэглээнд хязгаарлагдмал нөөцтэй ГДУ-ыг хуваарилах зохимжтой шийдэл бий болгох, (3) Аризонагийн усан хангамжийг сайжруулах замаар газрын доорх усыг

								нэмэгдүүлэх юм.
Арканзас	Зохистой хэрэглээ болон Харилцан хамааралтай хэрэглээ	Тийм	Тийм	50 жил	Газар доорх ус хамгаалах, менежментийн дүрэм — Арканзас дүрэм Бүлэг 4, 401 - 407 (Title IV Arkansas Regulation (AR Reg.) 401-407)	Арканзасын Хөрс болон ус хамгаалах хороо	Усны эрхийн холимог тогтолцоотой. ГДУ нь газар өмчлөгчийн өмчлөлд байх боловч усны зохистой ашиглалтаа нотолсны үндсэн дээр ус ашиглах зөвшөөрөл авна. Ус ашиглах зөвшөөрлийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 3 дугаар сарын 1-ний өдөр хүртэл олгодог. ГДУ-ны асуудалтай газруудад мужийн захиргааны хяналт өндөртэй. ГДУ-ны өөр ордруу шилжүүлэх нь зөвхөн шилжиж буй усны ордын ус хэтэрсэн тохиолдолд боломжтой. Хуулийн дагуу зөвхөн өнөөгийн болон ирээдүйн хэрэглээний 25%-тай тэнцэх усыг голын бус (proprietary transfer) шилжилт хийхийг зөвшөөрсөн байна. Ус ашиглалтын тайлагнал, мэдээлэл болон боловсрол, ус хадгалах, зардал хамтран хариуцах болон улсын тэмдэгтийн хураамжийн тогтолцоо муж даяар хэрэгждэг.	
Калифорни	Зохистой	Тийм	Үгүй	Үгүй	Газар доорх	Мужийн усны	Усны эрхийн холимог	

	хэрэглээ болон Харилцан хамааралтай хэрэглээ		(зарим онцгой тохиолдол бий)		усны тогтвортой менежментийн тухай хууль	нөөцийн хяналтын зөвлөл/ Усны эрхийн хэлтэс	тогтолцоотой. Үүний үндсэн дээр нэг эх үүсвэрээс ус хуваан хэрэглэх боломжтой болсон. Одоогийн байдлаар газар өмчлөгч ГДУ-ыг өмчилдөг бөгөөд бусадтай эрх нь тэгш, харилцан хамааралтай байдаг. Газар эзэмшдэггүй этгээд газар өмчлөгчөөс ус авах боломжтой. Ус шахалтыг дүүрэг, хороодын нутгийн захиргаа хариуцдаг. ГДУ нь 3 төрөлтэй: (1) газар доорх горхи, хөндийгөөр урсдаг, (2) гадаргын урсцын газар доорх урсгал. Хөрс, элс, хайрга дунд урсдаг ус бөгөөд гадаргын устай холбоотой байх ёстой. (3) нэвчих ус буюу харьцангуй сийрэг давхаргаас илүү гүнд орших сав газар луу нэвчдэг усыг хэлнэ.
Колорадо	Давуу эрхий эзэмшил	Тийм	Тийм (зарим онцгой	Хамгийн багадаа 1 жил	1965 оны Газар доорх усны менежментийн	Колорадогийн Усны нөөцийн хэлтэс	Усны хомсдлын үед тэргүүн ээлжинд ахуйн хэрэглээг хангадаг бөгөөд дараа нь газар

			тохиол- дол бий)		тухай хууль, 1969 оны Усны эрх тодорхойлох болон зохицуулах хууль	Мужийн инженер, Колорадогийн газар доорх усны хороо	тариалан болон аж үйлдвэрлэлд ашиглана. ГДУ-ыг газар зүйн байршил болон гадаргуун усны нөлөөллөөр ангилсан байна.
Коннектикут	Үнэмлэхүй өмчлөх эрх	Үгүй	Тийм (зарим онцгой тохиол- дол бий)	25 жил	Коннектикутын ерөнхий хууль, 22A хэсэг, 446 <sup>b</sup> бүлэг Усны бохирдол, 22а- 454 <sup>b</sup> ГДУ-ны мониторинг	Байгаль орчин хамгаалах газар/ Дотоодын усны нөөцийн хэлтэс	ГДУ нь газар өмчлөгчийн өмч мөн. Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан ГДУ-ны голдирлыг өөрчлөх зөвшөөрөл олгодог. Ус ашиглах зөвшөөрлийг ус хангамжийн шаардлага, одоогийн болон төлевлөгдсөн ашиглалтад болон загас, амьтан, орчин тойронд үзүүлэх нөлөөг харгалзан олгоно. ГДУ- ыг өөр усны орд руу шилжүүлэхийг зөвшөөрлийн үндсэн дээр хийх бөгөөд донор сав газрын нарийвчилсан үнэлгээ шаардана.
Делавэйр	Харилцан хамааралта й хэрэглээ	Тийм	Тийм	30 жил	Делавэйр Байгаль орчин хамгаалах хууль	Байгалийн нөөц, Байгаль орчны хяналтын газар/ Усны нөөцийн хэлтэс	Газар өмчлөг ГДУ-ыг мөн адил өмчилнэ. ГДУ-ыг ашиг олох зорилгоор ашиглах тохиолдолд зөвшөөрөл шаардлагатай. Зөвшөөрөл нь сав газрын хэтрүүлэн ашиглалтыг хязгаарлах, бохирдуулагч оруулахаас сэргийлэх болон бусад хэрэглэгчдэд сөрөг нөлөө

								үзүүлэхгүй байх нөхцөлтэйгээр олгогдоно. Онцгой байдал зарласан тохиолдолд усыг амьдрал, эрүүл мэнд, баялаг гэх зорилгуудад энэхүү дарааллаар хэрэглэнэ.
Флорида	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм	20 жил хүртэл	2016 оны Булаг болон уст давхарга хамгаалах тухай хууль,	Байгаль орчин хамгаалах газар		ГДУ-ны хэрэглээний дараалал нь хэрэглээний зорилго болон хэмжээнээс шалтгаална. Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай, амралт болон бусад хэрэгцээг хангана. ГДУ-ны сав газраас ус татах тохиолдолд зөвшөөрөл авах бөгөөд ахуйн хэрэгцээний худаг болон гол унтраахтай тэмцэх зорилгоор хэрэглэх тохиолдолд зөвшөөрөл шаардлагагүй. ГДУ-ыг таван усны менежментийн дүүргүүдэд хуваадаг бөгөөд тэдгээртэй хамтран Флоридагийн БО хамгаалах газар усны хэмжээ болон чанарт хяналт тавин, Флоридагийн Усны төлөвлөгөө болон бодлогыг хэрэгжүүлдэг байна.
Жиоржия	Үнэмлэхүй	Тийм	Тийм	10 жил	1972 оны Газар	Флоридагийн	Үнэмлэхүй өмчлөх эрх нь	

	өмчлөх эрх болон Зохистой хэрэглээ		(зарим онцгой тохиолдол бий)		доорх ус ашиглалтын тухай хууль, 1985 оны Усны худгын стандартын тухай хууль	Байгалийн нөөцийн газар	аажмаар нөхөгдөх уст давхаргын нэвчих усанд хамааралтай бол Зохистой хэрэглээ нь хурдан нөхөгдөх газар доорх горхид хамааралтай байна. Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай, амралт болон бусад хэрэгцээг хангана.
Хавай	Харилцан хамааралтай хэрэглээ	Тийм	Тийм	Хугацааг үй (зарим онцгой тохиолдол бий)	174C-HRS 1987;13-167,168,169,170, 171 - HAR 1988	Усны нөөцийн удирдлагын хороо	Газар өмчлөгч ГДУ-ыг өмчилнө. Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай, амралт болон бусад хэрэгцээг хангана. Ахуйн хэрэглээнд ГДУ-ыг ашиглах тохиолдолд зөвшөөрөл шаардлагагүй.
Айдахо	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм	5 жил	Айдахо Код, 42 дугаар хэсэг	Усны нөөцийн газар	Айдахо Код, 42 дугаар хэсэг нь ГДУ-ны хуваарилалт, захиргаа болон удирдлагыг зохицуулна. Ус нь нийтийн өмч гэж үздэг бөгөөд тусгай хүсэлт гаргаж зөвшөөрөл авсны үндсэн дээр ГДУ ашиглах эрхтэй болно.
Иллиной	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм (зарим онцгой	Янз бүр	ГДУ-ны чанар 1991 оны Иллиной	Байгалийн нөөцийн газар	ГДУ-ны чанарын стандартыг дагаж мөрдсөнөөр ГДУ-ны ирээдүйн болон одоогийн

			тохиол- дол бий)		Захиргааны Хууль 35 хэсэг 620-р зүйл, 601, 615-617-р зүйлүүдээр Техникийн стандартыг зохицуулна. (IL Adm. Code 620, Groundwater Quality 1991 35 IL Adm. Code 601, 615, 616 and 617, Technical Standards, 1991)		нөөцийг хамгаалах бодлого баримталдаг байна. Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар газар тариалан, аж үйлдвэр, уул урхай, амралт болон бусад хэрэгцээг хангана. ГДУ-ыг зөвшөөрлийн дагуу олгох бөгөөд үүний өмнө нөлөөллийн үнэлгээ хийнэ. .
Индиана	Үнэмлэхүй өмчлөх эрх	Тийм	Тийм	20 жил хүртэл	Усны нөөцийн менежмент - IC 14-25-7 (1983); Усны эрх: онцгой байдлын зохицуулалт - IC 14-25-4 & Rule 312 IAC 12 (1983)	Байгалийн нөөцийн газар/ Усны хэлтэс	ГДУ ашиглалтын тодорхой хууль тогтоомжгүй, Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар газар тариалан, мал аж ахуй, аж үйлдвэр, уул уурхай, амралт болон бусад хэрэгцээг хангана.
Айова	Харилцан хамааралта й хэрэглээ	Тийм	Тийм	10 жил хүртэл	1987 оны ГДУ- ны хамгаалалтын тухай хууль	Байгалийн нөөцийн газар	ГДУ-ны бохирдолтоос хамгаалахын тулд ГДУ-ны хамгаалалтын тухай хуулийг баталсан байна. Энэхүү хуулиар ус хамгаалалтын

							төсвийг нэмэгдүүлэхийн тулд (1) пестицид үйлдвэрлэгчийн тусгай зөвшөөрлийн хураамж (2) пестицид диллерийн тусгай зөвшөөрлийн хураамж (3) бордооны татвар.
Канзас	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм	5 жил хүртэл	Канзасын ус хуваарилалтын хууль, K.S.A. 82a-730.	Мужийн хөдөө аж ахуйн зөвлөл	ГДУ-ны Менежментийн дүүргүүдэд тусгай зохицуулалттай. Муж нь ГДУ-ны өмчлөгч мөн бөгөөд бусад этгээдүүд зөвшөөрлийн үндсэн дээр ГДУ-ыг ашиглана. Зөвшөөрөл эзэмшигч нь ус ашиглалтын газар зүйн байрлал, усны төрөл болон урсгалын чиг өөрчилж болдог байна.
Кентуки	Зохистой хэрэглээ	Үгүй	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Байхгүй		Байгалийн нөөц, байгаль орчин хамгааллын газар / Усны хэлтэс	ГДУ ашигладаг нийтийн ус түгээгүүрийн сүлжээ нь Худгийн эх сурвалж хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Түүнчлэн ГДУ-ыг бохирдуулах магадлалтай этгээдүүд ГДУ хамгаалах төлөвлөгөө боловсруулна.
Луизиана	Үнэмлэхүй өмчлөх эрх	Үгүй	Үгүй	Байхгүй	Захиргааны хууль, 43 бүлэг, 6-р хэсэг, 1-р дэд хэсэг- Усны нөөц.	Тээвэр хөгжлийн газар/ Нийтийн ажил, үерийн удирдлагын	Луизианагийн Иргэний хууль газар өмчлөгч гадаргын болон газрын доорх бүх зүйлийг өмчилнө гэж заасан байдаг боловч Луизианагийн Ашигт

						газар	малтмалын тухай хууль нь ГДУ-ыг газар өмчлөгч татан авч гадаргууд гаргах хүртэл ГДУ нь түүний өмчлөл биш хэмээн заажээ.
Мэйн	Үнэмлэхүй өмчлөх эрх	Үгүй	Үгүй	Байхгүй	Том хэмжээний ГДУ-ны худгийн хууль, Усны шилжүүлгийн тухай хууль	Мэйний Хамгаалалтын газар	Эдгээр гурван хууль нь гадаргын болон газар доорх усанд тус тус хамааралтай байна. Газар өмчлөгч ГДУ-ыг мөн өмчлөх боловч нэг өрхийн хэрэглээнээс давсан ус татсан эсхүл өмнө нь ус хэрэглэж байсан өрхийн хэрэглээнд нөлөөлсөн тохиолдолд хариуцлага хулээнэ.
Мэрилэнд	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	12 жил хүртэл	Байгаль орчны хууль, Мэрилэндийн шинэчлэгдсэн код	Мэрилэндийн Байгаль орчны газар/ Усны эрхий хэлтэс	Газар өмчлөгч ГДУ-ыг мөн адил өмчилнэ. Орон нутгийн хэрэгцээнд ашиглагдах усны эрх давуу бөгөөд түүний дараагаар газар тариалан, аж үйлдвэрийн ашиглалт орно.
Массачусетс	Үнэмлэхүй өмчлөх эрх	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	20 жил хүртэл	Усны менежментийн тухай хууль, Усны ордын шилжилтийн тухай хууль, Ундны усны тухай хууль	Байгаль орчин хамгаалах газар/ Усны сав газрын удирдлагын алба	Газар өмчлөгч нь хөршүүдийнх нь эрх хөндөгдсөн ч ГДУ-ны ашиглалтын хариуцлага хүлээхгүй. ГДУ-ны давуу эрхийг түрүүлж ГДУ ашиглаж эхэлсэн зөвшөөрөл эзэмшигч эдэлнэ.
Мичиган	Ашгийн	Үгүй	Тийм	Байхгүй	Аюулгүй ундны	Мичиганы	ГДУ ашиглалтын зөвшөөрөл

	төлөөх зарчим Гэм хорын хоёр дугаар Ристэйтмен т 858		(зарим онцгой тохиолдол бий)		усны тухай хууль, Байгалын нөөц, байгаль орчин хамгаалах тухай хууль, Нийтийн эрүүл мэндийн тухай хууль – Ус хангамж, ариутгах татуургын хэсэг.	Байгалийн нөөцийн газар/ Усны нөөцийн хэлтэс	шаардлагатай. Зөвшөөрөл нь тодорхой хугацаагүй байна
Миннесота	Харилцан хамааралтай хэрэглээ	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Байхгүй	Миннесотагийн хууль 103А бүлэг. Миннесотагийн зөвшөөрөл, шалгалт, хяналтын дүрэм.	Байгалийн нөөцийн газар / Усны хэлтэс	Газар өмчлөгч нь мөн ГДУ-ыг өмчилнэ. >1000 gpd-с дээш ус ашиглах томоохон байгууламж нь зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана. Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар орон нутаг, газар тариалан, эрчим хүч болон бусад хэрэгцээг хангана
Миссисипп и	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм	10 жил хүртэл	Миссисиппигийн шинэчлэгдсэн хууль 51-3-1 ээс 51-3-107 хүртэл, Гадаргуун болон газар доорх ус ашиглалт болон хамгаалалтын дүрэм	Байгалийн нөөцийн газар/ Газар ба усны нөөцийн товчоо	ГДУ нь мужийн өмчлөлд байна. Хэрэглээний ашиг тусаас шалтгаалан дараах давуу эрхийн дараалалтай: нийтийн усан хангамж, аж ахуй болон аж үйлдвэрийн, зэрлэг амьтдын хамгаалал, ургамлын усжуулалт болон бусад.
Миссури	Зохистой	Тийм	Тийм	Байхгүй	Усны худгийн	Байгалийн	Газар өмчлөгч ГДУ-ыг ашиглах

	хэрэглээ				өрөмдлөгийн тухай хууль, томоохон ус ашиглагчдын тухай хууль, Усны нөөцийн хууль, Бөхир зайлцуулагч худгийн тухай хууль	нөөцийн газар/ Геологи, газрын судалгааны хэлтэс	эрхийг өмчилдөг боловч усыг нь өмчлөхгүй. Ахуйн хэрэглээнд тэргүүлэх ач холбогдол өгдөг бөгөөд түүний дараагаар орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай болон аялал жуулчлал болон бусад.
Монтана	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Тийм (янз бүр)		Байгалийн нөөц, хамгаалалтын газар/ Усны нөөцийн хэлтэс	Усыг муж өмчилдөг бөгөөд зөвшөөрлийн дагуу усыг ашиглах эрхтэй байна. ГДУ ашиглах зөвшөөрөл нь гурван төрөлтэй, үүнд: богино хугацааны зөвшөөрөл, түр зуурын зөвшөөрөл – зөвшөөрөл албан ёсоор шийдвэрлэгдэх хүртэл ус ашиглах, үндсэн зөвшөөрөл.
Небраска	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Байхгүй	Небраскагийн ГДУ-ны менежмент, хамгаалалтын тухай хууль	Усны нөөцийн газар	Газар өмчлөгч ГДУ-ыг мөн адил өмчилнө. Ус ашиглахад тусгай зөвшөөрөл шаардагдахгүй хэдий ч бүх худаг, байгууламжууд нь заавал бүртгэгдэх ёстой. ГДУ ашиглах зөвшөөрөл нь зөвхөн хяналтын бүсэд шаардлагатай. Ус таталтын хэмжээнд хязгаарлалт байхгүй болно.

Невада	Давуу эрхий эзэмшил	Тийм	Тийм	5 жил хүртэл	Невадагийн шинэчлэгдсэн хууль 533 болон 534-р бүлэг.	Хамгаалалт, байгалийн нөөцийн газар/ Усны нөөцийн хэлтэс	Муж нь ГДУ-ын өмчлөгч мөн болно. Тэргүүн ээлжинд ахуйн хэрэгцээг хангаж түүний дараагаар орон нутаг, аж үйлдвэр, газар тариалан, уул уурхай болон бусад хэрэгцээг хангана. Худаг болон усны байгууламж барихын өмнө заавал ГДУ ашиглах зөвшөөрөл авна. Ахуйн хэрэглээнд зөвшөөрөл шаардлагагүй.
Нью Хэмпшир	Зохистой хэрэглээ болон харилцан хамааралтай хэрэглээ	Үгүй	Тийм	Янз бүр	Нью Хэмпшир Газар доорх ус хамгаалах тухай хууль, Нью Хэмпшир Үндны ус хамгаалах тухай хууль	Байгаль орчны үйлчилгээний газар / Усны нөөцийн хэлтэс	Муж нь ГДУ-ыг өмчилдөг, Газар өмчлөгч ус ашиглах эрхтэй боловч усыг өмчлөхгүй юм. 1998 оноос хойш баригдсан 57,600 gpd-с дээш хүчин чадалтай худганд зөвшөөрөл авна. Томоохон ус таталтаас ГДУ-аа хамгаалах бодлого явуулдаг.
Нью Жерси	Харилцан хамааралтай	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	5-10 жил шинэчлэх тогтоож болно	Усны хуваарилалтын зөвшөөрлийн дүрэм (N.J.A.C. 7:19) 1983. Усны нийлүүлэлтийн менежментийн тухай хууль (N.J.S.A. 58:1A)	Байгаль орчин хамгаалах газар/ Ус хуваарилалтын товчоо	Ус нь мужийн эрх мэдэлд байдаг. Тухайн газрын нөөц болон нөөц ашиглагчдад хохирол учруулахгүй тохиолдолд голдирол өөрчлөх зөвшөөрөл олгож болно. Үндны усны бус салбарын үйлдвэрлэл болон усалгаанд тэргүүн ээлжинд чанар багатай ус ашиглах эрх олгоно. Үндны

							усны үйлдвэрлэлт сайн чанарын ус ашиглах эрх олгоно. Зөвшөөрөл хүсэгч нь шаардлагатай усны чанараа нотолно.
Нью Мехико	Давуу эрхийн зарчим	Үгүй	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Хамгийн багадаа 1 жил	Нью Мехико Усны чанарын тухай хууль (NMSA 1978, Sections 74-6-1 through 74-6-17)  Нью Мехико Усны чанарын хяналтын зөвлөлийн дүрэм (20.6.3 NMAC) Нью Мехико Усны хууль (N.M.S.A. 1978 § 72-12-1 through 78-13-12	Мужийн инженерийн алба	Ус нь мужийн өмч. Ашигтай хэрэглээ ус ашиглах зөвшөөрөл авах боловч хуулинд “ашгийн төлөө” гэдэг нэр томьёог тодорхойлоогүй байна. Ихэвчлэн үүнд газар тариалан, хот суурин, ахуйн хэрэглээ, худалдаа болон аж үйлдвэрлэлд зориулахыг хэлнэ. Сав газар хооронд ус шилжүүлэх нь зөвшөөрлийн үндсэн дээр боломжтой. Зөвшөөрөл олгохын өмнө Нью Мехикогийн усны нийлүүлэлт, усны хэрэгцээ, усны хомсдлын түвшин болон нөлөөллийн үнэлгээг харгалzan үзэх шаардлагатай байна.
Нью Йорк	Зохистой хэрэглээ	Үгүй	Тийм	Байхгүй	NYS ECL 15-1525.	Байгаль орчин хамгаалах газар/ Усны зөвшөөрлийн товчоо	1905 оноос хойш ГДУ ашиглахад зөвшөөрөл шаарддаг болсон байна. Зохистой хэрэглээг нотолж байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үндсэн дээр олгоно.
Хойд	Зохистой	Тийм	Тийм	10 жил	Ус ашиглах	Байгалийн	ГДУ нь мужийн өмчлөлд байна.

Каролина	хэрэглээ		(зарим онцгой тохиолдол бий)	хүртэл	тухай хууль 1967 (G.S. 143-215.11-22, 1967-2009), Ус таталт болон шилжүүлгийн талаарх бүртгэл(G.S. 143-215.22G )	нөөц, орон нутгийн хөгжлийн газар/ Усны нөөцийн хэлтэс	Усыг эрэмбийн дагуу ашиглана. Ахуйн хэрэглээ давуу эрх эдэлж цаашид орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр болон бусад хэлбэрээр ашиглах эрх орно. Гэсэн ч эдгээрээс нэн тэргүүн ээлжинд гал түймэр унтраах зорилгоор ус ашиглана. Ус ашиглах зөвшөөрлийг тодорхой хамгаалалтын бүсэд л шаардана. 1989 оноос орон нутгийн бүх захиргаа ус хангамжийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай болсон байна.
Хойд Дакота	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Байдаг	Хойд Дакотагийн Үндсэн хууль 11-р зүйл, (1889). NDCC61-01 (Мужийн ус). NDCC 61-03 (Мужийн инженер). NDCC 61-04 (Ус хуваарилалтын дүрэм). NDAC 89- 03-01(Усны зөвшөөрөл).	Мужийн усны хороо	Бүх ус нь мужийн өмч. Нэг усны нөөцөөс хэд хэдэн этгээд ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд дараах эрэмбээр зөвшөөрөл олгодог байна, 1. Ахуйн хэрэглээ, 2. Орон нутгийн хэрэглээ, 3. Мал аж ахуй, 4. Усалгаа, 5. Аж үйлдвэр, 6. Загас, зэрлэг амьтад болон бусад.

Охайо	Ашгийн төлөөх зарчим Гэм хорын хоёр дугаар Ристэйтмен т 858	Үгүй	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	5 жил хүртэл	ORC 6111 – Усны бохирдлын хяналт; ORC 1521 – Хөрс болон усны нөөц;	Охайогийн байгаль орчин нөөцийн газар	Ус ашиглалтын давуу эрхийн эрэмбэ байхгүй. 100,000 gpd-с дээш ус татах тохиолдолд зөвшөөрөл авна. Зөвшөөрлийн үндсэн дээр сав газар хоорондын шилжүүлэг хийж болно.
Оклахома	Зохистой хэрэглээ болон Харилцан хамааралтай хэрэглээ	Тийм	Тийм	Байдаг	Бүлэг 82 Оклахомагийн хууль 1020.1 болон Оклахомагийн Захиргааны хууль 785:30	Оклахомагийн Усны нөөцийн зөвлөл	Муж нь ГДУ-ы зохистой ашиглалтын түвшинг тогтоож газар өмчлөгчдийн газрын хэмжээнээс хамаарч ус ашиглах эрхийн усны хэмжээг тогтооно. Ахуйн хэрэглээнд давуу эрх олгон, цаашид орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай болон бусад хэрэгцээ гэх дараалал үйлчилнэ. Ахуйн хэрэглээнээс бусад зорилгоор ашиглах тохиолдолд газар өмчлөгч нь зөвшөөрөл авна.
Орегон	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм	Байдаг	Орегоны шинэчилсэн хууль 537.535 зүйл (ГДУ-ны хуваарилалт) 537.730 зүйл (ГДУ-ны аюултай бүсийг тодорхойлох)	Усны нөөцийн газар	Ус нь мужийн өмч мөн болно. Ахуйн хэрэглээний ус нь давуу эрхтэй бөгөөд түүний дараагаар орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай болон бусад ашигтай хэрэглээ орно. Усны нөөцийн газар нь усны хамгийн ашигтай хэрэглээг ангилж, ус ашиглалт

					537.531 зүйл (Уст давхарга хадгалах ба нөхөн сэргээх) 537.747 зүйл (Худаг барих)		хязгаарлах болон түүний хэмжээг багасгах эрхтэй. Ус ашиглах эрхийг хэрэглээний эрэмбийн дарааллаар олгох ба тухайн мөчид ашиглалтад байгаа худгуудын харилцан хамаарлыг авч үзнэ.
Пенсильвани	Зохистой хэрэглээ	Үгүй	Тийм	25 жил хүртэл	1937 оны Цэвэр ууршилтын тухай хууль, 2002 Усны нөөцийн төлөвлөлтийн тухай хууль	Байгаль орчны нөөцийн газар/Усны нөөцийн удирдлагын товчоо	Газар өмчлөгч нь ГДУ-ны өмчлөгч мөн боловч зөвхөн зохистой хэрэглээнд усыг ашиглана. 10,000 gpd-ээс дээш ус таталтанд зөвшөөрөл шаардана.
Род Айлэнд	Үнэмлэхүй өмчлөх эрх	Үгүй	Үгүй	Байхгүй	Газар доорх усны хамгаалалтын хууль (RIGL 46-13.1); Усны бохирдлын тухай хууль (46-12); Намагшсан газрын хууль (2-1-20) болон бусад дүрэм журам	Усны нөөцийн зөвлөл	Газар өмчлөгч нь ГДУ-ны өмчлөгч мөн. Ус ашиглах зөвшөөрөл авах шаардлагагүй. Сав газар хоорондын шилжилт зөвшөөрөгдөх боловч их хэмжээний шилжилтэд Усны нөөцийн зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай.
Өмнөд Каролина	Зохистой хэрэглээ	Үгүй	Тийм (зарим онцгой тохиол-	Үгүй	1969 оны Газар доор ус ашиглалт, тайлагналтын	Усны нөөцийн хороо	Газар өмчлөгч нь ГДУ-ны өмчлөгч мөн. Хэрэглээний давуу эрхийн эрэмбэ тогтоогоогүй боловч Ган

			дол бий)		тухай хууль		гачгийн хариу арга хэмжээний тухай хуулиар онцгой байдал үүссэн тохиолдолд ахуй хэрэглээг эхний ээлжинд хангах бөгөөд дараах дарааллаар бусад зорилгоор ашиглана орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай бусад.
Өмнөд Дакота	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм (зарим онцгой тохиол- дол бий)	Хураах хүртэл хүчинтэй	Өмнөд Дакотагийн кодчлогдсон хууль	Ус болон байгалийн нөөцийн газар/ Усны эрхийн хэлтэс	Мужийн нутаг дэвсгэр дээрх бүх ус нь иргэдийн өмч мөн. Ахуйн хэрэглээний ус нь давуу эрхтэй бөгөөд түүний дараагаар орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай болон бусад ашигтай хэрэглээ орно. Ахуйн хэрэглээнд зөвшөөрөл шаардагдахгүй боловч 25 gpt-ээс хэтэрсэн тохиолдолд шаардагдана.
Теннесси	Зохистой хэрэглээ	Үгүй	Тийм (зарим онцгой тохиол- дол бий)	Янз бүр	2000 оны Усны нөөцийн мэдээллийн тухай хууль, Теннессигийн шинэчилсэн хууль	Теннессигийн эрүүл мэнд, байгаль орчны газар/ Усны удирдлагын алба	Газар өмчлөгч нь ГДУ-ны өмчлөгч мөн. Ус ашиглалтад зөвшөөрөл шаардлагагүй боловч 10,000 gpd-ээс дээш ашиглалт бүртгүүлэх шаардлагатай. Сав хоорондын шилжүүлгийг зөвшөөрдөггүй.
Texas	Зохистой хэрэглээ	Тийм	Хамгаал алтын бүсэд байdag	Байхгүй	Техасын Усны хууль, Техасын Захиргааны хууль 356-р	Техасын усны хөгжлийн зөвлөл	Газар өмчлөгч нь ГДУ-ны өмчлөгч мөн бөгөөд ашигт малтмалтай адил зохицуулна. ГДУ хамгаалах бүсээс бусад

					бүлэг.		газарт Английн нийтийн эрх зүйн дүрмийг дагана. Газар өмчлөгч усаа ашиглах эрхтэй боловч санаатай, бусдыг хохигоохын тулд нөөцийг үр дүнгүй үрэгдүүлэхийг хориглоно.
Юта	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм	Тийм	Ютагийн хууль, Хэсэг 73-3, 1935 оноос усны журам гаргахыг хуульчилсан.	Байгалийн нөөцийн газар/ Усны эрхийн хэлтэс	ГДУ-ыг муж өмчилнө. Юта муж нь ГДУ-ыг гурван төрөлд хувааж үздэг бөгөөд тухай бүрт ус ашиглалтын дүрэм нь өөр байна. ГДУ-ны гурван төрөлд (1) газар доорх урсгал (2) гүний урсгал (3) нэвчих ус.
Вермонт	Харилцан хамааралта й эзэмшил	Үгүй	Тийм	Тийм (янз бүр)	Байгаль орчны хамгаалах дүрэм, Бүлэг 12, Газар доорх ус хамгаалах дүрэм. Байгаль орчны хамгаалах стратегийн дүрэм, Бүлэг 24, Газар доорх ус таталтын тайлагнал болон зөвшөөрлийн дүрэм.	Вермонтын байгаль хамгааллын газар/ Усны эрхийн хэлтэс	Газар өмчлөгч нь газар доорх усыг мөн өмчилнө. 15,2 метрээс гүн болон 25,000 gpd-ээс дээш хүчин чадалтай худаг ус ашиглах зөвшөөрлийн үндсэн дээр баригдаж болно.

Виржиния	Зохистой хэрэглээ	Тийм	Тийм	10 жил хүртэл		Мужийн усны хяналтын зөвлөл	Газар өмчлөгч нь газар доорх усыг мөн өмчилнө. Усны тэжээлд нөлөөлөх тохиолдолд усыг ус таталтын газраас гадуур зарахыг хориглоно.
Вашингтон	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Байдаг	Газар доорх усны нөөцийн тухай хууль болон бусад хууль	Экологийн газар	ГДУ-ыг муж өмчилнө. 5,000 gpd-с дээш хүчин чадалтай ус татах байгууламжид зөвшөөрөл шаардлагатай. 5 жил дараалан ус ашиглаагүй тохиолдолд ГДУ нь дахин хуваарилалтад орно.
Баруун Виржиния	Зохистой хэрэглээ	Үгүй	Үгүй	Байхгүй	Баруун Виржиниягийн хууль Бүлэг 22, 12-р зүйл.	Усны нөөцийн газар/ Усны нөөцийн хэлтэс	Газар өмчлөгч нь газар доорх усыг мөн өмчилнө. Сав газар хоорондын ус шилжүүлгийн талаар зохицуулалт байхгүй.
Висконсин	Ашгийн төлөөх зарчим Гэм хорын хоёр дугаар Ристэйтмен т 858	Үгүй	Тийм (зарим онцгой тохиолдол бий)	Янз бүр	Висконсиний хууль Бүлэг 160, 281.34, Висконсиний Захиргааны хууль 850, 852, 856, 860.	Байгалийн нөөцийн газар / Усны нөөцийн удирдлагын товчоо	100,000 gpd-ээс дээш өндөр хүчин чадалтай худгуудад зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд зөвхөн олон нийтийн усны хангамжид нөлөөлөх тохиолдолд татгалзана.
Вайоминг	Давуу эрхийн эзэмшил	Тийм	Тийм	Байдаг	W.S. Title 41. Water State Engineer's Office Regulations and Instructions, Part II, Ground Water (1974) State Engineer's Office	Байгалийн нөөцийн газар/ Усны нөөцийн удирдлагын товчоо	Ахуйн хэрэглээний ус нь давуу эрхтэй бөгөөд түүний дараагаар орон нутаг, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхай болон бусад ашигтай хэрэглээ орно. Газрын төрлөөс шалтгаалан ус ашиглах эрх олгогдоно. Хяналтын бүсэд

					Regulations and Instructions, Part III, Water Well Minimum Construction Standards (2011).		зөвшөөрөл шаардагдах бөгөөд хүн шалгууруудыг давсны үндсэн дээр олгогдоно. Хяналтын бүсээс гадуур тохиолдолд ус ашиглалт нь ашигтай бөгөөд байгууламжийн барилга нь зохистой гэж үзсэн тохиолдолд зөвшөөрөл олгоно.
--	--	--	--	--	---	--	---

## КАНАД УЛС

Канад улсын усны хууль нь Английн нийтийн эрх зүйд тулгуурладаг бөгөөд эрт дээр үеэс газар доорх усны хэрэглээг гадаргын уснаас ялгадаг байсан. Газар дээрх ус нь эргийн эрхээр тодорхойлогддог байсан бол газар доорх усны хэрэглээ нь Үнэмлэхүй өмчлөх эрхийн дүрмээр зохицуулагддаг байна.

Усыг эргийн эрхийн дүрмийн дагуу ашигладаг этгээдүүд урсгалын доор оршиж буй этгээдүүдийн эрхийг зөрчихгүй байх үүрэг хүлээдэг байсан бол газар доорх ус ашиглагчид хөршид учруулах аливаа хариуцлага хүлээхгүйгээр усаа чөлөөтэй ашиглаж болдог байсан. Хэдийгээр гидрогеологийн салбар хөгжиж газар доорх усны ойлголт сайжирсан боловч Канадын газар доорх усны эрх зүйн зохицуулалт тогтвортой хэрэглээг дэмжих хэмжээнд хараахан хүрээгүй.

Газар доорх усны нөөцийн мэдээлэл хомс байдгийн улмаас газар доорх усны түвшин багасаж эсхүл ихсэж байгаа нь тодорхойлох аргагүй байгаагаас гадна төрөл бүрийн салбарын ашиглагчдын ашиглах хэв маягийг тодорхойлох хэцүү байдаг. Энэхүү мэдээллийн хомсдлоос оновчтой менежментийг тодорхойлох боломжгүй юм.

Канадын нийт иргэдийн 1/3 нь газар доорх усыг ахуйн хэрэглээндээ ашигладаг, үүний 80% нь орон нутагт амьдардаг байна. Үүнээс Онтарио муж нь газар доорх уснаас хамааралтай иргэдийн тоог 1.3 саяар тэргүүлдэг. Харин Принс Эдвардын арал тэр чигтээ цэнгэг усны хэрэгцээгээ газар доорх уснаас хангадаг байна. Газар тариалангийн хувьд янз бүр байдаг бөгөөд Манитобад 44% хүртэл ашигладаг бол Саскачеванд ердөө л 3%-ийг эзэлдэг. Канадын нийт орон нутгийн 25% нь сүүлийн 10 жилд усны хомсдолд орсон боловч газар доорх ус ашигладаг газар нутаг усны хомсдолд илүүтэй өртсөн байна. Газар доорх усны үзүүлэх байгаль орчны нөлөөнд газар доорх усны хомсдол, намгархаг газартай холбоотой эвдрэл болон далайн давсархаг усны халдлага зэрэг оржээ.

## ЭРХ ЗҮЙН ХАРЬЯАЛАЛ

Үндсэн хуулийн дагуу Орон нутгийн засаг захиргаа нь байгалийн нөөц болон тэдгээрийн өмчлөл эзэмшлийг зохицуулах эрхтэй учир усны нөөцтэй холбоотой харилцааг мужийн хуулиар зохицуулдаг. Иймд газар доорх усны зохицуулалт мөн адил мужийн эрх хэмжээнд байдаг байна. Холбооны Засгийн газар нь хил дамнасан ус, навигаци, загасны аж ахуй, олон улсын гэрээг зохицуулдаг бөгөөд Муж, Холбооны Засгийн газар нь эрүүл мэнд, аж ахуйг хамтаар хариуцдаг.

Мужийн газар доорх усны эрх зүйн зохицуулалтуудыг ихэвчлэн дараах агуулгаар ялгадаг. Үүнд:

- тусгай зөвшөөрлийн систем бий эсэх
- ус татуургын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний арга
- олон нийтийн оролцооны эрх г.м.

Ус ашиглах тусгай зөвшөөрөлд ашиглагдах усны хэмжээ, үргэлжлэх хугацаа, ашиглах цаг болон ус ашиглах зорилгыг тусгана.

Канадын ихэнх мужуудад өрхийн ахуйн хэрэглээнд зориулан гаргасан худганд тусгай зөвшөөрөл хамаардаггүй. Ашиглалтад зориулсан худганд тусгай хяналт тавьдаг бөгөөд тухайн худгийг өрөмдөж гаргах тоног төхөөрөмж нь хүртэл тусгай зөвшөөрөл авч техникийн үзлэгт заавал хамрагддаг байна. Канадын зарим муж нь худгийн бүртгэл болон тайлангаа олон нийтэд нээлттэй тавьдаг.

Түүнчлэн, Канадад олон нийт буюу иргэдийн оролцоог ихээхэн чухалчлах болсон. Жишээ нь Манитобагийн Усны эрхийн тухай хуулийн 6(4) дугаар зүйлд газар доорх ус ашиглалтын өргөдлийг хэлэлцэх явцад зөвшөөрөл олгохоос өмнө Орон нутгийн удирдлагад олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлнэ. Энэхүү хэлэлцүүлэгт иргэн нь өөрөө эсхүл зөвлөлөөр дамжуулан ус ашиглах эрх олгохыг дэмжих эсхүл эсэргүүцэхээр үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй байна. Хувь хүмүүст ус ашиглалтын зөвшөөрөл өгөх эсэхт саналаа өгч, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нь олгосноор тухай ус ашиглалтын зөвшөөрөл нь аливаа хувь хүн, хуулийн этгээдийн эрхийг хөндөхгүй байх, хөндөж байгаа тохиолдолд залруулах боломжийг нь олгодог. Мөн тухайн ус ашиглах зөвшөөрөл олгох нь олон нийтийн эрх ашгийг хөндөж залруулах боломжгүй бол олгохоос татгалзах нөхцөл мөн болох юм.

### КАНАДЫН ГАЗАР ДООРХ УСНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Муж	Эрх зүйн зохицуулалт	Хэрэгжүүлэгч байгууллага	Нэмэлт тайлбар
Британы Колумб	2004 оны Газар доорх усны хамгаалалтын журам	Байгаль орчны яам	Газар доорх усанд тусгай зөвшөөрөл шаарддаггүй цорын ганц муж. Худгийн бүртгэл нь олон нийтэд нээлттэй
Альберта	1962 оны Усны хууль Усны журам	Байгаль орчны яам	Худаг ашиглалтын талаар тайлан тавихыг шаарддаг бөгөөд үүнд худгийн газар зүйн байрлал, эх үүсвэр болон зорилгыг тусгадаг. Газар доорх усны олон нийтийн оролцоо болон гомдол гаргах ажиллагааг Усны хуулиар зохицуулдаг
Саскачеван	1959 оны Газар доорх ус хамгаалах тухай хууль, Газар доорх усны зохицуулалтын журам	Саскачеваны байгаль орчин, Саскачеваны усны корпораци, Саскачеваны Усны хагалбарын захиргаа	1959 оноос хойш худганд тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн бөгөөд 2004 оноос тайлагнах шаардлага тавьж эхэлсэн
Манитоба	1972 оны Усны	Усны нөөц	Тусгай зөвшөөрөл эзэмшигч

	эрхийн тухай хууль	зохицуулалтын алба	болгон тайлагнах үүрэгтэй
Онтарио	1961 оны Усны нөөцийн тухай хууль Ус шилжүүлэх, авах журам	Байгаль орчны яам	Уг яаманд жил болгон ус, худаг ашиглалтын тайлан гаргана. Олон нийтийн оролцоо нь Байгаль орчны эрхийн тухай хуулиар олгогддог
Квебек	2004 оны Байгаль орчны чанарын тухай хууль Газар доорх ус тогтоох журам	Тогтвортой хөгжил, байгаль орчин, цогцолборт газрын яам	Жилд 600 ширхэг худаг бөгөөд нэг бүр нь $75 \text{ м}^3$ дээш хэмжээний ус тогтоолт тусгай зөвшөөрөл авдаг ба эдгээр нь тайлагнах үүрэгтэй байна. Олон нийтийн оролцоо байхгүй, зөвхөн эрх нь хөндөгдөж буй этгээд гомдол гаргах эрхтэй
Шинэ Брансвик	Цэвэр усны тухай хууль болон Цэвэр байгаль орчны тухай хууль Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам Усны чанарын журам	Байгаль орчны яам болон нутгийн захиргаа хамтаар	Тусгай зөвшөөрлийн мэдээлэл олон нийтэд нээлттэй
Ньюфаундленд ба Лабрадор	Усны нөөцийн тухай хууль	Байгаль орчин болон хамгаалалтын алба	Жил бүрийн ус ашиглалтын тайлан шаарддаг, тусгай зөвшөөрөл олголтод олон нийтийн оролцоо зөвшөөрөгдсөн, гомдол гаргах эрх болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нээлттэй
Нова Скоша	1973 оноос Байгаль орчны тухай хууль	Байгаль орчин, хөдөлмөрийн алба	Усны хэрэглээг бүртгэх шаардлагатай, мэдээлэл олон нийтэд нээлттэй
Принс Эдвардын арал	Байгаль орчин хамгаалах тухай хууль	Байгаль орчин, эрчим хүч, ойн яам	Худаг ажиллуулдаг этгээд яам болон худгийн эзэнд тайлан гаргах үүрэгтэй. Олон нийтийн оролцоо байхгүй

Юкон	Усны тухай хууль Усны журам	Юконы байгаль орчны газар	Тусгай зөвшөөрөл шаарддаггүй ч мэдэгдэх, жил бүр тайлагнах үүрэгтэй. Тусгай зөвшөөрөл олголтод олон нийтийн оролцоо зөвшөөрөгдсөн, мэдээлэл олон нийтэд нээлттэй
Баруун хойд нутаг дэвсгэр	Баруун хойд нутаг дэвсгэрийн усны тухай хууль Маккэнзи хөндийн нөөцийн менежментийн тухай хууль	Байгаль орчин, байгалийн нөөцийн яам	Тусгай зөвшөөрөл шаардлагагүй ч мэдэгдэх болон тайлагнах үүрэгтэй, олон нийт гомдол гаргах эрхтэй, мэдээлэл ил тод
Нунавут	Нунавутын усны хууль Гадаргын эрхийн трибунатын хууль	Байгаль орчны алба	Тусгай зөвшөөрөл шаардлагагүй, мэдэгдэх, тайлагнах үүрэгтэй, олон нийт мэдээлэл авах эрхтэй

### БҮГД НАЙРАМДАХ КАЗАКСТАН УЛС

#### Газрын доорх усыг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн орчин

№	Хуулийн нэр	Газрын доорх усны ашиглалт, хамгаалалттай холбоотой заалт байгаа эсэх
1	"Усны тухай" хууль 2003.07.09	115 дугаар зүйл. Усны нөөцийг хомсдохоос хамгаалах" /хэсэгчлэн орчуулсан/ 120 дугаар зүйл. "Газрын доорх усны нөөцийг хамгаалах" /хэсэгчлэн орчуулсан/
2	"Байгаль орчны хууль" 2018.06.29 нэмэлт, өөрчлөлт орсон.	224 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт газрын доорх ус ашиглуулах байгаль орчны шаардлагуудыг тусгасан байна.
3	Газрын хэвллий болон газрын хэвллий ашиглах тухай" 2018.05.24	12 дугаар зүйл. "Ашигт малтмал болон түүний ангилал"-ыг тодорхойлсон байх ба газрын доорх усыг энэ ангилалд хамруулсан байна.
4	"Газрын доорх усыг хамгаалах тухай" журам 1984	Энэ журамд газрын доорх усыг ашиглах, газар зохион байгуулалт, ариун цэврийн байгууламж барих, газрын доорх усыг бүртгэх, газрын доорх усны хамгаалалтыг хянах зэрэг чухал заалтуудыг тусгасан байсан.
5	"Газрын тос, байгалийн хий, газрын доорх ус,	Газрын доорх усны ашиглалтыг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалтад чухал ач холбогдолтой

	ашигт малтмал орд газрыг хамгаалах тухай журам батлах тухай" Засгийн газрын тогтоол 1999	байсан ба 2015 онд хүчингүй болсон байна.
--	--	---

Бүгд Найрамдах Казакстан улсын "Үндсэн хууль", "Усны тухай хууль" Газрын хэвлүй болон газрын хэвлүй ашиглах тухай", "Байгаль орчны хууль" зэрэг хуулиуд, Засгийн газрын тогтоол бусад хууль эрх зүйн актуудад газрын доорх усыг хамгаалах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан. "Газрын доорх усыг хамгаалах тухай" журмыг 1984 онд баталсан. Энэ журамд газрын доорх усыг ашиглах, газар зохион байгуулалт, ариун цэврийн байгууламж барих, газрын доорх усыг бүртгэх, газрын доорх усны хамгаалалтыг хянах зэрэг чухал заалтуудыг тусгасан байсан. "Газрын тос, байгалийн хий, газрын доорх ус, ашигт малтмал орд газрыг хамгаалах тухай журам батлах тухай" 1999 онд батлагдсан Казакстан Улсын Засгийн газрын тогтоол нь газрын доорх усны ашиглалтыг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалтад чухал ач холбогдолтой байсан ба 2015 онд хүчингүй болсон байна.

Казакстан улсын "Усны тухай" хууль 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан. "Усны тухай" хууль нь усны хууль тогтоомжийн гол зорилго, зорилт, зарчмуудыг тодорхойлсон бөгөөд энэ зохицуулалт нь хууль эрх зүйн орчинг цааш хөгжүүлэх эхлэлийн цэг нь болж өгсөн. "Усны тухай" хуулийн 13 дугаар зүйлд газрын доорх усанд хамаарах объектуудыг тодорхой тусгасан. Газрын доорх усны объектод:

1. Уст давхарга, давхаргын болон чулуулгийн цогцолбор
2. Гүний усны сав газар
3. Газрын доорх усны орд
4. Газрын доорх ус хуурай газар байгалийн аясаар гарах ус /булаг/

"Усны тухай" хуулийн 120 дугаар зүйлд "Газрын доорх усны нөөцийг хамгаалах" талаар тусгагдсан. Үүнд:

- Газрын доорх усны нөөц, төлөв байдалд хор нөлөөтэй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд нь газрын доорх усанд хяналт, шинжилгээ хийж, усанд үзүүлэх хор уршиг, усны нөөцийн хомсдол, бохирдоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг заавал авч хэрэгжүүлнэ.
- Үндны усан хангамжийн зориулалтаар ашиглагдаж байгаа болон ашиглагдах газрын доорх усны нөөцийн орд хэсэгт газрын хэвлүйтэй холбоотой үйл ажиллагаа явуулах, цацраг идэвхт болон химийн хог хаягдал хаях, малын сэг, зэм, оршуулга зэрэг газрын доорх усанд нөлөөлөх бусад объектуудын үйл ажиллагааг хориглоно.
- Газрын доорх усны төлөв байдалд нөлөөлж байгаа болон нөлөөлөх бол хаягдал усаар газар тариалан эрхлэхийг хориглоно.
- Гидрогеологийн цооногууд, тэр дундаа өөрөө оргилдог болон хайгуулын худаг, мөн ашиглах боломжгүй эсвэл ашиглалт нь зогссон цооногуудыг булж (устгана) эсвэл тоног төхөөрөмжөөр хамгаалал хийнэ. Устгал, хамгааллыг

гидрогоеологийн цооног эзэмшигч хийнэ. Өөрөө оргилдог цооногийн устгал, хамгааллыг газрын хэвлийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага улсын төсвийн хөрөнгөөр хийнэ.

- Газрын хэвлий ашиглагч нь газрын доорх усыг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.
- Газрын доорх усыг байгууламжаар олборлодог иргэн, хуулийн этгээд нь ариун цэврийн хамгаалалтын бүс болон газрын доорх усны хяналтыг зохион байгуулах үүрэгтэй.
- Барилга болон газар тариалангийн усалгааны систем барьж байгуулах үед газрын доорх ус олборлох бол ус ашиглах тусгай зөвшөөрөл авна.
- Газрын доорх ус ашиглахтай холбоотой ус хангамжийн барилга байгууламж ашиглалтад оруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хүрээлэн буй орчин болон гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах ёстой.
- Газрын хэвлийд геологийн судалгаа хийх, ашигт малтмал хайх, олборлох, ашигт малтмалын олборлолтой холбоогүй газар доор бутээн байгуулалт хийхдээ газрын хэвлий ашиглагч нь гүний усны бохирдол, хомсдоос хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

"Усны тухай" хуулийн 115 дугаар зүйлд "Усны нөөцийг хомсдохоос хамгаалах" талаар тусгагдсан. Үүнд:

1. Усны нөөцийг хомсдохоос хамгаалахын тулд ус ашиглагч иргэн, хуулийн этгээд нь дараах зүйлүүдийг хийх шаардлагатай:
  - 1) Усны ашиглах боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглахгүй байх;
  - 2) Усны хамгаалалтын бүс, усан сангийн хагалбар зурваст мал угаах, ариутгах, барилга байгууламж барих, усны нөөцийг хомсдуулах бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх;
  - 3) Усны хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх
2. Усны нөөцийг хомсдохоос хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээд нь байгаль орчныг хамгаалах чиглэлийн эрх бүхий улсын байгууллага ба газрын хэвлий судлах эрх бүхий байгууллагатай урьдчилан зөвшилцэж, зөвшөөрөл авсан байна.

Казакстан улсын "Газрын хэвлий болон газрын хэвлий ашиглах тухай" хуульд 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ хуулийн 12 дугаар зүйлд "Ашигт малтмал болон түүний ангилал"-ыг тодорхойлсон байх ба газрын доорх усыг энэ ангилалд хамруулсан. Газрын хэвлийн геологийн судалгаа хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 3 жилийн хугацаанд газрын хэвлийд геологи, геофизикийн судалгаа хийхээс гадна газрын доорх усны эрэл хайгуул хийх эрхтэй байна.

Казакстан улсын "Байгаль орчны хууль"-д 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ хуулийн 34 дүгээр бүлгийн 224 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт газрын доорх ус ашиглуулах байгаль орчны шаардлагуудыг тусгасан байна. Энэ бүлэг 2017 оны 21 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлтээр хуулинд орсон. Үүнд:

- Газар доорх усыг ашиглах харилцаа нь Казакстан улсын "Усны тухай"-д заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.
- Хоногт 2000 м3-ээс дээш газрын доорх усны хэрэглээтэй төслүүд байгаль орчны үнэлгээ хийлгэнэ.
- Газар доорх ус ашиглах тусгай зөвшөөрөл аваагүй эсвэл нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд газар доорх ус ашиглахыг хориглоно.
- Газрын доорх усны ордыг ашиглах эсвэл хайгуул судалгаа хийх үед ус ашиглах тусгай зөвшөөрөл авах ба Казакстан улсын байгаль орчны хууль болон бусад норм, дүрмийг мөрднө.
- Газрын доорх усыг хэрэглэж болон хайгуул хийж байгаа байгаль ашиглагч нь дараах үүргийг хүлээнэ.

## УЗБЕК УЛС

"Ус болон ус ашиглалтын тухай" хууль 1993 онд батлагдсан. Энэ хуульд газрын доорх ус гэж газрын давхаргаас доош орших усыг хэлнэ гэж тодорхойлсон байна. Узбекстанд газрын доорх усны асуудлыг эрдэс, баялгийн нөөцийн хороо хариуцдаг. "Ус болон ус ашиглалтын тухай" хуулиас газрын доорх усны хамгаалалттай холбоотой хэсгийг орчуулав.

### Бүлэг 101. Газрын доорх усыг хамгаалах

- Гүний усыг ашигладаг, олборлодог аж ахуй нэгж нь өөрсдийн усны хэрэглээ, түүнд хамаатуулах нутаг дэвсгэрийг хянаж, мөн ашиглагдаж буй усны хэмжээ, чанарын талаар бүртгэл хөтлөх үүрэгтэй.
- Хэрэв ашигт малтмал нээж илрүүлэхтэй холбоотой өрөмдлөг, өөр бусад уул уурхайн ажлын явцад гүний усны нөөц илэрвэл байгаль хамгаалагч, хөдөө орон нутгийн болон усны менежментийн байгууллагуудад мэдэгдэж, гүний усыг хамгаалах арга хэмжээг тогтоосон журмын дагуу биелүүлэх шаардлагатай
- Уст давхаргын бохирдол үүсгэж болох бүх тохиолдолд үйлдвэрийн бохир ус хаях шингээлтийн цооног өрөмдөхийг хориглоно. Эдгээр нь ус бохирдуулах эх үүсвэр болж болзошгүй байдаг байна.
- Өөрөө шахдаг болон ашиглах боломжгүй цооногууд нь тогтоосон хууль журмын дагуу тоног төхөөрөмжийн тоноглол, хамгаалалт хийж эсвэл устгалд оруулна.
- Чанарын шаардлага хангасан устай газрын доорх усны ордын бүсэд хатуу болон шингэн хаягдал, хог хаягдлын овоолго, гүний усыг бохирдуулагч эх үүсвэр болж болзошгүй үйл ажиллагаа эрхэлсэн үйлдвэрлэл, аж ахуй болон бусад обьектууд байж болохгүй.
- Газрын доорх усыг хамгаалах үйл ажиллагаа нь цооногийн ажиглалтын сүлжээ байгуулахаас гадна, газар доорх усанд нөлөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн тусламжтай хийгдэнэ.

## КИРГИЗ УЛС

Узбекистан, Таджикистан, Казахстан улстай харьцуулбал Киргиз улс нь усны нөөц ихтэй, 50 тэрбум.м<sup>3</sup>/жил гадаргын ус, 13 тэрбум м<sup>3</sup>/жил газрын доорх ус,

1,745 тэрбум.м<sup>3</sup>/жил нуур усны нөөцтэй. Газрын доорх усныхаа 5-15 хувийг унд ахуй, усан хангамжийн зориулалтаар ашигладаг. Сүүлийн жилүүдэд усалгаатай газар тариалангийн зориулалтаар өргөн хэрэглэж байна.

Бүгд Найрамдах Киргиз улсын “Усны тухай хууль” 2004 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан ба 2013 оны 10 дугаар сарын 26-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ хуульд газрын доорх усыг бохирдоос хамгаалах болон хамгаалалтын бүсийн талаар тусгасан ба “Газрын доорх усыг хамгаалах тухай” журмыг Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 18-ны 31 дүгээр тогтоолоор баталсан байна. Энэхүү журмаар газрын доорх усыг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулдаг. Журам нь газрын доорх устай холбоотой үндсэн ойлголт, газрын доорх усыг хамгаалах, газрын доорх ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс, ажиглалтын сүлжээ, орхигдож хаягдсан цоногийн устгал, газрын доорх усны бүртгэл, хаягдал ус газар доогуур хаях, газрын доорх усны хамгаалалтын хяналт гэсэн хэсгүүдээс бүрддэг. Журмын холбогдох заалтуудыг хэсэгчлэн орчуулав. “Газрын доорх ус”- газрын гадаргаас доош байрлах бүх цэвэр ус болон эрдэст дулаан усыг хэлнэ.

### Ажиглалтын систем

Бүгд Найрамдах Киргиз улсын нутаг дэвсгэр дэх гүний усны байдал, үйл ажиллагааны горим болон усны хамгаалалтын тусгай арга хэмжээг хянахын тулд хоёр төрлийн хяналтын систем үүсгэж ажиллуулдаг.

- бүсийн ажиглалтын сүлжээ
- тусгай ажиглалтын сүлжээ

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллийг харгалзан үзэж бүс нутаг бүрийн гүний усны (гидрогоеологийн усан сангүүд) болон усны өөрчлөлтийн зүй тогтлын нэгдсэн мэдээллийг авах зорилгоор бүсийн ажиглалтын сүлжээ бий болдог. Тэр нь “Киргизийн нэгдсэн гидрогоеологийн экспедиц” гэх төрийн байгууллагаар геологи, ашигт малтмалын төрийн агентлаг, Бүгд Найрамдах Киргиз Улс (цаашлаад “Киргизийн гидрогоеологийн нэгдсэн экспедиц” төрийн байгууллага)-ын дор бүтээгддэг.

Ус бохирдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулдаг субъектуудыг хянахын тулд тусгай ажиглалтын сүлжээ байгуулдаг. Системчилсэн ажиглалт хийхийн тулд:

- Их хэмжээний гүний ус агуулсан усны нөөцийг хомсдоос сэргийлэхийн тулд, гүний усны түвшинг
- Гүний усны бохирдол илэрсэн орд газрууд эсвэл бохирдох аюултай газруудын гүний усны чанарыг хянана.

Тусгай ажиглалтын сүлжээ нь (заавал байх бүрэлдэхүүн хэсэг) усны хэрэглээний тоноглол барилгын ажил (сэргээн босголт, өргөтгөл) зэрэг төслүүдийн бүрэлдэхүүнд ордог.

Тусгай ажиглалтын сүлжээ нь юуны өмнө дүүргийн аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон ахуйн гадаргуун ус зайлзуулах болон хог хаягдлыг хадгалагч (хаягдлын цөөрөм, лагтын коллектор, тунгаах сав, ууршуулагч цөөрөм, үнсний овоолго болон бусад хог хаягдал хадгалагч тусгай газрууд) мөн газар доорх газрын тос, тосны

бүтээгдэхүүн ба шингэрүүлсэн хий хадгалагч, бүх томоохон аж үйлдвэр, хөдөө аж ахуйн обьектуудад тоноглогдсон байх ёстой.

Тусгай ажиглалтын сүлжээ нь бохирдож болзошгүй газруудад дор хаяж хоёр цооногоос бүрдсэн байх ёстой. Тэр нь бохирдлын эх үүсвэрээс доош урсгал дагуу байрласан байна.

Тусгай ажиглалтын сүлжээ нь шаардлагатай үед эхний гадаргуун дахь даралттай ба даралтгүй ундны усыг, мөн газар доорх уснуудыг бурхаж байх ёстой.

Аж үйлдвэр болон бусад обьектуудын ажиглалтын сүлжээ, дизайн, тоног төхөөрөмж, ажиглалт болон лабораторийн хяналтыг “Киргизийн гидрогеологийн нэгдсэн экспедиц” төрийн байгууллагын удирдамжийн дагуу ус хэрэглэгчдээр гүйцэтгүүлдэг.

Бүсийн ажиглалтын сүлжээ болон тусгай ажиглалтын сүлжээний ажиглалтын цооногийг гэмтээх болон устгах, дур мэдэн авч, гүний усыг ашиглаж, хураах, үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.

### **Орхигдсон цооногуудын устгал**

Гүний усыг бохирдоос сэргийлэхийн тулд гүний усыг бохирдуулж болзошгүй арга замуудын нэг болох хаягдсан цооногуудын үйл ажиллагаа, мөн түүнчлэн хайгуулын (хатуу, чулуужсан олдворууд мөн орно) цооногуудыг буулгаж, уст давхаргуудыг сэргээх ёстой. Ашиглах боломжгүй цооногуудын устгал (төсөлтэй уялдуулан) тусгай өрөмдлөгийн байгууллагуудаар цаашид сэргээж, ашиглах боломжгүй гэсэн бичиг авснаар хэрэгждэг. Геологийн болон гидрогеологийн нехцэлөөс хамааран устгал болон буулгалтад тусгай шавран уусмалууд, шавар болон цемент ашиглана. Босоо болон хэвтээ уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа явуулахаа больсон цооногууд болон орхигдсон худгууд нь төслийн дагуу татан буулгагдана.

Үйл ажиллагаа явуулах боломжгүй болон гүний ус ажиглахад тохиромжгүй болсон цооногуудын устгал тусгай өрөмдлөгийн байгууллагаар тогтоосон дэг журмын дагуу тэдний харьяалагдаж буй байгууллагын хөрөнгөөр хэрэгжинэ.

### **Гүний усны бүртгэл**

Гүний усны ашиглалтын бүртгэл нь төрийн бүртгэлийн нэгдсэн системийн хүрээнд уул уурхайн салбарын хөгжил болон газрын хэвлэй ашиглалтад төрийн бодлого хэрэгжүүлдэг эрх бүхий төрийн байгууллагаар хэрэгжинэ. 1995 оны 1-р сарын 25-ны өдөр Киргизийн Засгийн газрын 19 тоот тушаалаар батлагдсан Бүгд Найрамдах Киргиз Улсын Усны хэрэглээний улсын бүртгэл, хяналтыг зохицуулах журмын дагуу улсын бүртгэлийг хөтлөх, усны ашиглалтыг хянах журмыг тогтоосон.

Усан хангамжийн эх үүсвэрээс гүний усны хураамж болон ашиглалтын бүртгэлд дараах зүйлс орно:

- гүний ус ашиглалтын анхан шатны бүртгэл нь ус хэрэглэгчдийн журнал болон усны тоолуураар эсвэл хүн амыг гүний усаар хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж үйлдвэр болон бүгд найрамдах улсын бусад обьектуудаар хөтлөгднө. Анхан шатны бүртгэлийн үр дүнг тогтоосон журмын дагуу уул уурхайн салбарын хөгжил болон газрын хэвлэй ашиглалтад төрийн

бодлого хэрэгжүүлдэг эрх бүхий төрийн байгууллагад шаардлагатай шат дарааллын дагуу хүргэгддэг.

- Орд газар, захиргааны бүс, артезын усны цөөрөм болон ус ашиглах бусад хэлбэрийн гүний усны ашиглалтын улсын бүртгэл.

Төрийн гүний усны бүртгэлийн үндсэн зорилго нь усны тоо хэмжээ, чанар, мөн гүний усны батлагдсан нөөц илэрсэн орд газрын хүрээнд хэрхэн ашиглагдаж буй болон цаашид хүн ам, үйлдвэрлэл ба бусад байгууламжуудын хэрэгцээнд хэрхэн үр өгөөжтэй ашиглагдах талаар мэдээлэл авах зорилготой.

Төрийн гүний усны бүртгэл болон усны хэрэглээ нь эх сурвалжийн өгөгдлийг авч байж шийдэгдэх асуудлуудад;

- Одоогийн болон урт хугацааны төлөвлөлт, усны хэрэглээ ба ус хамгааллын үйл ажиллагааны гүйцэтгэл;

- Усны хамгаалалт болон ашиглалтын схем байгуулалт;

Бүгд Найрамдах Улсын нэгдсэн системээр төрийн усны бүртгэл болон ашиглалт хэрэгждэг. "Гүний ус" гэсэн хэсэг нь уул уурхайн салбарын хөгжил болон газрын хэвлий ашиглалтад төрийн бодлого хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагаар. "Гадаргын ус" (усны тогтоц үүсэх бүсийн гадаргын ус) гэсэн хэсэг нь ус цаг уурын салбарын төрийн эрх бүхий байгууллагаар. "Гүний болон гадаргын усны ашиглалт" гэсэн хэсэг нь усны нөөцийн салбарт төрийн бодлого хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагаар.

Эрх бүхий төрийн байгууллага нь уул уурхайн салбарын хөгжил болон газрын хэвлий ашиглалтад төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд:

- гүний усны нөөцийн улсын бүртгэл хийхээс гадна тэдний чанар болон горимыг хянадаг;

- бүс нутгийн болон тусгай ажиглалтын сүлжээгээр нөөцийн хомсдол үүсч, чанар нь муудаж болзошгүй бүс нутгууд дахь гүний усны төлөв байдлыг хянаж, судалдаг;

- гүний усны талаар сонирхсон байгууллагууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийг мэдээллээр хангадаг;

Эрх бүхий төрийн байгууллага нь усны нөөцийн салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд:

- ус ашиглалтын төрийн хяналт болон бүртгэлийг хийнэ;

- ус хэрэглэгчдийн бүртгэл болон тайланг гаргана;

- усны менежментийн тоноглолын жагсаалт гаргана:

Эрх бүхий төрийн байгууллага нь ус цаг уурын салбарт:

- усны тогтоц үүсэх бүсийн гадаргын усанд төрийн усны бүртгэл явуулдаг

- ус цаг уурын станц, шуудангийн системд ажиглалт хийсний үндсэн дээр гадаргын усны хяналт хийдэг

- усны тоон үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах боломжийг олгодог.

### Хаягдлыг газар доор булах

Тусгай төслийн дагуу ус агуулж буй бүсийг аж үйлдвэрийн хаягдал, газрын тосны ордыг булахад ашиглана. Тэр төсөлд хаягдал ус, хорт бодисууд, бохирдол болон бусад өөр төрлийн бодис, материалуудыг аюулгүй болгох, булж буй

зүйлсүүдээ тодорхой шингээгч бүсэд байрлуулах зэрэг арга хэмжээнүүд авах ёстой;

Аж үйлдвэрийн бохирдол булсан газар доорх полигон дээр татагдаж буй бохирдол усыг давхарга ба ус агуулсан газруудаар хэрхэн шилжихийг хянахын тулд ажиглагч цооног бүтээгддэг. Ажиглагч сүлжээний тоноглолгүйгээр полигон үйл ажиллагаа явуулах боломжгүй. Ажиглагч сүлжээний тоноглол болон ажиглагчийн үйлдвэрлэл нь полигон эзэмшигчээр хэрэгжинэ.

### Гүний усны хамгаалалтын хяналт

Гүний усны ашиглалт ба хамгаалалтын улсын хяналт төрийн бүрэн эрхт байгууллагаар биелэгдэнэ:

- уул уурхайн салбарын хөгжилд төрийн бодлого хэрэгжих талаар
- байгаль орчны болон техникийн салбарын аюулгүй байдал төрийн хараа хяналтан доор байх талаар
- нийтийн эрүүл мэндийн салбарт төрийн бодлого хэрэгжих талаар

Уул уурхайн салбарын хөгжилд төрийн бодлого хэрэгжүүлэх талаар төрийн бүрэн эрхт байгууллага нь өөрийн ур чадварын хүрээнд биелүүлэх нь:

- гүний цэвэр ба эрдэст бүлээн усны бохирдол болон хомсдлын хамгаалалтыг хянах
- өөрөө шахагч цооногийн краны горимд шилжихийг хянах, орхигдсон цооногийг устгах
- техникийн нөхцөл болон бүлгийн ба ганцаарчилсан гүний усны хэрэглээний үйл ажиллагааны горимыг хянах
- ус хэрэглэгчдийн усны горимын ашиглалт болон усны хэрэглээний хэмжилтийг хянах
- анхдагч түүвэрлэлтийн хөтлөлт үнэн зөв эсэхийг болон гүний усны ашиглалтад хяналт тавих
- цооног ашиглалтын сүлжээ, түүний техникийн нөхцөл байдлыг хянаж, ажиглалтын явцыг бас хянах
- рашаан сувиллын газар, эмнэлэг, савлагааны үйлдвэр зэрэг нь эмчилгээний усыг (эрдэст болон бүлээн усны нөөц) зөв ашиглаж (олборлож) байгааг хянах

Байгаль орчин ба техникийн аюулгүй байдлын салбар дахь төрийн хараа хяналтын талаар төрийн бүрэн эрхт байгууллага нь өөрийн ур чадварын хүрээнд биелүүлэх нь:

- Гүний усны бохирдол болон усны хэрэглээ, өрөмдлөг, уул уурхайн ажил эрхлэгч байгууллагуудаас үүдэх хомсдлоос хамгаалж хэрэглээний хяналт тавих
- Гүний усыг бохирдуулагч объектуудын судалгаа шинжилгээний үр дүнгийн талаар акт бүрдүүлэх
- Байгаль орчин хамгаалах хууль тогтоомж зөрчсөн гэм буруутанд захиргааны хариуцлага хүлээлгэх

Нийгмийн эрүүл мэндийн салбар дахь төрийн бодлого хэрэгжүүлэх талаар төрийн бүрэн эрхт байгууллага нь өөрийн ур чадварын хүрээнд биелүүлэх нь:

- Ундны ус, ундны усны эх булаг, системд тавьсан шаардлагыг дагаж мөрдөж буй эсэхийг хянах

### “Газрын хэвлийн тухай” хууль

Бүгд Найрамдах Киргиз улсын “Газрын хэвлийн тухай” хууль 2018 оны 5 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орж, шинэчлэгдсэн байна. “Газрын хэвлийн тухай” хуульд газрын доорх цэвэр болон эрдэст усыг ашигт малтмал гэж тодорхойлж авч үзсэн байна. Хуулиас холбогдох заалтуудыг хэсэгчлэн орчууллаа.

Бүлэг 27. “Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох” энэ хэсэгт газрын хэвлийг ашиглах эрх нь дуусгавар болсон ч газрын хэвлийг ашиглагчийн газрын доорх усыг бохирдол, хомсдлоос хамгаалах үүргийг дуусгавар болгохгүй талаар оруулсан.

Хуулийн 44 дүгээр зүйл. Газрын доорх усны ашиглалт, зохицуулалтын онцлог

- Газрын хэвлийг ашиглах эрхээр тусгай зөвшөөрөл авахгүйгээр гидрогоеологийн худгийг өрөмдөх эрхтэй.
- Тусгай зөвшөөрөлгүй болон газрын хэвлийг хамгаалах үйлдвэрлэлийн болон байгаль орчны экспертээр орсон өрөмдлөгийн тесөл байхгүй тохиолдолд 30 метрээс дээш өрөмдөхийг хориглоно.
- Гал унтраах болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоогүй хувийн хэрэгцээнд ашиглахаас бусад бүх тохиолдолд газрын доорх усыг ашиглахад заавал тусгай зөвшөөрөл авна.

Хуулийн 45 дугаар зүйл. Ус хэрэглээний худгийг /водозaborных скважин /улсын бүртгэлд бүртгэх

- 30 метрээс дээш гүнтэй худагтай эсвэл 30 метрээс дээш өрөмдсөн бол өрөмдлөг дууссанаас 30 хоногийн дотор цооногийн техникийн үзүүлэлтийн талаар газрын хэвлийг ашиглах эрх бүхий төрийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай. Энэ байгууллага нь улсын бүртгэлд бүртгэнэ. Үүнийг зөрчсөн тохиолдолд Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

### ОХУ

ОХУ-ын “Усны тухай” хуулийн 5 дугаар зүйлд газрын доорх усны ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгасан байна. Газрын доорх усны ордын хилийг “Газрын хэвлийн” хуулиар зохицуулдаг.

Гүний усанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эсвэл сөрөг нөлөө үзүүлэхүйц аж ахуй эрхэлсэн хуулийн этгээд, хувь хүн гүний усны бохирдол, хомсдлоос сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Мөн түүнчлэн гүний усны нөөцөд нөлөөлж болохуйц хэм хэмжээг дагаж мөрдөх хэрэгтэй.


1. Ундны болон аж ахуйн зориулалтаар ашиглагддаг гүний усны ус их хурсан газар үйлдвэрлэлийн болон хэрэглээний хог хаягдал, оршуулга, малын сэг зэм болон өөр бусад гүний усанд сөрөг нөлөө үзүүлэхүйц объект байрлуулах хориотой.

- Бохир усыг газрын бордоо болон усжуулалтад ашиглах нь ариун цэврийн хууль тогтоомжийн дагуу явагдаж болно.
- Газрын хэвлүй ашигласан тохиолдолд уст судлууд илэрсэн бол гүний усыг хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй.
- Гүний усны ашиглалттай холбоотой үйл ажиллагаа, барилга байгууламж, сэргээн босголт болон усны байгууламжийн хэрэглээнд эдгээр зүйлс байгаль орчин болон усны гадаргууд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлсэн арга хэмжээ авсан байх ёстой.

## БҮГД НАЙРАМДАХ ЛИВИ УЛС


Ливи улс нь гадаргын ус багатай, газар нутгийн 93% нь жилд дунджаар 100 мм орчим хур тунадас унадаг, нийт нутгийн жилийн дундаж хур тунадас нь 26 мм байдаг. Дотоодын нийт бүтээгдэхүүний 2% -ийг газар тариалангийн салбараас гаргадаг ба нийт нутаг дэвсгэрийн 95% нь цөл, үлдсэн 5 хувь буюу 2.2 сая га талбайг газар тариалангийн зориулалтаар ашиглах боломжтой. Үйлдвэрлэлийн том салбар нь газрын тос олборлолт ба энэ нь одоогийн ДНБ 71%-ийг эзэлж байна.

Улсын нийт хэрэглээний 95%-ийг газрын доорх ус болон далайн ус давсгүйжүүлэх үйлдвэрээс, үлдсэн хувийг нь шинээр усны нөөцийг бий болгох замаар байгуулсан усан сангудаас хангадаг байна. Дараах зурагт Ливи улсын усны эх үүсвэрүүдийн төрлийг хувиар харуулав.



**Зураг 1. Ливи улсын усны эх үүсвэрүүд, хувиар**

Ливийн 4-н голын сав газарт сэргээгдэх боломжтой гүехэн хурдасны газрын доорх ус, бусад нутагт нөхөн сэргээгдэх боломжгүй хэт гүний усны нөөцтэй. Жишээ болгон Жефара хөндийн бүс нутгаас хэрэглэж буй усны хэмжээг салбар бүрээр дараах зурагт харуулав (Abdulmagid & Scott, 2014).



**Зураг 2. Жефара хөндийн бүс нутгаас хэрэглэж буй ус хэрэглээ, сая.m<sup>3</sup>/жил**

Сүүлийн жилүүдэд жилийн нийт ус хэрэглээ 4903 м<sup>3</sup>/жил болсон байна. Нийт ус хэрэглээнээс 70 хувь нь газар тариалан, 12 хувь нь унд ахуй, 18 хувь нь үйлдвэрлэлд ашигладаг (Ronny, 2007).

Усны асуудлыг 2012 оноос Усны нөөцийн яам хариуцан ажиллаж байгаа бөгөөд өмнө усны асуудал хариуцаж байсан Усны ерөнхий газрыг уг яаманд багтаасан байна. Үүнээс гадна Хүрээлэн буй орчны ерөнхий газар усны зарим асуудлыг хамтран хариуцдаг.

Ливи нь 1965 онд анхны усны тухай хуулиа санаачилсан байна (Otman & Erling, 2007). Энэ хуулинд ус бол зайлшгүй хэрэгцээ гэж тодорхойлсон байсан бол 1982 онд дахин шинэчилж усны нөөцийг зохистой ашиглах, бус нутагт дамжуулан ашиглах тухай дагалдах тушаал шийдвэрүүд олноор гарчээ. Усны нөөцийг зохистой ашиглахтай холбоотой 1982 оны п.790 тушаалд газрын доорх усыг хомсдол, бохирдлоос хамгаалах асуудлыг тусгасан.

Ливи улс нь 1953 оноос газрын тос олборлож байгаад Ливийн өмнөд хэсэгт газар доорх усны том орд олжээ. Түүнийгээ далайн эргийн хотууд руу татах, бус нутагт газар тариаланг хөгжүүлэх зорилгоор 1960 оноос Алдарт хиймэл гол (The great man-made river) төслийг эхлүүлсэн. Төслийн хүчин чадал нь 6.5 сая м<sup>3</sup> усыг олон зуун км хоолойгоор дамжуулан түгээх ба эх үүсвэр нь Nubian Sandstone орд бөгөөд энэ орд нь Судан, Египт, Чад зэрэг улсуудын хил дамнан оршдог (FAO, 2009).

Хил дамнasan газрын доорх усны орд Ливи, Алжир, Тунис, Египт, Судан, Чад гэх мэт улс орон дамнан орших ба 2000 оноос хойш эдгээр улсуудын хамтарсан комисс аливаа харилцаа, хэрэглээтэй асуудлыг шийдэж эхэлжээ.

#### Газрын доорх усыг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн орчин

№	Хуулийн нэр	Газрын доорх усны ашиглалт, хамгаалалттай холбоотой заалт байгаа эсэх
1	“Усны тухай” хууль 1982, Law n. 3	16 зүйлтэй. Хөдөө аж ахуй, хүн амын ундны усанд гадаргын болон газрын доорх усыг ашиглахтай холбоотой асуудлыг зохицуулах /Хэсэгчлэн орчуулсан/
2	Хүрээлэн буй орчны хамгааллын тухай хууль 1982 / 2003, Law n. 7, Law n. 15	Бүлэг 4-д усны нөөцийг хамгаалах тухай заагдсан байна. /Хэсэгчлэн орчуулсан/
3	Үндэсний усны нөөцийн менежментийн стратеги 2000-2025	Газар тариалангийн ус хэрэглээг үр ашигтай болгох, үйлдвэрлэлийн ус хэрэглээг бууруулах, хязгаарлах Ус хэрэглээний үнэ цэнэ бий болгох, эдийн засгийн эргэлтэд оруулах, усны тоо хэмжээ чанарын хяналтыг нэвтрүүлэх Гадаргын усны нөөцийг ихэсгэж газрын доорх усны хэрэглээг хязгаарлах Усны тухай баримт бичгүүд, тогтоолуудыг гаргах

4	Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр, 2008	7-р зорилт: Хүрээлэн буй орчны тогтвортой байдал: Усны нөөцийг зөв зохистой хүртээмжтэй байдлаар дахин хуваарилах, ногдуулах, усны нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, унд ахуйн усны хүртээмжийг сайжруулахад чиглэнэ (MOSSA A, 2014).
---	---	---

**Хүрээлэн буй орчны хамгааллын тухай хууль (source: Compendium of Environmental Laws of African Countries, Volume 1)**

/Хэсэгчилсэн орчуулга/

Хэсэг 1. Зүйл 1 (1). Хүрээлэн буй орчин гэдэгт хүн болон амьтны амьдарч байгаа орчин агаар, ус, хөрс болон хүнс орно.

Хэсэг 1. Зүйл 2. Энэ хууль нь хүрээлэн буй орчныг бохирдоос хамгаалах, бохирдооос урьдчилан сэргийлэх тохиромжтой арга хэмжээг авахад чиглэнэ.

Хэсэг 4. Усны нөөцийг хамгаалах тухай

Хэсэг 4. Зүйл 40. Усны нөөц бол Ливийн ард түмний өмч юм.

Хэсэг 4. Зүйл 42. Усны нөөцийг хэрэглэж байгаа хүн бүр түүнийг хамгаалах арга хэмжээг авах ёстой. Усны нөөцийг зохион байгуулах үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр усны нөөцийг зөв зохистой ашиглах, арвилан гамнах үйл ажиллагаагаар хангаж ажиллана. Үүнтэй холбоотойгоор:

Зүйл 42 (1) Газрын доорх усны орд руу их хэмжээний далайн ус, бага хэмжээний цэвэр ус, бусад үе давхаргуудаас ус шүүрч орж ирэхээргүй байх хэрэгтэй.

Зүйл 47 Ямар нэгэн хаягдал, хогийн зүйлийг шууд болон шууд бусаар усны нөөцэд оруулахыг хориглоно.

Зүйл 50 Хүрээлэн буй орчныг хамгаалахад хариуцлага үүрч буй төрийн захиргааны байгууллага нь усны нөөцийг бохирдоос хамгаалах, хянах үүрэг хүлээнэ. Үүнтэй холбоотойгоор:

Зүйл 50 (а) Энэ хуулийг дагаж гарах дүрэм, журмыг томьёолоход туслах

- (б) Бүх төрлийн төслийдийн хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлыг судлах
- (с) Усны нөөцийг бохирдоос урьдчилан сэргийлэх талаар импорт, үйлдвэрлэл, тээвэр болон бусад химийн бодисын хэрэглээн дээр зөвлөмж гаргаж хүргүүлэх

**Усны нөөцийн ашиглалтын тухай хууль (Law No.3 of 1982 to organize the Utilization of Water Resources)**

/Хэсэгчилсэн орчуулга/


Хуулийн 1-р зүйлд усыг хэтрүүлэлгүйгээр хүн бүр ашиглах нөөц гэж тодорхойлсон. Гадаргын болон газрын доорх усны өмчлөгч нь Ливийн ард түмэн байна. 5-р зүйлд ус ашиглах зөвшөөрлийг олон нийтийн усны асуудал эрхэлсэн байгууллагаас олгох бөгөөд усны нөөцэд хомсдол үүсгэлгүйгээр ашиглах хамгаалах тухай заасан. Өөрөөр хэлбэл иргэн нь өөрийн хэрэгцээнд зориулж усыг ашиглах бүрэн эрхтэй боловч уг усны нөөцийг бохирдуулж хомсдуулах, хүрээлэн буй орчинд нь нөлөөлж болохгүй. 6-р зүйлд усны нөөцийг бохирдуулахыг хориглох, 7-р зүйлд Газар тариалангийн газрын зөвшөөрөлгүй худаг өрөмдөхийг хориглох тухай заасан. Энэ хуульд усны менежментийн тухай тусгасан байdag.

Мөн 7-р зүйлд газар тариалангийн хөгжлийн газар нь ашиглагдахгүй байгаа худгуудыг хурааж авах, мөн усны газрын эрх үүргийг гүйцэтгэх буюу ашиглаж байгаа худгийн үйл ажиллагаанд үндэслэн хаах боломжтой гэх мэт давхардсан үүргүүдийг заасан байна. Хуульд усны нөөцийг ашиглах лиценз авах шаардлагуудыг тусгасан. 8-р зүйлд усны нөөцийн хэрэглээнд хязгаарлалт хийх тухай заажээ. 10-р зүйлд нэг эх үүсвэрээс олон хэрэглэгч хэрэглэх тохиолдолд гарах харилцааг зохицуулах тухай заасан. 11-р зүйлд усны нөөцийг бохирдуулахыг хориглох тухай заажээ. Бохирдлыг хянах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээг усны асуудал эрхэлсэн засгийн газрын байгууллага болон бусад хүрээлэн буй орчны болон бохирдуулах боломжтой салбарын асуудал эрхэлсэн байгууллагууд эрхэлдэг байна. Усны эх үүсвэрийг бохирдуулах үйл ажиллагааг хориглох эрх нь уг байгууллагуудад байдаг.

Хуулинд усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх институт нь Усны ерөнхий газар байна гэж томьёолсон. Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг шинжлэх ухаанд сууриссан судалгаа, шинжилгээний үр дүнг түшиглэж улс орны бүхий л нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг боловсруулах ёстой гэж заасан байна.

### ИЗРАИЛЬ УЛС

Израиль нь хагас хуурай уур амьсгалтай газар дундын тэнгисийн зүүн хэсэгт оршдог орон юм. Жилийн дундаж хур тунадас нь 100-900 мм байх ба хойт хэсгээрээ илүү хур тунадас унадаг байна. Усны асуудлыг үндэсний усны нөөцийн менежментийн асуудлыг хариуцдаг Усны газар эрхэлдэг (Water Authority, Policies to manage Agricultural Groundwater use in Israel, 2015). Израиль нь газар тариаланд газрын доорх усны 45 гаруй хувийг ашигладаг, газрын доорх усны гачигдалд орсон орон юм.



Зураг 3. Израилийн газрын доорх ус ашигладаг салбарууд, хувиар

1980-аад оноос эхлэн газрын доорх ус үлэмж хэмжээгээр багасаж, байгалийн жамаар нөхөн сэргээгдэх эрчмээс илүү усыг хэрэглэдэг болсон. Иймд Израиль улс усыг үр ашигтай, гамтай зарцуулах тал дээр ажилласаар улмаар 2005 оноос далайн болон ашигласан бохир усыг цэвэршүүлэх төхнологийг хөгжүүлж эхэлсэн байна (Water Authority, Master plan for the National water sector, 2012). “Зохистой ус татамж”-ийн зарчим дээр үндэслэж борооны улиралд (4-р сар) хур тунадас, голын усны хэмжээг хяналтын сүлжээний тусламжтайгаар тодорхойлж дараа жил ашиглах боломжит усны хэмжээг гаргадаг (Schwarz, Bear, & Dagan,

2016). Хур тунадас багатай жил газрын доорх усны нөөцийг зохиомлоор нэмэгдүүлэн нөөцөлж ус хэрэглээ ихтэй үед ашигладаг.

#### Газрын доорх усыг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн орчин

№	Хуулийн нэр	Газрын доорх усны ашиглалт, хамгаалалттай холбоотой заалт байгаа эсэх
1	"Усны тухай" хууль 1959-2008, Law n. 5719	Усны тухай хуульд газрын доорх усыг бусад усны нөөцөд хамтатган авч үзэж өрөнхий заалтуудаар зохицуулсан байна. Хууль дагалдаж гарсан тогтоол, шийдвэрээр нарийвчлан газрын доорх усыг хамгаалдаг байна. /хэсэгчлэн орчуулсан/
2	Үндэсний усны салбарын мастер төлөвлөгөө 2050 он хүртэл, 2012	11 цөм сэдэвтэй. Үүний 4-т байгалийн усны нөөцийн менежмент, 6-д эрэлтийн менежмент зэрэгт газрын доорх усны хэрэглээ, нөхөн сэргээлтийн төлөвийг тогтоожээ. Газрын доорх усны хэрэглээг багасгаж далайн усыг цэнгэгжүүлэн ашиглах технологийг нэмэгдүүлэх, бохир усыг дахин ашиглах, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх тухай төлөвлөсөн байна.
3	Ус ашиглагчдад олгох зөвшөөрлийн тухай тогтоол, 2012	Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх дүрэм, журам (Regulation of water allocations to farmers)
4	Худгаас ус олборлох ногдол хэмжээг тогтоох тогтоол, 2014	Төлөвлөлтийн үед ус олборлох ногдлыг тооцоолох, өөрчлөлтийг тооцоолох (Regulation of levies for water extraction from wells) Ингэхдээ улаан шугам болон зохистой ус татамж гэдэг гидрологийн зарчмуудыг баримталж эхэлсэн байна.
5	Газар тариалангийн ус хэмнэх хөтөлбөр	Газар тариаланд хэрэглэж байгаа усанд хэмжээ тогтоож уг хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд торгууль ногдуулах (Agriculture water conservation programs)
6	Газрын доорх ус хэрэглээтэй холбоотой газрын тухай журмууд	Газрын доорх ус хэрэглээний хориглох бүсийг тогтоох Газрын доорх ус хэрэглээний эрэмбийг тогтоох (Land policies with implications on groundwater use)
7	Уур амьсгалын дасан зохицох хөтөлбөрүүд	Газар тариаланд хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэй технологийг нэвтрүүлэх Газрын доорх усны загварчлал, мэдээллийн сан бурдүүлэх (Climate change adaptation programs)
8	Усны сав газрыг хамгаалах хөтөлбөрүүд	Онцгой бүс нутгийг ус хэрэглээний бүсээс чөлөөлөх (Watershed conservation programs)
9	Газрын доорх усыг	Газрын доорх усны ордыг нөхөн сэргээх төсөл,

	сэргээх хөтөлбөрүүд (Aquifer recharge programs)	хөтөлбөр хэрэгжүүлэх Газрын доорх усны орд бий болгож усны нөөцийг хуримтлуулах Гадаргын усыг шүүрүүлэх сан байгуулах
--	---	--

### Усны хууль 1959-2008, Law n. 5719

/хэсэгчилсэн орчуулга/

#### Бүлэг 1 Удиртгал

Бүлэг 1.2 Усны нөөцөд гадаргын боон газрын доорх ус, дэвшилтэт технологиор бий болох усыг хамруулна.

Бүлэг 1.5 Хуулийн этгээд нь усны нөөцийг хомсдолд оруулахгүйгээр ашиглах эрхтэй.

Бүлэг 1.6 Усны нөөцийг дараах эрэмбийн дагуу ашиглана. Тухайн зорилго бүрд ашиглах нөөц хүрэлцэхгүй үед дараачийн зорилгоор ашиглахыг хориглоно. Үүнд:

1. Унд ахуйн ус хэрэглээ
2. Газар тариалан, хөдөө аж ахуй
3. Үйлдвэрлэл
4. Үйлчилгээ, худалдаа
5. Олон нийтийн үйлчилгээ
6. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд (2004 оны нэмэлтээр орсон.)

#### Бүлэг 2. Ус хэрэглээний зохицуулалт

Бүлэг 2.8 Энэ бүлэгт газар доорх болон дээрх усны түвшний бууралтыг усны эх үүсвэрийн хорогдол гэж үзнэ.

Бүлэг 2.9.3 Хуулийн этгээд, иргэн нь усны эх үүсвэрийг хорогдуулахгүй байх үүрэгтэй.

Бүлэг 2.9.4 Хуулийн этгээд, иргэн нь усны эх үүсвэрээс хэрэглэдэг бол түүнийг хорогдооос хамгаалах үүрэгтэй.

#### Бүлэг 3 Усны бохирдлоос хамгаалах

Бүлэг 3.20 А Усны бохирдол гэдэг нь физик, хими, органик, биологийн, бактериологийн, цацраг идэвхт болон бусад шинж чанаруудын стандарт хэмжээнээс өөрчлөгдэж олон нийт, ургамал амьтанд сөрөг нөлөө үзүүлэхүйц байхыг хэлнэ.

Бүлэг 3.20 В а. Иргэн нь усыг бохирдуулах шууд болон шууд бус үйлдлээс урьдчилан сэргийлнэ.

Бүлэг 3.20 В б. Иргэн нь усны эх үүсвэр рүү, түүний эргэн тойронд ямар нэгэн шингэн, хатуу, хийн бодис хаяхгүй, хийхгүй байх ёстой.

Бүлэг 3.20 Д а. Усны бохирдлоос хамгаалахын тулд Хүрээлэн буй орчныг хамгаалах яам, холбогдох байгууллага бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, бохирдлыг бууруулах гэх мэт үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, тогтоол боловсруулж ажиллана.

### АВСТРАЛИИ УЛС


Австралийн жилийн хур тунадас нь бүс нутагт харилцан адилгүй боловч дунджаар 419 мм, нутгийн 80 орчим хувь нь 600 мм-ээс бага, 50 орчим хувь нь 300

мм-ээс бага хур тунадас унадаг. Австрали улсын жилийн хэрэглээ нь 15 мян. Гига литр бөгөөд 5 мян. Гига литр нь газрын доорх уснаас хэрэглэдэг гэх статистик байх боловч бодит газрын доорх усны хэрэглээ нь 10 мян. Гега литр орчим байх магадлалтай гэнэ. Усны нөөцийн хэрэглээний тайлан, хэмжих аргачлал сайнгүй учир статистикийн мэдээлэл нарийвчлал багатай байдаг байна (Nikki & Peter, 2014). Иймд Австралийн үндэсний усны нөөцийн мэдээллийн систем боловсруулж илүү нарийвчлалтайгаар усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх ажлууд хийгдэж байгаа гэнэ. Австралийн газрын доорх усны хэрэглээ жил бүр ихэсч байгаа бөгөөд мужууд дунд Баруун Австрали хамгийн их газрын доорх усыг хэрэглэдэг.


Иймд уг бүс нутагт гадаргын уснаас газрын доорх усанд шилжиж буй хэрэглэгчдэд хатуу хяналт шаардлагуудыг тавьдаг. Австрали нь үндэсний газрын доорх усны мэдээллийн сантай бөгөөд түүнд хэрэглээ, чанарын асуудлууд багтсан (Water, 2016). Газрын доорх ус нь Австралийн ард түмний нөөц бөгөөд ашиглах, хянах асуудлыг эзэн хааны захиргаа (The Crown) шийднэ. Муж бүрийн засгийн газрын харьяа Усны хэрэг эрхлэх газар нь ус ашиглах зөвшөөрлийг олгох ба усны өмчийн эрхээр (water property right) зохицуулагдана (WaterAct, 2017). Газрын доорх ус ашиглах лицензийг ус хэрэглэх нехцөл, ашиглах хугацаа, олборлох эзлэхүүнээс хамааруулж олгодог. Усны нөөцийг ашиглахдаа дараах дарааллыг баримталдаг (OECD, 2015).

- Хүний критик хэрэгцээний ус
- Байгаль орчныг тэтгэх, усыг сав газар хооронд дамжуулах
- Усалгаатай газар тариалан, ахуйн хэрэглээ болон үйлдвэр аж ахуй

Лиценз нь автоматаар сунгагдах боловч төрийн захиргааны байгууллагаас усны нөөцийн төлөвлөгөөтэй уялдуулан өөрчлөлт хийх боломжтой байдаг.



**Зураг 4. Австралийн мужуудын газрын доорх ус хэрэглээний хувь**



**Зураг 5. Австралийн мужуудын газрын доорх ус ашигладаг салбарууд**

Газрын доорх усны тухай хууль, эрх зүйн акт боловсруулах, дүрэм журам гаргахдаа дараах гурван зүйлийг чухалчлан үздэг ба эдгээр нь (Rebecca & Philippe, 2016):

- Гадаргын ба газрын доорх усны харилцан холбоо, нэгнийх нь хэрэглээ нөгөөд хэрхэн нөлөөлж байгааг авч үзэх
- Газрын доорх ус олборлолт тухайн бүс нутгийн экосистемд хэрхэн нөлөөлж болохыг авч үзэх
- Хил дамнасан газрын доорх усны ашиглалт, түүнийг зохицуулах гэх мэт...

Газрын доорх усыг ашиглах эрхийг засгийн газрын усны нөөцийг зохицуулах байгууллага олгоно. Газрын доорх ус ашиглах эрх нь өмчийн эрхээр зохицуулагддаг. Усны олборлох хэмжээг мөн засгийн газрын усны нөөцийг зохицуулах байгууллага тогтоож өгдөг байна (WA & Department of, 2010). Ингэхдээ “Ус олборлолтын хүрээлэн буй орчинд тогтвортой түвшин” гэсэн зарчмыг баримталдаг. Ихэвчлэн ус олборлох хэмжээний хязгаар нь менежментийн төлөвлөгөөгөөр батлагддаг байна. Макро хэмжээний олборлолтод хязгаарыг нь тогтоолоор тогтоож өгдөг. Энэ талаар “to increase the productivity and efficiency of Australia's water use . . . and to ensure the health of river and groundwater systems by establishing clear pathways to return all systems to environmentally sustainable levels of extraction.” гэж үндэсний усны санаачлагын засаг хоорондын гэрээнд заасан байдаг (NWI, 2004). Австрали нь гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх тал дээр олон ажил хийхийн зэрэгцээ газар доорх усыг зохиомлоор нэмэгдүүлэх, далд нэвчүүлэх байгууламжуудыг усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж хийдэг.

#### Газрын доорх усыг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн орчин

№	Хуулийн нэр	Газрын доорх усны ашиглалт, хамгаалалттай холбоотой заалт байгаа эсэх
1	Мужуудын “Усны тухай” хууль	Усны тухай хуульд газрын доорх усыг бусад усны нөөцөд хамтатган авч үзэж ерөнхий заалтуудаар зохицуулсан байна. Хууль дагалдаж гарсан тогтоол, шийдвэрээр нарийвчлан газрын доорх усыг хамгаалдаг байна. /хэсэгчлэн орчуулсан/
2	Усны тухай хууль	Энэ хууль нь хэд хэдэн муж дамнасан усны нөөцийн

	(The Murray-Darling Basin), 2007	ашиглалт хамгаалалтын талаар байх бөгөөд голчлон The Murray-Darling Basin –ий харилцааг зохицуулахаар хийгдсэн байна. Энэ хуулинд муж бүрт нэг нөөцөөс авах усны хүртээмжийг хуульчилж зааж өгсөн байна.
3	Үндэсний усны чанарын менежментийн стратеги, 2013	Газрын доорх усны нөөцийг бохирдлоос хамгаалах гарын авлага гэх мэт газрын доорх усны бохирдлыг үнэлэх аргачлал, хамгаалах арга, нөхөн сэргээх арга зэргийг тусгасан байна.
4	Усны агентлагийн тухай хууль, 1984	Муж бүр усны агентлагийн тухай хуультай. Энэ хуульд яам, усны засаглалын бүтэц, тэдгээрийн үүрэг, үйл ажиллагааны хүрээ, эрх үүргийг заасан байна.

Австралийн газрын доорх усны эрх зүйн зохицуулалт

Өмнөд Австрали	Хойт бус нутаг	Баруун Австрали	Мужууд	ГДУ-ны эрхийн хуваарилалтын хэлбэр	ГДУ хуваари-лалтын эрэмбэтийн эсэх	ГДУ ашиглалтын зөв-шөөрөлтэй эсэх	Зөвшөөрлийн хугацаа	Хууль тогтоомж	Захиргааны байгууллага
	Тохиромжтой хэрэглээ	Тохиромжтой хэрэглээ	Тийм	Тийм	Тийм	Тийм	Хугацаагүй <sup>1</sup> (perpetuity)	Усны үйлчилгээний хууль, 2012 Усны агентлагийн тухай хууль, 1984	Баруун Австралийн засгийн газар, Усны хэлтэс
			Тийм	Тийм	Тийм	Тийм	Хугацаагүй (perpetuity)	Усны хууль, 2016	Хойт бус нутгийн засгийн газар, Усны хэлтэс
			Тийм	Тийм	Тийм	Тийм	Хугацаагүй (perpetuity)	Усны үйлдвэрлэлийн хууль, 2016	Өмнөд австралийн засгийн газар, Хүрээлэн буй орчин, усны хэлтэс

<sup>1</sup> Засгийн газар хяналт тавих бөгөөд ус ашиглах нөхцөл алдагдах тохиолдолд лицензийг цуцлах, өөрчлөх болно.

Квинсланд	Тохиромжтой хэрэглээ	Тийм	Тийм	Хугацаагүй (perpetuity)	Усны хууль, 2000	Засгийн газар, Байгалийн нөөц, эрчим хүч, уул уурхайн хэлтэс
Шинэ өмнөд Вэльс	Тохиромжтой хэрэглээ	Тийм	Тийм	Хугацаагүй (perpetuity)	Усны хууль, 2014 Усны менежментийн тухай хууль, 2000	Шинэ өмнөд Вэльсийн засгийн газар, Үйлдвэр аж ахуйн хэлтэс
Викториа	Тохиромжтой хэрэглээ	Тийм	Тийм	Хугацаагүй (perpetuity)	Усны хууль, 2010	Викториагийн засгийн газар, Хүрээлэн буй орчин, газар, усны

### Мужуудын Усны тухай хуулийн нийтлэг заалтууд

/Хэсэгчилсэн орчуулга/

**Усны нөөц гэдэгт:**

(a) гадаргын болон газрын доорх ус эсвэл

(b) гуу жалга, голдирол, нуур, намгархаг газар (устай болон усгүй);

Болон бүх төрлийн усны нөөцийг хамааруулна (организм болон экосистемд байх үнэт чанар бүхий усыг хэлнэ.).

**Газрын доорх ус гэдэг нь:**

(a) газрын доорх орших байгалийн ус (газрын доорх усны орд); эсвэл

(b) газрын доор зохиомлоор нөөцөлсөн, шингээсэн ус;

Боловч газар доорх байгууламж, усан сан, хоолой гэх мэтэд байх усыг хамаарахгүй.

**Хэтэрсэн хэрэглээ:** Хэрэв усны нөөцөөс тухайн цагт хэрэглээнд авч байгаа усны хэмжээ нь тэдгээр усны нөөцөөс авч болох хүрээлэн буй орчны тогтвортой түвшнээс (the environmentally sustainable level) илүү гарсан байвал хэтэрсэн хэрэглээ гэнэ.

**Мужийн усны менежментийн тухай хууль гэдэг нь:**

(a) the Water Management Act 2000, the Water Act 1912 and the Rivers and Foreshores Improvement Act 1948 – Шинэ өмнөд Вэльс;

(b) the Water Act 1989 болон the Catchment and Land Protection Act 1994-ийн Parts 4, 5 - Викториа

(c) the Water Act 2000 – Квинсланд

(d) the Natural Resources Management Act 2004 – Өмнөд Австрали

(e) the Water Resources Act 2007 – Австралийн нийслэлийн бүс нутаг

(f) Бусад сав газартай холбоотой хуулиуд:

(i) Сав газрын усны нөөцийн менежменттэй холбоотой хуулиуд

(ii) Устай холбоотой хуулиуд;

Болон дагалдах дүрэм, журам, зааврууд.

Усны менежментийн хууль 2000 – Шинэ өмнөд Вельс

Хуулийн ухагдахуун:

Энэ хууль нь мужийн одоогийн болон ирээдүйн хүмүүст ашиг тустайгаар усны нөөцийг зүй зохистойгоор нэгдсэн байдлаар зарцуулахад чиглэгдэнэ. Ялангуяа:

- Экологийн тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлах
- Усны нөөцийг сэргээх, хамгаалах, түүнтэй холбоотой эко системийг хамгаалах, усны чанарыг сайжруулах
- Усны нөөцийг зүй зохистойгоор ашиглан мужийн нийгмийн болон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах
- Усны нөөцийн менежменттэй холбоотой харилцааг ойлгож зохицуулах
- Усны нөөцийг эрэмбэтэй, үр ашигтай, хамтран ашиглах нөхцелийг бүрэлдүүлэх
- Бусад төрлийн тухайлбал байгаль орчны, ойн, амьтны, бэлчээрийн менежменттэй усны менежментийг уялдуулах
- Ус хэрэглэгчид болон засгийн газар хоорондын тогтвортой, үр ашигтай хэрэглээний хариуцлагыг дэмжих
- Усны хэрэглээнд шилдэг туршлагыг нэвтрүүлэх

Бүлэг 2: Усны менежментийн төлөвлөгөө

Хэсэг 1: Усны менежментийн үндсэн зарчмууд

Усны менежментийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална.

Еренхий зарчмууд

- Усны эх, үерийн татам, экосистем нь хамгаалагдсан, сэргээгдсэн байх ёстой.
- Уснаас хамааралтай ургамал, амьтны амьдрах орчин эсвэл менежментийн төлөвлөгөөнд өртөж байгаа зүйлс хамгаалагдсан, сэргээгдсэн байх ёстой.
- Бүх усны нөөцийн усны чанарыг хамгаалах ёстой.
- Усны менежмент, егөгдех зөвшөөрөл, аливаа үйл ажиллагааны хуримтлагдах нөлөөллийг аль болох бага байлгах, багасгах ёстой.
- Газарзүйн болон нутгийн уламжлалт зүйл хамгаалагдсан байх ёстой.
- Экосистемийн усны шаардлагыг ойлгож, хянах зориулалтаар дасан зохицох менежментийг ашиглах ёстой.

Усыг хуваалцах тухайд

- Усны нөөцөөс усыг хуваалцан ашиглагчид усны нөөцийг хамтран хамгаална.
- Усыг хуваалцаж байгаа хэрэглэгчид газрын өмчлөгчийн эрхийг хамгаална.

Усны хэрэглээтийг холбоотой

- Ус хэрэглээнээс улбаатай газрын доройтлоос сэргийлэх, газарт нелөөлөх нелөөллийг багасгах шаардлагатай.
- Ус хэрэглээ нь эдийн засгийн хувьд ашигтай байхаас гадна газрын бүтээмжтэй нийцэж байх хэрэгтэй.

- Ус хэрэглээ нь бусад ус хэрэглээнд нөлөөлөхгүй эсвэл бага нөлөөлж байх шаардлагатай.

#### Шүүрүүлийн менежменттэй холбоотой

- Шүүрүүлийн ажил нь газрын элэгдэл доройтол, усны нөөцийг бохирдуулахгүй байхаар төлөвлөгдөх ёстай.
- Шүүрүүлийн ажил нь бусад ус хэрэглэгчийн эрхийг зөрчихөөргүй, эсвэл нөлөөлөл нь бага байхаар төлөвлөгдсөн байна.

#### Үерийн татмын менежменттэй холбоотой

- Үерийн татмын менежмент нь газрын элэгдэл доройтол, усны нөөцийг бохирдуулахгүй, бохирдол нь бага байхаар төлөвлөгдөх ёстай.
- Үерээс хамгаалах ажлын нөлөөлөл нь бусад ус хэрэглэгчдэд бага эсвэл байхгүй байх ёстай.
- Үерийн татмыг эзэмшихээс үүдэлтэй хүний амьдралын одоогийн болон ирээдүйн эрсдэл бага байх ёстай.

#### Зарим хяналттай үйл ажиллагаатай холбоотой

##### Газрын доорх устай холбоотой

Хэсэг 2. 7. Усны эх үүсвэрийн ангилал Усны асуудал эрхэлдэг сайд энэ хуулийн зорилгод нийцэж байхаар усны эх үүсвэрүүдийг ангилж болно.

Үүнтэй холбоотой тушаал нь Хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн сайдын оролцоотойгоор гарч болно.

## НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Усны тухай хуульд нэмэлт оруулах төслийг боловсруулахдаа усны нөөцийг хамгаалах, хомсдол, бохирдоос сэргийлэх, зохистой ашиглах нөхцөл хяналтыг бүрдүүлэхийн тулд дараах холбогдох хуулиудын зүйл заалтыг судалж, нэмэлт оруулах шаардлагатай. Үүнд:

- Усны тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Эрүүгийн хууль
- Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль

Хоёр. Хууль батлагдсантай холбогдуулан дагалдан гарах Засгийн газрын тогтоол, холбогдох журмуудыг боловсруулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Орхигдож, хаягдсан цооногийг битүүмжлэх аргачлал
- Усны нөөцийн хомсдол, түүний түвшин, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох аргачлал

Гурав. Хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийн үйлчлэлд хамаарах хувь хүн, хуулийн этгээдүүдэд мэдлэг, мэдээллийг тухай бүр хүргэх, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын ажилтан, албан хаагч нарт сургалт, семинарыг зохион байгуулах нь зүйтэй.

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, АШИГТ МАЛТМАЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот 2019 он**

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, АШИГТ МАЛТМАЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээг Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд нь /цаашид “Хуулийн төслүүд” гэх/ Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу “Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл” хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслүүдийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлзээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ  
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

**Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, хуулийн төсөлд тусгагдсан

зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

**“Практикт хэрэгжих боломж”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд тэдгээрийг дагаж мөрдөх болон хэрэгжүүлэх этгээдэд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлэхээр сонгосон болно.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь бүхэлд нь Монгол Улсын Үндсэн Хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах замаар үнэлгээг хийхээр тооцоов.

## **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	<b>Зорилгод хүрэх байдал</b>	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшиүүлсэн зорилгыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	<b>Практикт хэрэгжих боломж</b>	Хуулийн төслийн 4 <sup>1.2</sup> дүгээр зүйл	Хуулийн төслийн сонгосон зүйлүүд практикт хэрэгжих боломжтой эсэхийг холбогдох хуулийн зохицуулалт хоорондын уялдаа, хэрэгжилтийн практик, мэргэжилтнүүдийн санал, дүгнэлтэд тулгуурлан дүн шинжилгээ хийнэ.
3	<b>Ойлгомжтой байдал</b>	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.

4	<b>Харилцан уялдаа</b>	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.
---	----------------------------	---	---

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

#### **“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Усны тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн зохицуулалтуудыг харьцуулан авч үзвэл.

<b>№</b>	<b>Усны тухай хууль</b>	<b>Усны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл</b>
1	<b>4 дүгээр зүйл.Усны нөөцийн нэгдсэн менежмент</b>	<p>Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4<sup>1</sup> дүгээр зүйл нэмэх:</p> <p><b>“4<sup>1</sup> дүгээр зүйл. Ус ашиглах эрхийн эрэмбэ</b></p> <p>4<sup>1</sup>.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрхийн эрэмбийг дараах байдлаар тогтооно. Эхний эрэмбийн усны хэрэгцээ бүрэн хангагдаагүй тохиолдолд дараагийн эрэмбэд ус хуваарилахгүй болно.</p> <p>4<sup>1</sup>.1.Хүн амын унд, ахуй; 4<sup>1</sup>.1.2.Хөдөө аж ахуй; 4<sup>1</sup>.1.3.Үйлдвэрлэл; 4<sup>1</sup>.1.4.Уул уурхай, баяжуулах үйлдвэр; 4<sup>1</sup>.1.5.Бусад.</p> <p>4<sup>1</sup>.2.Газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай болон үйлдвэрийн зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэхүү заалт хүнсний үйлдвэрлэлд хамаарахгүй болно.”</p>
2	<b>22 дугаар зүйл.Усны нөөцийг хамгаалах</b>	<p>Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дэх заалтаар хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.20 заалтуудыг нэмэх:</p> <p>“22.20 Цооног битүүмжлэх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”</p>
3	<b>25 дугаар зүйл.Ус бохирдуулсны</b>	Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтаар хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7 заалтыг

	<b>болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоох</b>	нэмэх: “25.7 Ус ашиглагч нь ус ашиглах боломжит нөөц болон гэрээнд заасан хэмжээг хэтрүүлснээс усны нөөц хомсдсон тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус хомсдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн гурав дахин нэмэгдүүлж тогтооно.”
4	<b>10 дугаар зүйл.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b>	Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтаар хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.31 заалт нэмэх: “10.1.31 Усны нөөцийн хомсдол, түүний тувшин, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох аргачлалыг батлах.”
5	<b>25 дугаар зүйл.Ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоох</b>	Төслийн 2 дугаар зүйлд Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь заалтын “25.2,” гэсний дараа “25.7” гэж нэмэх.
6	<b>4.9.Гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг усны сав газар /цаашид “сав газар” гэх/ бүрээр байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.</b>	Төслийн 2 дугаар зүйлд Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын “хязгаарыг” гэсний дараа “ус ашиглах эрхийн эрэмбийг баримтлан” гэж нэмэх.
<b>Ашигт малтмалын тухай хууль</b>		<b>Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</b>
7	<b>39.1.4.2 дугаар зүйл.</b>	Төслийн 1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.4.2 дахь заалтын “гүний” гэснийг “газрын доорх” гэж өөрчлөх.
<b>Эрүүгийн хууль</b>		<b>Эрүүгийн хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл</b>
8	<b>Хорин дөрөвдүгээр бүлэг.  Хүрээлэн байгаа</b>	Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй: 1/24.10 дугаар зүйл:  “24.10 дугаар зүйл.Усны нөөцөд хохирол

	<b>орчны эсрэг гэмт хэрэг</b>	<b>учруулах</b>
		<p>1.Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зэрчсөн, бусад санаатай эсхүл болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас усны нөөцийг хомсдуулсан эсхүл хомсдож болзошгүй нөхцөл байдал бий болгосон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”</p>

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Эрүүгийн хуулиудад нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилго нь усны нөөц хамгаалах, хомстлоос сэргийлэх, хариуцлагатай ашиглалт, хяналтыг сайжруулах, хүн амын унд, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэхэд оршиж байна.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 22.19, 22.20 заалтуудад орхигдсон цооногийг сум дүүргийн Засаг дарга нь улсын төсвийн хөрөнгөөр битүүмжлэх үүрэг хүлээж байгаа нь газар доорх усны бохирдлоос хамгаалах яаралтай арга хэмжээний нэг хэлбэр юм. Гэхдээ энэ нь буруутай этгээд үүргээс чөлөөлөгдж буй хэлбэр биш бөгөөд буруутай этгээд тогтоогдсон даруйд улсын төсөвт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг заавал гаргуулна холбогдох хариуцлагыг хүлээлгэнэ.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 4<sup>1</sup> дүгээр зүйлд ус ашиглах эрхийн эрэмбийг тогтоон өгч үүний тэргүүн ээлжинд Хүн амын унд, ахуйн хэрэглээг оруулж өгсөн нь Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.1-д “Усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ”, мөн Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030”-ын Зорилт 2 “Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэх зорилтуудыг хангахад оршино.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.4-д “Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална”, УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс экологийн талаар бодлогын 3.7.1-д “Монгол орны

газрын дээрх ба доорх усны нөөц нь байгаль болон амьдралын эрүүл орчны шүтэлцээг хангагч үндсэн эх үүсвэр хэмээн үзэж усны нөөц, чанарыг хадгалан гамтай ашиглаж, нөхөн сэргэх, арвижих боломжийг хангах нь төрийн бодлогын зангилаа асуудал мөн" гэж тус тус заасан нь Монгол Улсын усны нөөцийг хамгаалах, хомстлоос сэргийлэх, хүн амын ундны ус хангамжийг нэмэгдүүлэх, ус ашиглагчийн хариуцлага, хяналтыг сайжруулах бодлогыг баримталж байна.Үүнтэй холбоотойгоор Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 4<sup>1</sup>.2 дахь заалтыг оруулсан болно.

Өнөөг хүртэл Монгол Улсад усны нөөцийн хомстол болон түүний түвшинг тогтоох нэгдсэн аргачлал байхгүйн улмаас аж ахуйн нэгжүүдийн усны нөөцийн хавтгайрсан хэрэглээ бий болж үүнд улсаас тохирсон хариуцлагын хүлээлгэж чадахгүй байна. Иймд усны хомстлоос сэргийлэх, оновчтой хариуцлагын механизм бий болгохын тулд Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 10.1.31, 25.7 заалтуудыг тус тус нэмэлтээр оруулсан болно.

Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Эрүүгийн хуульд ус ашиглагч нь усны нөөцийг хомстуулсан тохиолдолд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх механизмыг оруулсан болно.

Ашигт малтмалын тухай хуульд гүний ус гэж орсон ойлголтын зөрүүг засаж, Усны тухай хуульд заасан газрын доорх ус гэсэн нэр томьёог оруулна. Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бий болгоно.

#### **"Практик хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Монгол Улсын хэмжээнд газрын доорх усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь байгалийн бус, бүслүүр, ус агуулах чулуулгийн тогтоц, найрлагаас хамаарч өөр өөр байна. Гадаргын усны нөөцийн 70% нь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт нийт нутаг дэвсгэрийн 30% орчим эзлэх талбайд бүрдэнэ. Манай улсын нийт ус ашиглалт, хэрэглээ жилдээ 500 сая.м3 орчим байгаа ба хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдан жилээс жилд нэмэгдэж байна.

Сүүлийн 40 жилийн судалгаагаар Монгол орны усны нийт нөөц олон жилийн дунджаар жилд 608,300.0 сая.м3 (мөнх цас, мөсөн голын усны нөөц буурснаас 564,800.0 сая.м3 болсон), үүний 34,600.0 сая.м3 гол, мөрний, 500,000.0 сая.м3 нуурын, 62,900.0 сая.м3 (19,400.0 сая.м3 болж буурсан) мөнх цас, мөсөн голын, 10.800 сая.м3 газрын доорх ус байна.

Судлаач доктор Р.Баттөмөрийн 2010 онд нэгтгэсэн мэдээгээр Өмнөговь, Дорнговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын нутаг дэвсгэрт нарийвчилсан хайгуулаар 140.4 мянган м3/хоног, урьдчилсан хайгуулаар 343.1 мянган м3/хоног, нийтдээ 483.5 мянган м3/хоног усны нөөцтэй 53 орд, үүнээс 38 орд буюу 43.2 хувь нь цэнгэг устай..."гэжээ.

Монгол Улсын усны хэрэглээний 80 орчим хувийг нийт нөөцийн 1.9 хувь болох газрын доорх усаар хангаж байгаа бөгөөд газрын доорх усыг ашиглах,

хамгаалах харилцааг зохицуулсан хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичиг хангалтгүй байна. Иймд Монгол Улсын газрын доорх усны хэрэглээг багасгаж гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэх болон хосолмол байдлаар ашиглах практикийг нэвтрүүлэх бүрэн боломжтой байна.

Монгол улсын уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд ихэвчлэн газрын доорх болон гадаргын усны нөөц багатай.govийн бүсэд олборлолт хийж байна. Эдгээрийн ашигладаг ус нь ихэвчлэн цэнгэг ус байдаг учир тухайн бүсийн хүн амын унд, ахуйн усны нөөцийг хомстолд хүргэх аюул нүүрлэж байна. Энэхүү ус ашиглалтыг хязгаарлах, хориглох нь ирээдүйн Монгол Улсын хүн амын ундны усны нөөцийг хамгаалах нь стратегийн ач холбогдолтой юм.

Уул уурхайн салбар нь манай улсын хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой нь маргаангүй үнэн. Иймд дээрх газрын доорх усыг хязгаарлах, хориглохтой холбоотой асуудлыг хангайн гол мөрний усыг хуримтлуулах замаар урсац тохируулгын усан сан бий болгож говь, хээрийн бүсэд шилжүүлэн газрын доорх усыг хэмнэх, гадаргын усыг хосолмолоор ашиглах замаар шийдвэрлэж болох юм.

#### **“Ойлгомжтой” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</b>	<b>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</b>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад	Шаардлагад нийцсэн

удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагад нийцсэн
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагад нийцсэн
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлагад нийцсэн
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлагад нийцсэн
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцуулэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлагад нийцсэн
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлагад нийцсэн
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлагад нийцсэн

### “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

№	Асуулт	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгodoо нийцсэн
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Нийцсэн
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай	Давхардаагүй

	давхардсан эсэх;	
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тусгасан
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Орхигдуулаагүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Тусгаагүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Энэ асуудлыг тусгах шаардлагагүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тусгаагүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Ийм зохицуулалт шаардлагагүй

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү үнэлгээг Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн үр нэлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нэлөө тооцох аргачлал”-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Энэхүү үнэлгээг Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд нь сонгосон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томьёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот 2019 он**

## **УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр ямар ч нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалтад нийцуулэн Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу дараах байдлаар тогтоолоо.

Үүнд:

**1. Хуулийн этгээдийн зардал**

Хуулийн төслөөр газрын доорх цэнгэг усны ордыг үйлдвэрлэл болон уул уурхайн зориулалтаар ашиглахыг хориглох тул эдгээр зориулалтаар цэнгэг усны орд ашигладаг аж ахуйн нэгж усны өөр эх үүсвэр хайх, илрүүлэхэд зардал гарна. Энэхүү зардлын нарийвчилсан тооцоог тусгайлан гаргана.

**2. Иргэний зардал**

Хуулийн төслөөр иргэний хувьд нэмж гүйцэтгэх үүрэг үүсэхгүй тул холбогdon гарах зардал байхгүй болно.

**3. Төрийн байгууллагын хувьд**

Хуулийн төслөөр төрийн байгууллагын хувьд сум, дүүргийн засаг дарга орхигдсон цооногийг улсын төсвийн хөрөнгөөр битүүмжлэх үүрэгтэй болно. Энэхүү төсөв нь орон нутгийн байршил, эдийн засгийн онцлог зэргээс хамаарах тул гарах зардлын нарийвчилсан тооцоог тусгайлан гаргана.

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот 2019 он**

## УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн мэдээллийг 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр өөрийн пэйж хуудас болох <https://www.facebook.com/IloveUmnugobi/>, болон өөрийн цахим орон зайд болох <https://www.facebook.com/lu.enkhbold> хуудсанд байршуулан, олон нийтэд мэдээлж, санал авах ажлыг зохион байгуулсан.

Энэ хугацаанд хуулийн төсөлтэй нийт 1424 иргэн танилцаж, 127 иргэн дэмжиж буйгаа илэрхийлсэн. Уг хуулийн төсөлтэй холбоотойгоор 15 иргэн санал, сэтгэгдэл бичиж хуулийн төслийг 100% дэмжсэн байна.



## Reach

Total People Reached

1,424

Total R

Rea

1,424  
Organic

0  
Paid

**Ganhuugijn Amarbayar** Оюутолгоёй Говийнгүйн цэнэгүүсны мөрчөөс яг одоогийн байдлаар 1секундад 873лitr ус 1минутанд 52320 лitr ус 1цагт 3 142 800 лitr ус ашигтай байна. Худэр угсах үйлдвэртэй 360 гаруй гүйцэн хөтөлбөрийн цонхшор гүйн болоод газарын усын татан ашигтай байгаа нь алж хадийнээс усны хөхцөн гамшигийн хэмжээнд хүргэсэн гэж бодсог. Дэлдэг үргэлжлэлийн өрөв 1секундад 1461 литр ус ашигтай тооцоо байгаа. Урсацан үлэг ажиллагаа бүр хүчин чадвараас ашиглагч юу бол энд төө нийзгэжсандаа гэхэг тооцоос байдал юу бичье.

Шинэгээс алжигас сонгодсон УИХ-ын гишүүд, Адмигинд үзүүлдэгээгүй, төвлөгөө нутгийн иргэд мэшигээхэд кийвэдэг. Одоогийн дагавараа давааныг ялангуяа хөтөл болсон чиглэлээ нутгийн олонд

**Sukhbaatar Salkhaa** Sain bing amjilt hush er ni manai govid dahij buu uul ushail neegeses hemneglei orduig astigquljuljul bologhul i gel boddog saaral us eh ornoch bus gel muran uyiran usnii huriitmal tsarigq ashigla beiges urinheig bol demej ejlajj bolljin govi nutnig gunii tsaver user baylagas ugajjal hair gamqul hereglej beiges uruutaihing bid bron nutag gadaad dotood gelgij haash huretel arga hemjees avah hereglei shuu geheuumee amjilt hushly

Zoijargal Jamiyansherz "Хүнд бүрж болье газалт эрдэм сурга. Газарт бүрж болье газалт ус тогтоо" гадарж уг байдаг. Эх, Орхон, Хэрээн. Онон гэсэн 4 гол гадаргын усны нэхэн сэргээлт хамгийн ихэй, сан байгуулж хүрээлдээгээ талбайтай. Энэ толготад хэрээн шар усны үер зуны борооны илүүдээд усны хадгалах санчугуд байгуулах эрхтэй санагдаг юм. Энэ нь Монголын хөгжлийн 1 том эх үүссээр болно. Орчинд нь ялангу ягуулчлан үйлдвэрлэлт хөгжүүлийг болжаа. Дээжээж байна.

Like Reply See Translation 2w Edited

**Nerenbayr Mönkhimed** Orkhon golos shuuuduu tataj tarialand ashiglaaj been vidergdel bidag. Odoo ch shuuuduuagar tataad ashigdag. Manalnii hamglin air hilgeed bolomjtoi go! Orkhon gol. Shuuuduu, suwag tataj Ongin golosu urseltseg ni nemegdүүбээl Ulaan nuurtsaagad bolch 1 yum shig sanagddag

Like Reply 2w

**Batbayar Zorigmyadar** Тоонуудаа нягтлахар Суурь болсон төв чинь буруу бол ямар ч сайнсан сангаа цаашаа явлагч бас дээр нь ийн сайнгаа сангааг зөвөвслүү хүүл болгож яхь нь вэ? Сайн тооцоо, сайн судалгаа сайн нэрэгжүүлжнүүгээр хөгжүүлж шиг Ажлын хүснэгт

Like Reply See Translation 2w

Дойрголын Yondonjimjinta Чухал хууль байна дээ. Ажлын тусын Байгаль орчин экологийн тэнцвэрт байдлыг хадгалан авч үлдэнэ газэг үр хөхцөдөө вэлүүлэх маш их баялаг юу

Like Reply See Translation 2w

**Bazarrugveldii Amarjavargal** Өдөр аргацаасан хуулиудыг бодвал алж хэтээ хэрсан чухал хууль

Like Reply See Translation 2w

**Benzirach Bayartsetseg** Үс хуван байна тэнд вындрэн Мэш чухал сээдээ зөндөвдэж байгаад баарлах байна. Яг Гашуунсүхийн орчмын усны хангамж ариутгах татуурга ирэздүүн точи суурьшын дээр ямар судалгаа шинжилгээний ажлыг хийгдэж байгаа вэ?

Like Reply See Translation 2w

**Чултэм Bayjavjavgal** Үс байнаа гадалшаа урсана Урсацан байнаа гаднээн уханаа

Like Reply See Translation 2w

**Batsuhan Salhona** oyu tolgoig gvnii us eshligletüg bolch heregtei

Like Reply 2w

**Ganboldi Tomor Mongolian** buh gol gadagshaa ursdag us amin erdene

Like Reply 2w

**Dendev Davsalam** Хэрээн говь. Орхин говь төслийг яаралтай хэрэгжүүлжээ хэрэгтэй. Гүний усны үнэлгээгээ нээж

Like Reply See Translation 2w

**Zoijargal Jamiyansherz** "Хүнд бүрж болье газалт эрдэм сурга. Газарт бүрж болье газалт ус тогтоо" гадарж уг байдаг. Эх, Орхон, Хэрээн. Онон гэсэн 3 гол гадаргын усны нэхэн сэргээлт хамгийн ихэй, сан байгуулж хүрээлдээгээ талбайтай. Энэ голуудад хэрээн шар усны үер, зуны борооны илүүдээд усны хадгалах санчугуд байгуулах эрхтэй санагдаг юм. Энэ нь Монголын хөгжлийн 1 том эх үүссээр болно. Орчинд нь ялангу ягуулчлан үйлдвэрлэлт хөгжүүлийг болжаа. Дээжээж байна.

Like Reply See Translation 2w Edited

**Usgui bol hichinneen nuurstei beiagaad yahin**  
Usgui bol ur holchdooyu heij zogsnom..

Like Reply 2w

**Mijiddorj Orojjav** Еле sanal sanaachlaglig demejj balna. Manal uls suudal 29 jil usni bodlogoguljuyavjitee. Socialist nigmisi ued usnii bodlogin yamtai usni erdem shingilaanli hureelentel, alma, hot bur usnii barlige ugsrultin kontoruudtai, hun, malin usan hangamjig saignuu balshuu mongoliid arl lumen martseguu harin tur, zasag ni martsan balgeea shuu deell!

Like Reply 2w

**Otgontsogolag Tumgas** Хууль батлагдан гарах болтугай ажлын индер ажилж хүснэгт

Like Reply See Translation 2w

**Санал ирүүлсэн иргэдийн хувьд хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан авч үлдэн, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээхийн чухлыг онцолж байв.**

**Зарим иргэд Монгол улсад нэн тэргүүнд тавигдах асуудал мөн болохыг чухалчилахын зэрэгцээ энэ асуудлыг одоо шийдвэрлэхгүй бол бид харамсаад ч хүрч болзошгүйг анхааруулсан.**

**Мөн орон нутгийн иргэдтэй уулзаж ярилцан тэдний санал сэтгэгдлийг сонсож байхад иргэдийн зүгээс "Ус үгүй бол амьдрал үгүй" хэмээн онцолж нутаг усаа хайрлах, ирээдүй хойч үеэдээ зориулан үржил шимтэй, уух устай газар нутгийг хадгалан авч үлдэх үүрэг энэ цагт бидэнд оногдож буйг сануулан амжилт хүсээд энэ хуулийн төслийг дэмжиж буйгаа илэрхийлж байлаа.**